



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/337

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гар угаах, халдваргүйжүүлэх заавар”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар”-ыг гуравдугаар, “Оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх дуран, түүний дагалдах хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар”-ыг дөрөвдүгээр, “Нүүр амны тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын заавар”-ыг тавдугаар, “Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар”-ыг зургаадугаар, “Хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар”-ыг долоодугаар, “Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах, халдваргүйжүүлэх заавар”-ыг наймдугаар, “Тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээний заавар”-ыг есдүгээр, “Сэрэмжлүүлэх нөхцөл, бичил биетний жагсаалт”-ыг аравдугаар, “Халдварын сэргийлэлт, хяналтад бичил амь судлалын лабораторийн гүйцэтгэх үүрэг”-ийг арваннэгдүгээр, “Уламжлалт эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын заавар”-ыг арванхоёрдугаар, “Тарилгын аюулгүй байдлын заавар”-ыг арвангуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Зааврын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулж, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Заавар батлах тухай” 2014 оны 187 тоот тушаал, “Заавар батлах тухай” 2018 оны А/288 тоот тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

082057



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны ...11... сарын ...29-ны  
өдрийн ...41537 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ГАР УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ ЗААВАР

### Нэг. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1.1. Гарын эрүүл ахуй сахилт нь халдвараас сэргийлэхэд хамгийн чухал бөгөөд энгийн арга тул энэхүү зааврыг эрүүл мэндийн байгууллагын ажилтан, дадлагажигч эмч, окутан, үйлчлүүлэгч түүний асран хамгаалагчид дагаж мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, шингэн саван, гар арчих зориулалтын нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

1.3. Мэс засал, төрөх, нярай, тарианы зэрэг ажилбар хийгдэх өрөөний гарын угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй байна.

1.4. Төвлөрсөн усан хангамжгүй газарт гоожуурт угаалтуурыг ашиглаж болно. Ус нөөцлөх сав нь цэвэр, ус бохирдохоос сэргийлсэн тагтай байна.

1.5. Гарын угаалтуур нь ажилбарын цэг, цэвэр хэсгээс 1 метрээс багагүй зайд байна. Гар угаах явцад ус цацагдах нь эмнэлгийн орчинд бичил биетний тархалтыг нэмэгдүүлдэг тул тосгуур хэт жижиг биш, гүн байна. Угаалтуурын цоргоноос тосгуурын гүн хүртэлх зай 26 см-ээс ихгүй байна.

1.6. Угаалтуурын арын ханын хэсэг ус нэвтрэхгүй, цэвэрлэх боломжтой материалаар хийгдсэн байна.

1.7. Гарыг ундны усны стандартын шаардлага хангасан, бүлээн усаар угаана.

1.8. Угаалтуур бүрт гарын шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур, хогийн савыг байршуулна.

1.9. Эрүүл мэндийн байгууллагад спиртийн агууламж нь 70-80 хувь, арьсыг хуурайшуулахаас сэргийлсэн зөөлрүүлэгч бодистой, эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэл, зөвшөөрөлтэй гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэнэ.

1.10. Гар халдваргүйжүүлэх бодисыг тусламж үйлчилгээний цэг бүрт, халдварын эрсдэл өндөртэй тасаг нэгжийн үүдэнд, үйлчлүүлэгчийн орны дэргэд хэрэглэхэд ойр байрлуулна.

1.11. Гар угаах дараалал, санамж, анхааруулга бүхий зурагт хуудсыг гарын угаалтуур болон тусламж үйлчилгээний цэгүүдэд байрлуулсан байна.

1.12. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй тасаг, нэгжүүдэд давтан арчдаг даавуун алчуур, гар хатаагч сэнсийг ашиглахгүй.

1.13. Эрүүл мэндийн ажилтан жилд 1-ээс доошгүй удаа гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг баталгаажуулах сургалтанд хамрагдана.

1.14. Гар халдваргүйжүүлэх бодис арьсыг хэт хуурайшуулах, харшил өгч байгаа нь тогтоогдвол бодисыг солих арга хэмжээ авна.

1.15. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал, гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээнд улирал тутам, эрүүл мэндийн ажилтны мэдлэг, дадал, гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

### **Хоёр. Эрүүл мэндийн ажилтны үүрэг**

2.1. Эрүүл мэндийн ажилтан гарын эрүүл ахуй сахих 5 заалтыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

2.1.1. Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө,

2.1.2. Үйлчлүүлэгчид хүрсний дараа,

2.1.3. Ариун ажилбар гүйцэтгэхийн өмнө,

2.1.4. Биологийн шингэнд хүрсний дараа

2.1.5. Үйлчлүүлэгчийн эргэн тойрон, орчны эд зүйлст хүрсний дараа гарын эрүүл ахуйг сахина.

2.2. Гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг зөв эзэмшинэ.

2.3. Гар угааж, халдваргүйжүүлсний дараа орчны гадаргуу, хийх ажилбараас бусад зүйлд хүрч гараа бохирдуулахаас сэргийлнэ.

2.4. Дараах тохиолдолд эрүүл мэндийн ажилтан **ус, шингэн саван ашиглан** гар угаана.

2.4.1. Нүдэнд харагдахуйц бохир;

2.4.2. Биологийн шингэнээр бохирлогдсон;

2.4.3. Бээлий тайлсны дараа;

2.4.4. Норовирус, ротавирус, гепатитийн А вирус зэрэг бүрхүүлгүй вирус болон *C.difficile*, спортой бактерийн халдварын сэжигтэй болон батлагдсан үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх.

2.5. Бусад тохиолдолд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ. Гар угаасны дараа спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодис ашиглаж болно.

2.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтны гарын хумс 0.2см–ээс урт биш, будаггүй, хиймэл хумсгүй, бөгж, бугуйвч, бугуйн цаггүй байна.

2.7. Гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн арьсыг хэт хуурайшуулах, харшил өгч байгаа тохиолдолд тасаг нэгжийн эрхлэгч, тархвар судлаач, халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан, алба, багт мэдэгдэнэ.

2.8. Шингэн саван, цаасан алчуур байхгүй, угаалтуур эвдэрсэн зэрэг гар угаах нөхцөл хангагдаагүй бол байгууллагын санхүү, аж ахуйн албанд мэдэгдэнэ.

### **Гурав. Гар угаах, халдваргүйжүүлэх арга**

3.1. Ус саван ашиглаж угаахдаа гараа норгосны дараа шингэн саванг хангалттай хэмжээгээр авна. Гар халдваргүйжүүлэхдээ спиртэн суурьтай бодисоос алганы хонхорыг дүүртэл буюу 3 мл орчмыг авна.

3.2. Саван, ус ашиглаж угаах болон гар халдваргүйжүүлэхдээ дараах үйлдлүүдийг бүрэн гүйцэтгэнэ.

- Саван болон халдваргүйжүүлэх бодисыг гарын гадаргууд жигд тараана;
- 2 гарын алга болон хурууны завсар хооронд үрэх;
- Нэг гарын алгаар нөгөө гарын ар талыг үрэх;
- Хурууг үеэр нугалж нөгөө гарын алган дотор хурууны үзүүр, хумс, үений хэсгийг үрэх;
- Алганы хонхорыг нөгөө гарын хурууны үзүүр хэсэгтэй хооронд нь үрэх;
- Эрхий хурууг нөгөө гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр үрэх;
- Гарын бугуй үрэх.

3.3. Гар угаах хугацаа 1 минут, халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс багагүй байна.

3.4. Гараа угаасны дараа усаар зайлж саванг арилгаад нэг удаагийн цаасан алчуураар арчина. Угаагуурын ус гар оролцож хаагддаг бол крантыг цаасан алчуураар жийрэглэж хаана.

3.5. Шингэн саван, гар халдваргүйжүүлэх бодисыг дууссаны дараа савыг сайтар цэвэрлэж, хатаана. Дуусаагүй байхад нэмж хийхийг хориглоно.

3.6. Гар нойтон байхад спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэхгүй.

3.7. Гар халдваргүйжүүлэх бодисыг ашиглаж эхлэхдээ нээсэн огноо, савалж хэрэглэдэг бол дахин савласан огноог тэмдэглэнэ.

3.8. Хэрэглээний явцад спиртын агууламжийг тодорхойлж, шаардлага хангаж буй эсэхэд эм зүйч, эм найруулагч дотоодын хяналт тавина.

### **Дөрөв. Мэс ажилбарын үеийн гар угаах, халдваргүйжүүлэлт:**

4.1. Мэс заслын өрөөний угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн байна. Тосгуур нь тохой хүртэл гар угаахад шүргэхээргүй, ус цацагдахааргүй том хэмжээтэй байна. Угаалтуурын ханын хэсэг нь ус нэвтэрдэггүй, цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна.

4.2. Гар угаах хөөсрүүлэгч материал, саван, ариун алчуур, халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

4.3. Гар угаах, халдваргүйжүүлэх бодис нь мэс заслын гар угаалтад зориулагдсан байна.

4.4. Гар угаах усны хэм, урсгалыг тохируулан тохойноос урагш хэсгийг сайтар норгосны дараа нэг удаагийн хэрэглээний губка ашиглан гарын алга, ар тал, хуруунуудын завсар, хумс, бугуйнаас тохой хүртэл сайтар үрж 5-аас багагүй минутын турш угаана.

4.5. Цэвэр усаар булхуулж саванг бүрэн гүйцэт арилгасны дараа арчиж хатаана.

### **Тав. Хяналт, үнэлгээ**

5.1. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах, халдваргүйжүүлэх зааврын хэрэгжилтэд хавсралт дахь үнэлгээ хийх загвар хуудасын дагуу дотоодын хяналт, үнэлгээ хийнэ. Үүнд:

5.1.1. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдалд жилд 2-оос доошгүй удаа;

5.1.2. Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг бүх ажилтныг хамруулан жилд 1-ээс доошгүй удаа;

5.1.3. Гарын эрүүл ахуйг сайжруулах талаар байгууллагын үйл ажиллагааг жил тутам;

5.1.4. Гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцон ажилладаг эрүүл мэндийн ажилтанг хамруулан жилд 1-ээс доошгүй удаа;

5.1.5. Гар халдваргүйжүүлэх спиртэнд суурилсан бодисын хэрэглээний байдлыг улиралд 1-ээс доошгүй удаа тус тус үнэлнэ.

5.2. Хяналт, үнэлгээг сургалтанд хамрагдсан, дадлага, туршлагатай мэргэжилтэн хийж, үнэлгээний дүнг эргэн мэдээлдэг байна.

5.3. Үнэлгээний дүнгийн дагуу үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

## Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдлыг үнэлэх загвар хуудас

Огноо:

Тасаг, өрөөний нэр: .....

Үнэлгээ хийсэн хүний нэр:

Бүх асуултанд хариулж **Тийм, Үгүй** тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Хэвийн ажиллагаатай (эвдрэл гэмтэлгүй) угаалтууртай эсэх			
2	Угаалтуур нь хөл, тохойгоор ажиллах боломжтой эсэх эсвэл мэдрэгчтэй эсэх			
3	Угаалтуурын дэргэд шингэн савантай эсэх			
4	Угаалтуурын дэргэд зориулалтын цаасан алчууртай эсэх			
5	Гар угаах ус нь цэвэр эсэх			
6	Шингэн савангийн сав нь цэвэр эсэх			
7	Угаалтуур цэвэр, угаалтуур дотор ямар нэгэн багаж хэрэгсэл хийгээгүй байх			
8	ЭМА гартаа бөгж, бугуйвч, бугуйн цаг зэрэг гоёл чимэглэлгүй, хумс ургуулаагүй, хумс будаггүй, хиймэл хумсгүй байх			
9	Гар угаах санамж бүхий зурагт хуудастай эсэх			
10	Тусламж, үйлчилгээний цэг бүрт гар халдваргүйжүүлэх бодистой байх			
11	Гар халдваргүйжүүлэх бодисын спиртын агууламж 70-80 хувь байх			
12	Гар халдваргүйжүүлэх бодис нь тунлагч, шахуурга бүхий зориулалтын савтай байх			
13	Гар халдваргүйжүүлэх бодисын сав цэвэр эсэх			
14	Гар халдваргүйжүүлэх бодисыг ашиглаж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн эсэх			

**Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг үнэлэх  
загвар хуудас**

Огноо:

Үнэлгээнд хамрагдсан ажилтны нэр: .....

Үнэлгээ хийсэн хүний нэр: .....

Бүх асуултанд хариулж **Тийм, Үгүй** тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Гарын эрүүл ахуй сахих 5 мөчийг нэрлэж чадаж байна уу			
2	Гар угаах, халдваргүйжүүлэх үйлдлийг шалгах			
2.1.	Гар халдваргүйжүүлэх бодис эсвэл шингэн саванг гарт бүрэн тараах			
2.2	Гарын алга, хуруу хооронд үрж угаах			
2.3	Хоёр гарын ар талыг үрж угаах			
2.4	Хоёр гарын хурууг үеэр нугалж алга дотроо үрж угаах			
2.5	Алганы хонхорыг нөгөө гарын хурууны өндгөөр үрж угаах			
2.6	Эрхий хурууг алга дотор үрж угаах			
2.7	Бугуй угаах			
3	Гараа цэвэр усаар саванг арилтал зайлсан			
4	Угаасан гараа крантад хүргэлгүйгээр усаа хаасан			
5	Нэг удаагийн цаасан алчуураар арчиж хатаасан.			
6	Гар угаахад угаалтуурын тосгуурт гар хүрэлцээгүй			
7	Гар халдваргүйжүүлсний дараа бодис бүрэн шингэсэн			
8	Гар угаахад 1 минутаас багагүй хугацаа зарцуулсан			
9	Гар халдваргүйжүүлэхэд 20-30 секунд зарцуулсан			

## Гарын эрүүл ахуйг сайжруулах талаар байгууллагын үйл ажиллагааг үнэлэх загвар хуудас

Огноо:

Үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн нэр: .....

Үнэлгээ хийсэн хүний нэр: .....

Бүх асуултанд хариулж **Тийм, Үгүй** тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Төвлөрсөн усан хангамжтай эсэх			
2	Угаалтуур орны харьцаа. Тасгуудад хамгийн багадаа 1:10; Тусгаарлах өрөө болон сэхээн амьдруулах өрөөнд 1:1 байх			
3	Байгууллагын төлөвлөгөөнд гарын эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа тусгасан			
4	Хэрэгцээг тооцож төсөвт тусгасан эсэх			
5	Гарын эрүүл ахуйн сургалт хийх сургагдсан мэргэжилтэн байгаа эсэх			
6	Бүх ажилтанг гарын ахуйн сургалтад хамруулж баталгаажуулсан эсэх			
7	Шинэ ажилтанд мэдлэг, дадал олгох сургалт хийдэг эсэх			
8	Гарын эрүүл ахуй сахих ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцож байгаа ажилтанг бүрэн хамруулсан (хамгийн багадаа жилд 1 удаа)			
9	Ажиглалтын үнэлгээ хийдэг ажиглагч сургалтад хамрагдсан эсэх			
10	Ажиглалтын үнэлгээний үр дүнг эргэн мэдээлдэг эсэх			
11	Гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээг хянадаг эсэх (Хамгийн багадаа 3 сар тутамд)			
12	Гарын савангын хэрэглээг хянадаг эсэх (Хамгийн багадаа 3 сар тутамд)			
13	Эмнэлгийн ажилтны гарын эрүүл ахуй сахилтын түвшинг тогтоосон байх			
14	Гарын эрүүл ахуй сахилтын түвшин 70% - иас багагүй байх			
15	Гарын эрүүл ахуй сахих дэлхий нийтийн (5 сарын 5) өдрийг тэмдэглэн ажил зохион байгуулдаг уу ?			



ГАРЫН АРИУН ЦЭВРИЙН САХИЛТЫГ ҮНЭЛЭХ  
АЖИГЛАГЧИЙН МАЯГТ

Эмнэлэг.....

Ажиглагч (эхний үсэг)	□□□	Үе шат №	□□□	Тасал/хэлтэс	□□□□□□□□
Огноо (ө,с,о)	□□ □□ □□ □□	Бүлэг ажиглалт №	□□□	Үйлчилгээ	□□□□□□□□
Эхлэх/дуусах (ц,м)	□□ □□ □□ □□	Маягт №	□□□	Тасал/өрөө	□□□□□□□□
Бүлэг ажиглалтын хугацаа (мин)	□□				

Мэргэжил □□□□□□  
Код □□□  
№ □□□□□□

Мэргэжил □□□□□□  
Код □□□  
№ □□□□□□

Мэргэжил □□□□□□  
Код □□□  
№ □□□□□□

Мэргэжил □□□□□□  
Код □□□  
№ □□□□□□

Бо	Заалт	Үйлдэл
1	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
1	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
1	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
1	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
2	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
2	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
2	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
2	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
3	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
3	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
3	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
3	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
4	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
4	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
4	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
4	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
5	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
5	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
5	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
5	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
6	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
6	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
6	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
6	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
7	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
7	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
7	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

Бо	Заалт	Үйлдэл
7	<input type="checkbox"/> өвч өм	
	<input type="checkbox"/> ар өм	<input type="checkbox"/> үр
	<input type="checkbox"/> шинда	<input type="checkbox"/> уг
	<input type="checkbox"/> өвч да	<input type="checkbox"/> үгүй
	<input type="checkbox"/> орчда	

## Гарын ариун цэврийн сахилтыг үнэлэх ажиглагчийн маягтын тайлбар

1. Ажиглалтын маягтын ажиглалт тэмдэглэх хэсгийг дараах байдлаар ойлгоно.

Бо (Боломж)	Заалт (Гарын эрүүл ахуй сахих заалт)	Үйлдэл (Гүйцэтгэл)
1	<input type="checkbox"/> өвч.өм (Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө) <input type="checkbox"/> ар.өм (Ариун ажилбарын өмнө) <input type="checkbox"/> шин.да (Биеийн шингэнтэй хүрсний дараа) <input type="checkbox"/> өвч.да (Үйлчлүүлэгчид хүрсний дараа) <input type="checkbox"/> орч.да (Орчны эд зүйлд хүрсний дараа)	<input type="checkbox"/> үр(ССГХБ-р халдваргүйжүүлсэн) <input type="checkbox"/> уг (Гараа угаасан) О Үгүй (Гарын эрүүл ахуй сахих ямар ч үйлдэл хийгээгүй)

2. **Боломж** - Гарын эрүүл ахуй сахих заалт гарч байна гэсэн үг. Боломж бүр үйлдэлтэй зохицож байх ёстой. Ажиглалтын явцад нэг дор гарын эрүүл ахуй сахих хэд хэдэн заалт гарч болно. Боломж нь гарын эрүүл ахуй сахих хэрэгцээ байгааг тодорхойлно. Заалт нэг эсвэл олон байхаас үл хамаарна.

3. **Заалт** – Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуй сахих 5 заалт. Жишээлбэл: Таны ажиглаж байгаа сувилагч үйлчлүүлэгчийн биеийн шингэнд хүрсэн бол гарын ариун цэвэр сахих заалт гарч байна гэж ойлгон “шин.да “гэсэн хэсэгт тэмдэглэгээ хийнэ. Сувилагч биеийн шингэнд хүрсний дараа гараа савандаж угаасан бол үйлдэл гэсэн хэсгийн “ уг” гэсэн хэсэгт тэмдэглэнэ. Гар угаах үйлдэл хийгээгүй эсвэл спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэгч ашигласан бол буруу үйлдэл (биеийн шингэнд хүрсэн бол гар савандаж угаана) гэж үзэн “О Үгүй” гэсэн хэсэгт тэмдэглэгээ хийнэ.

4. Нэг хүснэгтэд нэг үйлдлийг тэмдэглэнэ. Таны ажиглаж байгаа сувилагч дараагийн үйлчлүүлэгчид тариа хийх болоход гарын эрүүл ахуй сахих боломж дахин гарч байна гэж ойлгон дараагийн хүснэгтэд шилжиж тэмдэглэгээг дээрхийн адил хийнэ.

5. Гарын эрүүл ахуй сахисан үйлдэл болон боломжийн хоорондын харьцаагаар эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуй сахих түвшинг тодорхойлно. Жишээлбэл: Сувилагчийг 30 минут ажиглахад түүнд гарын эрүүл ахуй сахих 18 боломж гарсан, үүнээс гар угаах, халдваргүйжүүлэх зөв үйлдэл 7 хийсэн гэж үзвэл тухайн сувилагчийн гарын эрүүл ахуй сахих түвшин 38,8% байна гэж үзнэ.

6. Гарын эрүүл ахуй сахих түвшинг мэргэжлийн төрлөөр, заалт тус бүрээр тооцоолж бас болно.

7. Заалт бүрээр гаргасан гарын эрүүл ахуй сахих түвшингийн ач холбогдол нь эрүүл мэндийн ажилтны мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход тусална.

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 1/537 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

## ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ, ХЭРЭГСЛИЙГ ЦЭВЭРЛЭХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, АРИУТГАХ ЗААВАР

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйлчлүүлэгчийн гэмтсэн болон гэмтээгүй арьс, салстад хүрэлцдэг, зөөлөн эд, яс, биеийн хөндийд нэвтэрдэг багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгахад энэхүү зааврыг мөрдөж ажиллана.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэх ариутгалын тасаг, хэсэгтэй байна.
- 1.3. Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв, сумын нэгдсэн эмнэлэг болон мэс засал, гэмтэл, эх барих зэрэг эрсдэл өндөртэй тусламж үйлчилгээ үзүүлдэг ор бүхий хувийн хэвшлийн эмнэлэг нь төвлөрсөн ариутгалын тасагтай, дээр дурьдсанаас бусад эрүүл мэндийн байгууллага ариутгалын хэсэгтэй байна.
- 1.4. Ариутгалын тасаг, хэсгийг зохион байгуулах боломжгүй эрүүл мэндийн байгууллага нь энэхүү зааврын шаардлага хангасан мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
- 1.5. Багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгах үйл ажиллагааг ариутгалын ажилтны мэргэжил олгох сургалтад хамрагдсан ажилтан гүйцэтгэнэ.
- 1.6. Багаж хэрэгслийг эрсдлийн түвшингээр нь 3 ангилна.
  - 1.6.1. **Өндөр эрсдэлтэй** – Арьс, салстыг гэмтээж, судас, дотор эрхтэн, биеийн хөндий, эд эрхтэн рүү нэвтрэн орох багаж, хэрэгсэл;
  - 1.6.2. **Дунд эрсдэлтэй** - Салст бүрхэвчтэй хүрэлцдэг багаж хэрэгсэл;
  - 1.6.3. **Бага эрсдэлтэй** – Гэмтээгүй арьс, салстад хүрэлцдэг болон хүний биед хүрдэггүй багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж
- 1.7. Багаж хэрэгслийн цэвэрлэгээ нь органик болон органик бус бохирдлыг арилгана.
- 1.8. Халдваргүйжүүлэлт нь бичил биетний тоог бууруулна.
- 1.9. Ариутгал нь багаж хэрэгсэл дэх бичил биетнийг бүрэн устгана.

### Хоёр. Ариутгалын тасаг, хэсэгт тавигдах шаардлага

- 2.1. Төвлөрсөн ариутгалын тасаг нь нэг чиглэлийн урсгалтай, бохир багаж, хэрэгсэл, материалыг хүлээн авах, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, хатаах,

засварлах, боох, савлах, ариутгах, ариун багаж, материал хадгалах, ариутгалын ажилтны хувцас солих, ажлын өрөөтэй байна.

2.2. Ариутгалын хэсэг нь нэг чиглэлийн урсгалтай, цэвэр, бохир хэсгээр тусгаарласан байна.

2.3. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэг нь цэвэр, бохир усны шугамд холбогдсон, гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй, агаарын урсгал нь ариун хэсгээс бохир хэсэг руу чиглэсэн байна.

2.4. Ариутгалын тасаг, хэсгийн өрөөний шал нь резинэн хулдаас, хана, тааз нь цэвэрлэж, халдваргүйжүүлэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

2.5. Бохир хэсэгт багаж хэрэгслийг хүлээн авч угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх, хатаах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Цэвэр хэсэгт багаж хэрэгслийн арчилгаа, савалгаа, ариутгалыг гүйцэтгэнэ.

2.6. Төвлөрсөн ариутгалын тасаг нь ариун материал хадгалах өрөөтэй байна.

2.7. Ариутгасан багаж материалыг тасаг, нэгжид ариун байдлыг алдагдуулахгүй зориулалтын, битүү шүүгээнд хадгална.

2.8. Ариутгалын тасаг, хэсэг нь шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, нөөцтэй байна.

2.9. Ариутгалын тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаанд инженер техникийн ажилтан хяналт тавьж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг холбогдох журмын дагуу гүйцэтгэж, тоног төхөөрөмжийн хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийлгэнэ.

2.10. Шинэ тоног төхөөрөмж ашиглахад ханган нийлүүлэгч байгууллага тоног төхөөрөмжийн ашиглах заавар, техникийн үзүүлэлт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг монгол хэл дээр хөрвүүлж, ажиллагсдад сургалт зохион байгуулна.

2.11. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг ажлын байранд ил байрлуулна. Техник ашиглалтын бүртгэлийг хөтөлнө.

2.12. Төвлөрсөн ариутгалын тасагт цэвэр, бохир хэсэгт ажиллах ажилтан тусдаа байна.

2.13. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ашиглана. Бодисын хэрэглэх, найруулах, аюулгүй ажиллагааны зааврыг ханган нийлүүлэгчээс авна.

2.14. Арьс, салстад бодис үсэрсэн, санамсаргүй уусан тохиолдолд тухайн бодисын аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан хордолт, түлэгдэлт зэргээс сэргийлэх арга хэмжээ авна.

2.15. Ариутгалын тасаг, хэсэгт албан ажил, сургалт, дадлагаар ажиллах ажилтан, мэргэжилтэн, оюутан хамгаалах хувцас хэрэгслийг өмсөнө.

2.16. Ариутгалын ажилтны амрах болон ажлын өрөөнөөс бусад хэсэгт хоол хүнсний зүйл хадгалах, идэхийг хориглоно.

2.17. Ариутгалын тасаг, хэсэгт шинэ ажилтанг ажиллуулахын өмнө тоног төхөөрөмж ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгнө.

## Гурав. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үйл явц

3.1. Багаж хэрэгслийг давтан ашиглахаас өмнө цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал гэсэн 3 үндсэн үйл ажиллагааг зааврын дагуу гүйцэтгэнэ.

3.2. Ариутгал, халдваргүйжүүлэлт нь багаж хэрэгслийн эрсдэлийн түвшинээс хамаарна. Үүнд:

3.2.1. Өндөр эрсдэлтэй багаж хэрэгслийг дунд түвшинд халдваргүйжүүлэх үйлчилгээтэй бодисоор халдваргүйжүүлж, ариутгана.

3.2.2. Дунд эрсдэлтэй багаж хэрэгслийг халдваргүйжүүлээд, ариутгана. Ариутгах шаардлагагүй болон ариутгах боломжгүй тохиолдолд өндөр түвшний үйлчилгээтэй бодисоор халдваргүйжүүлнэ.

3.2.3. Бага эрсдэлтэй багаж хэрэгслийг цэвэрлэж, бага болон дунд түвшинд халдваргүйжүүлнэ. Ариутгах шаардлагагүй.

3.3. Өндөр болон дунд эрсдэлтэй багаж хэрэгслийг ариутгахад дараах дарааллыг баримтлана:

3.3.1. Ариутгалын тасаг, хэсэгт бохир багаж, хэрэгслийг хүлээн авах;

3.3.2. Бохир багаж хэрэгслийг зориулалтын цэвэрлэгээний уусмалаар цэвэрлэх;

3.3.3. Шүүсэн буюу зөөлрүүлсэн усаар цэвэрлэгээний бодисын үлдэгдлийг арилтал зайлах;

3.3.4. Халдваргүйжүүлэх;

3.3.5. Шүүсэн усаар халдваргүйжүүлэх бодисын үлдэгдлийг арилтал зайлах;

3.3.6. Хатаах;

3.3.7. Багаж хэрэгслийн арчилгаа хийх (зэв арилгах, тослох, эвдрэл гэмтэл засах, шалгах);

3.3.8. Багцлах, савлах, боох;

3.3.9. Ариутгах;

3.3.10. Ариун байдлыг алдагдуулахгүй хадгалах.

3.4. Ариутгалын тасаг, хэсгийн бохир бүсэд багаж хэрэгслийг хүлээн авч цэвэрлэх, халдваргүйжүүлэх, хатаах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.5. Ариутгалын тасаг, хэсгийн цэвэр бүсэд багаж хэрэгслийг шалгах, арчлах, багцлах, боох, савлах, ариутгах үйл ажиллагааг хийнэ.

3.6. Ариутгалын тасгийн ариун бүсэд ариутгасан багаж хэрэгслийг ариун байдлыг алдагдуулахгүй хадгалж тасаг, нэгжид түгээнэ.

3.7. Ариутгалын хэсэгтэй бол ариутгасан багаж хэрэгслийг цэвэр бүсээс тасаг, нэгж рүү түгээнэ. Тасаг, нэгж нь ариутгасан материал хадгалах зориулалтын битүү шүүгээтэй байна.

3.8. Ариутгалын тасаг, хэсгийн бохир бүсэд ажиллах ариутгалын ажилтан дараах хамгаалах хувцас хэрэгслийг өмсөнө. Үүнд:



- 3.8.1. Үс далдалсан малгай;
- 3.8.2. Нүдний шил (битүүмжлэл үүсгэх), эсвэл нүүрний хаалт;
- 3.8.3. Шингэн нэвтрүүлдэггүй амны хаалт;
- 3.8.4. Шингэн нэвтрүүлдэггүй халад, хормогч;
- 3.8.5. Зориулалтын зузаан халуунд тэсвэртэй бээлий болон хурц үзүүр иртэй багажинд тэсвэртэй резинэн бээлий;
- 3.8.6. Хальтрахгүй ултай гутал, усны гутал эсвэл гутлын гадуурх углааш;
- 3.8.7. Норсон, бохирдсон үед солих даавуун цамц ба өмд.
- 3.8.8. Ус нэвтэрдэггүй халад, хормогч, ханцуйвчийг нэмэлтээр өмсөнө.
- 3.8.9. Бохир хэсэгт ажилласан хувцастай цэвэр, ариун материал хадгалах хэсэг болон бусад өрөөнд орохыг хориглоно.

3.9. Цэвэр бүсэд ажиллах ариутгалын ажилтан нь халад, өмд цамц, амны хаалт, малгай, бээлий хэрэглэх бөгөөд бохир, ариун хэсэгт орохгүй.

#### **Дөрөв. Ариутгалын тасаг, хэсэгт багаж хэрэгслийг хүлээн авах**

4.1. Ариутгалын тасаг, хэсэгт бохир багаж, хэрэгслийг “Маягт 1”-ын дагуу бүртгэн хүлээж авна.

4.2. Бохир багаж хэрэгслийг биологийн бохирдол хатахаас сэргийлж хэрэглэсэн даруйд ариутгалын тасаг, хэсэгт шууд хүргэнэ.

4.3. Шууд хүргэх боломжгүй, биологийн шингэн хатах эрсдэлтэй бол хаталтаас сэргийлсэн бодис ашиглах эсвэл цэвэрлэгээний уусмалд хэрэглэсэн даруйд хийнэ. Ариутгалын тасагт хүргэхээс өмнө багаж хэрэгслийг уусмалаас гаргаж зөөвөрлөнө.

4.4. Ариутгалын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь бохир багаж хэрэгслийн цэвэрлэгээ хийсний дараа зөөвөрлөнө. Цэвэрлэгээ хийх нөхцлийг бүрдүүлсэн байна.

4.5. Бохир багажийг зөөх сав нь тагтай, бариултай байна. Тэргэнцэр ашиглаж зөөвөрлөж болно.

#### **Тав. Багаж хэрэгслийг цэвэрлэх**

5.1. Тасаг, нэгжид цэвэрлэгээ хийсэн эсэхээс үл хамааран ариутгалын тасаг, хэсэг цэвэрлэгээ заавал хийнэ.

5.2. Цэвэрлэгээ хийх бодис нь органик бохирдол арилгах энзим (фермент) болон угаагч бодисын (детергент) найрлагатай байна.

5.3. Цэвэрлэгээний бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ. Нунтаг бодис хэрэглэж байгаа тохиолдолд усанд бүрэн ууссаны дараа багажийг хийнэ. Бүрэн уусаагүй бодис нарийн нүхтэй багажийг бөглөх болон гадаргууг өөрчлөх эрсдэлтэй.

5.4. Багаж хэрэгслийн цэвэрлэгээг гараар эсвэл зориулалтын машин ашиглан хийнэ.

## 5.5. Гар аргаар цэвэрлэх.

5.5.1. Багаж хэрэгслийг угаах угаалтуур нь багажийг гэмтэхээс сэргийлсэн зөөлөвчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн байна.

5.5.2. Багаж хэрэгслийг задалж, салган цэвэрлэгээний уусмалд хийнэ.

5.5.3. Багаж хэрэгслийг ус цацагдахаас сэргийлж цэвэрлэгээний уусмал дотор, уусмалын түвшинээс дээш гаргахгүйгээр сойздож угаана.

5.5.4. Хүнд багаж нь хөнгөн, эмзэг, үзүүр, иртэй багажийг гэмтэх эрсдэлтэй тул ангилж цэвэрлэнэ. Уусмалд хамт хийх бол хүнд багажийг доор нь байрлуулна.

5.5.5. Хөндий, гуурстай багажийг уусмалд бүрэн дүрсний дараа хоолойг нь цэвэрлэх уусмалаар даралттайгаар зайлж, хөндий хэсэгт агаарын бөмбөлөг үлдээлгүй, дотор гадаргууг цэвэрлэх уусмалтай хүрэлцэхээр байршуулна. Усан буу, өндөр даралттай усаар шүршин угааж, цэвэрлэнэ.

5.5.6. Хөндий, сувагтай багажийг цэвэрлэх уусмалд нэвчүүлсний дараа сувагт тохирсон сойзыг сонгож сувгийг цэвэрлэнэ. Багажийг усны түвшинээс доор байрлуулж сувгийг хэд хэдэн удаа сойздоно.

5.5.7. Ховилтой, араа шүдтэй багажийн ховил, хонхор, нүхийг зориулалтын сойзоор үрж угаана.

5.5.8. Цахилгаан багаж, тогны утас, кабель зэрэг уусмалд дүрэх боломжгүй эд зүйлсийг тусад нь цэвэрлэнэ.

5.5.9. Засварт өгч байгаа болон засвараас ирсэн, шинэ болон нөөцийн багажийг бохир багажийн адил цэвэрлэнэ.

5.5.10. Цэвэрлэх бодисын үлдэгдлийг шүүсэн болон зөөлрүүлсэн усаар сайтар зайлж арилгана. Хатуулаг ихтэй ус багажийг гэмтээдэг.

5.5.11. Бохир багаж зөөвөрлөсөн сав, тэргэнцэр болон цэвэрлэгээний хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

## 5.6. Машинаар цэвэрлэх

5.6.1. Эрүүл мэндийн байгууллагад ашигладаг машины төрөл:

5.6.1.1. Угаах машин: - Цэвэрлэгээний бодис бүхий зориулалтын уусмалаар угаах, зайлах, 50-75 хэмийн халуунаар хатаах үйлдэлтэй.

5.6.1.2. Угааж-халдваргүйжүүлэх машин: - Ус нь 70-95 хэм халж, халууны нөлөөгөөр халдваргүйжүүлэх үйлчилгээ үзүүлдэг. Дуран болон унтуулгын багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой.

5.6.1.3. Хэт авианы цэвэрлэгч (Ultrasonic cleaning): - Хэт өндөр давтамжтай дуу авиа, чичиргээний нөлөөгөөр багаж хэрэгслийг цэвэрлэдэг.

5.6.2. Угаах болон угааж, халдваргүйжүүлэх машинд багаж, хэрэгслийг хийхийн өмнө гараар цэвэрлэгээ хийнэ.

5.6.3. Машинаар цэвэрлэгээ хийсний дараа цэвэрлэгээний үр дүнг нүдээр шалгаж бохирдол салаагүй бол гараар давтан цэвэрлэнэ.

5.6.4. Хатуу ба уян дуран, гэрэл үүсгэгч кабель, кабелууд, оптик, резинэн эдлэл, соронзон хавтан, зөөлөн хуванцар, дахин ашиглах гуурс, амьсгалын хүрээний хэрэгслийг хэт авианы цэвэрлэгчид хийхгүй.

5.7. Цэвэрлэгээний үр дүнг хянах.

5.7.1. Цэвэрлэгээний үр дүнг цэвэрлэхэд төвөгтэй, бохирдол үлдэх эрсдэлтэй нугас, шүд, ховил зэргийг томруулдаг шил ашиглан шалгана.

5.7.2. Цус, уургийн үлдэгдэл тодорхойлох зориулалтын тест ашиглан сард 1-ээс доошгүй удаа хяналт хийнэ. Тестийн үйлдвэрлэгчийн зааврыг баримтлана.

### **Зургаа. Багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх**

6.1. Багаж, хэрэгслийг халдваргүйжүүлэхэд халууны болон химийн аргыг ашиглана.

6.1.1. Халууны нөлөөгөөр халдваргүйжүүлэх арга - Угааж, халдваргүйжүүлэх машин ашиглах.

6.1.2. Химийн халдваргүйжүүлэлтийн арга - Халдваргүйжүүлэх бодисыг (химийн бодис) ашиглах.

6.2. Халдваргүйжүүлэх бодисыг бичил биетэнд үйлчлэх идэвхээс хамааран өндөр, дунд, бага түвшний гэж 3 хуваана.

6.2.1. Өндөр түвшинд халдваргүйжүүлэх бодис (High level disinfectant) нь - Богино хугацаанд олон тооны бичил биетэн, зарим тохиолдолд спортой бактерийг устгах болон тоог цөөрүүлдэг.

6.2.2. Дунд түвшинд халдваргүйжүүлэх бодис (Intermediate level disinfectant) нь - микобактери, ихэнх бактери, вирус, мөөгөнцрийг устгаж, спортой бактерийн тоог цөөрүүлдэг.

6.2.3. Бага түвшинд халдваргүйжүүлэх бодис (Low level disinfectant) нь – Зарим бичил биетнийг устгаж, тоог цөөрүүлдэг.

6.3. Багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх уусмалд бүрэн дүрнэ.

6.4. Халдваргүйжүүлэх бодисын үйлчлэх хугацааг баримтлан сэрүүлэгтэй цаг хэрэглэнэ. Хугацаа харснаас хойш багаж нэмж хийхийг хориглоно.

6.5. Халдваргүйжүүлэх уусмалын концентраци буурахаас сэргийлж нойтон, устай багаж хийхгүй.

6.6. Уусмалд багаж хэрэгслийг задалж, нугастай багажийг нээж хийнэ.

6.7. Гуурс, хөндий суваг бүхий багажийг агаар (хий) үлдээхгүйгээр халдваргүйжүүлэх уусмал бүрэн бүрхсэн байна

6.8. Үзүүртэй, иртэй зүйлд гараа гэмтээх, уусмал асгарахаас сэргийлж багаж хэрэгслийг уусмалаас гаргахдаа бээлийтэй гараар, хавчаараар эсвэл шүүлтүүр бүхий саваар гаргана.

6.9. Уусмал бохирдсон тохиолдол бүрд сольж хэрэглэнэ. Шинээр уусмал бэлтгэсэн огноог тэмдэглэнэ.

6.10. Өндөр түвшинд халдваргүйжүүлэх бодисыг олон хоног хэрэглэж байгаа үед бодисын идэвхийг индикатороор хянаж тэмдэглэнэ.

6.11. Халдваргүйжүүлэлтийн дараа бодисын үлдэгдлийг шүүсэн усаар сайтар зайлж хатаана.

6.12. Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, гадаргуу халдваргүйжүүлэхэд хэрэглэж байгаа бодисыг багажийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэхгүй.

6.13. Багаж хэрэгслийг хатаах

6.13.1. Хатаах шүүгээнд эсвэл өрөөний хэмд, цэвэр даавуугаар арчиж хатаана.

6.13.2. Гуурс, хөндийтэй багаж хэрэгслийг өндөр даралттай хийгээр үлээж хатаана.

6.13.3. Багаж, хэрэгслийг зэв үүсэхээс сэргийлж хатааж, автоклавт хийнэ

6.14. Бага болон дунд эрсдэлтэй зарим багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт:

6.14.1. Дунд эрсдэлтэй, давтан хэрэглэж болох интубацийн гуурс, утлагын аппаратны хошуу, чих цэвэрлэх хэрэгсэл, чихний дурангийн хошуу, амбуны маск, лазерын хошуу, мэдээгүйжүүлгийн хэрэгсэл зэрэг багаж хэрэгслийг цэвэрлэсний дараа өндөр түвшинд халдваргүйжүүлнэ. Мөн угааж, халдваргүйжүүлэх автомат машин ашиглана.

6.14.2. Дээрх багаж хэрэгсэл нь нэг удаа хэрэглэх зориулалттай бол угааж, халдваргүйжүүлж давтан ашиглахгүй.

6.14.3. Амьсгалын аппаратыг задалж дотор талыг нь халдваргүйжүүлж, ариутгах шаардлагагүй.

6.14.4. Амьсгалын хүрээний эд ангиудыг нэг үйлчлүүлэгчид хэрэглэх ба амьсгалын аппаратны гуурс, амьсгал гаргах хавхлага, агаар чийгшүүлэх хэрэгсэл нь гэмтсэн, илэрхий бохирдсон үед солино. Илэрхий бохирдоогүй, механик гэмтэл үүсээгүй үед солих шаардлагагүй. Дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхийн өмнө давтан хэрэглэх эд, ангийг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Нэг удаагаар хэрэглэх хэсгийг шинээр солино.

6.14.5. Даралтын аппарат, пульс хэмжигч, чагнуур, зүрхний цахилгаан бичлэгийн хэрэгсэл, ЭХО-ны аппаратны датчик, бумба зэрэг бага эрсдэлтэй багаж хэрэгслийг цэвэрлэсний дараа бага түвшинд халдваргүйжүүлнэ. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг хосолсон найрлагатай нэг бодисоор цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж болно.

6.14.6. Эмчилгээний ванн, нярайн усанд оруулах хэрэгсэл, хүүхдийн жин болон хүний биед хүрэлцдэггүй тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэн, халдваргүйжүүлнэ. Үүнд: Амьсгалын аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, диализын аппарат, хөтөвч, шээсний сав, дуслын хөл гэх мэт тоног төхөөрөмж хамаарна.

## **Долоо. Багаж хэрэгслийг шалгах, арчлах, савлах**

7.1. Ариутгалын тасаг, хэсгийн цэвэр бүсэд хийгдэнэ. Багажийг шалгах, засах, багц бэлтгэх, савлах, баглах, сорил тавихад хангалттай зай талбайтай байна.

7.2. Томруулдаг шил, баглаа боодол, баглаа боодлыг таслах, наах төхөөрөмж, хяналтын тестүүд, зэв арилгах, тослох бодис, 96 хувийн спирт зэргийг бэлдсэн байна.

7.3. Ариутгах багц бэлтгэх, баглахын өмнө багажийг нэг бүрчлэн сайтар шалгана. Үүнд:

7.3.1. Багажийг томруулагч шил ашиглан шалгана. Хэрэв бохир бол дахин цэвэрлэнэ.

7.3.2. Цууралт үүссэн, үзүүр нугарсан, тохируулга алдагдсан зэрэг багаж гэмтсэн эсэхийг шалгаж засварлана..

7.3.3. Хайч болон хурц ирмэгтэй багаж мөхсөн, гадаргуу гэмтсэн, пүрш, эрэг боолт суларч, чөлөөтэй хөдлөх хэсгүүд гацсан гэмтэлтэй байгаа эсэхийг шалгаж засварт илгээх, дахин ашиглах боломжгүй бол хэрэглээнээс хасна.

7.4. Нээгддэг, хаагддаг нугас бүхий багажийг шалгаж гацсан тохиолдолд тосолгооны бодис ашиглан тосолно. Хэвийн ажиллагааг хангасан бол үлдэгдэл тосыг 96 хувийн спиртээр арчина.

7.5. Олон эд ангиас бүрдсэн багажийг угсарч үйл ажиллагаа нь хэвийн эсэхийг шалгаад дахин задална.

7.6. Багажийн гадаргууд тогтсон өнгөр, хаг, зэвийг хурц иртэй зүйлсээр хусаж цэвэрлэж болохгүй, зориулалтын бодисоор арилгана. Арилахгүй бол хэрэглээнээс хасна.

7.7. Мэс заслын багажийн арчилгаа тосолгоо хийхэд парафин болон вазелинд суурилсан бодис ашиглана. Силикон агуулсан бодис хэрэглэхгүй. Энэ нь хөдөлгүүр хэсгийг гацаах, уурын ариутгалын үр дүнг бууруулна.

7.8. Багажийн тосолгоог нугас, эрэг, шураг, хэрчлээс хэсэгт гараар жигд түрхэнэ. Зориулалтын тосыг хэрэглэнэ. Хугацаа нь дууссан болон нүдэнд илт харагдахуйц бохир тосыг хэрэглэхгүй.

7.9. Багаж, хэрэгслийг савлах, бооход анхаарах зүйл.

7.9.1. Савлах, боох материал нь ариутгалд зориулагдсан бүх гадаргуугаар уур нэвтрэх боломжтой, вакуум нөхцлийг хангасан байна.

7.9.2. Зориулалтын боолт, савалгааны материал ашиглана. Үүнд: Ариутгалын зориулалтын цаасан боолт, рулон уут, нийлэг материал бүхий боолтын материалыг ашиглана.

7.9.3. Зориулалтын бус даавуун боолт ашиглахыг хориглоно.

7.9.4. Багаж материалыг 1 хүнд 1 тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглах байдлаар багцалж савлана.

7.9.5. Рулон уутанд багаж материалыг савлахдаа тухайн багажинд тохирсон хэмжээтэй уут сонгоно. Уут хэтэрхий жижиг байвал агшилт үүсэх, хэт том уутыг зөөвөрлөх үед багаж уутан дотор хөдөлж уутыг



цоолох эрсдлээс сэргийлнэ. Багаж, тавиурын захаас уутны ирмэг хүртэл зай 1.5 - 2 см байхаар уутыг сонгоно. Уутны ам хэсгийг наахдаа мөн дээрх хэмжээг баримтлана.

7.9.6. Рулон боолтыг наасан хэсэгт тулгаж таслахгүй, наалтаас 1.5 см орчим зай үлдээнэ. Задлах үед боолтын гадна хэсэг дэх бохирдлоор багаж бохирдох эрсдэлтэй.

7.9.7. Рулон уутны цаасан талд шошго наах, бичих нь савлагааг гэмтээж болох тул гялгар талд шошго хадна.

7.9.8. Нэг ба түүнээс олон хэсэгтэй багажийг ариутгахын тулд давхар уут ашиглаж болно. Давхар уутыг ашиглах тохиолдолд доторх рулон цаасан уутыг битүүмжилсэний дараа дахин том уутанд хийж битүүмжилнэ.

7.9.9. Давхар уут ашиглахдаа цаасан талыг цаасан тал руу, гялгар талыг гялгар тал руу харуулж байрлуулна.

7.9.10. Зориулалтын даавуун боолт ашиглаж байгаа үед багаж материалд тохирсон хэмжээтэйг сонгоно. Даавуун боолтыг задлах үед боолтын гадна талын бохирдол багаж бохирдуулахаас хамгаалагдсан байна.

7.9.11. Нэг удаагийн боолт, савалгааны материалыг давтан ашиглахгүй.

7.9.12. Савлаж бэлтгэсэн баглаа бүрд дотор болон гадна хяналтын индикатор байрлуулна.

7.9.13. Савласан, боолттой багаж материалын гадна шошгонд ариутгасан огноо, хүчинтэй байх хугацаа, ариутгалын ажилтны код, багаж хэрэгслийн нэр, тоог тэмдэглэнэ.

### **Найм. Багаж хэрэгслийг ариутгах, ариутгалын аргууд**

8.1. Эрүүл мэндийн байгууллага нь багаж материалыг ариутгахдаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ариутгалын аргыг ашиглана. Үүнд:

8.1.1. Өндөр даралттай уурын ариутгал буюу автоклаваар ариутгах

8.1.2. Хуурай халууны аргаар ариутгах

8.1.3. Бага хэмийн ариутгал буюу устөрөгчийн хэт ислийн хийн плазмаар ариутгах

8.1.4. Химийн аргаар ариутгах.

8.2. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа багаж, хэрэгслийг ариутгах тоног төхөөрөмжөөр хангагдсан байх ба эвдрэл гэмтэл гарсан үед ашиглах нөөц ариутгагчтай байна.

8.3. Багаж, хэрэгсэл бүрд тохирох ариутгалын аргыг сонгон ариутгана.

8.4. Өндөр даралттай уурын ариутгал буюу автоклавын ариутгал хийхэд анхаарах зүйл:

8.4.1. Автоклав нь ажиллах горим, хэлбэр хэмжээ, зориулалт нь өөр өөр байдаг тул үйлдвэрлэгчийн зааврын дагуу ашиглана.

Лабораторид ашиглах, хог хаягдлыг халдваргүйжүүлэх автоклавыг багаж хэрэгслийн ариутгалд хэрэглэхгүй.

8.4.2. Хэмжээний хувьд олон сонголттой байдаг тул эмнэлгийн ачаалал, онцлогт тохируулан хэрэглэнэ.

8.4.3. Автоклавт мэс заслын багаж хэрэгсэл, төмөр болон ган багаж, даавуун хэрэгсэл, шилэн эдлэл, шингэн, керамик, резинэн эдлэл зэргийг ариутгахад хэрэглэнэ.

8.4.4. Автоклавт нугастай, хавчигддаг багаж хэрэгслийг нээлттэй ариутгана. Хаалттай хэсэг ариутгагдахгүй үлдэх эрсдэлтэй.

8.4.5. Автоклавт уур чөлөөтэй нэвтрэхээр багаж, хэрэгслийг байрлуулна. Ариутгах зүйлсийг овоолж чихэж болохгүй.

8.4.6. Ариутгах хэрэгслийг дотор хананд хүргэхгүйгээр хооронд нь зайтай байрлуулна.

8.4.7. Даавуу, зөөлөн эдлэлийг багаж, хэрэгслээс тусад нь ариутгана.

8.4.8. Ариутгах төхөөрөмжийн дээд тавиур дээр хөнгөн зүйлс, доод тавиур дээр хүндийг байрлуулна. Нэг тавиуртай тохиолдолд хүнд зүйлсийг дор нь, хөнгөн зүйлсийг дээр нь байрлуулна.

8.4.9. Автоклавыг ажиллуулахдаа үйлдвэрлэгчийн зааврыг мөрдөнө. Ажиллах хэм, даралт, хугацааг зааврын дагуу тохируулна.

8.4.10. Автоклавын хэм, даралт зохих хэмжээнд хүрээгүй байхад цагийг тооцож эхлэхгүй. Цаг тавихаа мартсан бол мөчлөгийг дахин эхлүүлнэ.

8.4.11. Автоклав бүрэн автомат бол хэм, даралт нь зохих хэмжээнд хүрэнгүүт мөчлөг автоматаар дуусна.

8.4.12. Автоклавын манометрийн заалт 0 болсны дараа автоклавыг онгойлгоно. Үлдсэн уурыг гаргасны дараа автоклавын таг, хаалгыг нээнэ. Багаж материалыг бүрэн хаттал нь автоклавт байлгана.

8.4.13. Автоклавт задгай багаж хэрэгсэл ариутгахгүй.

8.4.14. Автоклаваас багаж хэрэгслийг гаргахад уур цацагдах, түлэгдэхээс сэргийлж ажилтан автоклавын хажуу талд зогсож хаалгыг нээнэ. Халуунд тэсвэртэй зузаан бээлий өмсөнө.

8.4.15. Ариутгалаас гарсан багаж хэрэгслийг тэргэнцэртэй бол сэрүүн өрөөнд хөрөх хүртэл, тэргэнцэргүй үед тасалгааны хэмд жижиг багцыг 30 минут, том багцыг 2 цаг хүртэл хугацаатай хөргөнө.

8.4.16. Сав баглаа боодол нь автоклаваас нойтон гарсан, усны тунадас үүссэн бол ариутгал бүрэн хийгдээгүй, автоклав хэвийн ажиллаагүй гэж үзнэ.

8.4.17. Ариутгах үйл явцын аль нэг хэсэгт гэмтэл гарсан тохиолдолд тухайн гэмтэлтэй автоклаваар ариутгасан бүх багаж, материалыг хүлээн авсан тасаг, нэгжүүдээс нь эргүүлэн татаж, хэвийн ажиллагаатай ариутгагч ашиглан дахин ариутгана.

8.4.18. Ариутгах төхөөрөмжийг өдөр бүр цэвэрлэнэ.

- 8.5. Хуурай халууны ариутгагч (Hot air sterilization)
- 8.5.1. Шил сав, металл багаж хэрэгсэл, тос болон нунтаг эм, иртэй багаж, зүү, тариа, лабораторийн шилэн эдлэлийг ариутгана.
- 8.5.2. Тос буюу вазелиныг уур нэвтэлж чаддаггүй тул ус агуулаагүй өөх, тосыг ариутгахад хуурай халууныг ашиглана.
- 8.6. Бага хэмийн ариутгал буюу устөрөгчийн хэт ислийн хийн плазмын ариутгагч
- 8.6.1. Устөрөгчийн хийн плазмын ариутгагчаар өндөр хэм, чийгэнд тэсвэргүй материалыг ариутгахад ашиглана.
- 8.6.2. Багаж хэрэгслийг заавал боож, савлан ариутгах камерт хийнэ.
- 8.6.3. Боох, савлах материал нь тьювек (Тувек) эсвэл полипропилен байна.
- 8.6.4. Ариутгалын явцад температур нь 45°C-аас хэтрэхгүй. Нэг удаагийн ариутгах мөчлөгийн хугацаа 28 - 77 минут үргэлжилнэ.
- 8.6.5. Устөрөгчийн хэт ислийн шингэнтэй шууд хүрэлцсэн тохиолдолд арьсны загатнаа үүсгэж, нүдийг гэмтээх эрсдэлтэй тул ариутгалын ажилтан хамгаалах хувцас, латекс, винил эсвэл нитрил бээлий өмсөнө.
- 8.7. Химийн ариутгал
- 8.7.1. Багаж хэрэгслийг ариутгах өөр сонголтгүй үед химийн ариутгалыг ашиглана. Ариутгалын өөр арга ашиглах боломжтой бол химийн ариутгалыг хэрэглэхийг зөвшөөрөхгүй.
- 8.7.2. Химийн ариутгалд хэрэглэхийг зөвшөөрөгдсөн дараах бодисоор хугацаа, хэмийг баримтлан хийнэ. Үүнд:
- 8.7.2.1. Устөрөгчийн хэт ислийн 7.5%-ийн уусмалд 6 цагийн турш 20 хэмд;
- 8.7.2.2. Глютаральдегидийн  $\geq 2\%$  уусмалд 10 цагийн турш 20-25 хэмд;
- 8.7.2.3. Ус төрөгчийн хэт ислийн 7.35%/ перацетик хүчлийн 0.23% -ийн уусмалд 3 цагийн турш 20 хэмд
- 8.8. Ариутгалын ажилтан ариутгасан багаж, материалын бүртгэлийг “Маягт-2”-ын дагуу хөтөлнө.

### **Ес. Ариутгасан багаж, хэрэгслийн хадгалалт, тээвэрлэлт**

- 9.1. Ариутгалын тасгийн ариун материал хадгалах өрөө тоос шороо хуримтлагдах эрсдэлгүй байна. Гадаргуу нь гөлгөр цэвэрлэхэд хялбар байна.
- 9.2. Өрөөний температур нь 24°C хэмээс их, харьцангуй чийгшил нь 70%-с бага байна. Хэт их чийгшил нь туузан наалт, хаяг шошгоны цаавууны наалдалтыг бууруулж таних тэмдэг багцын агууламжийг танихад муугаар нөлөөлнө.
- 9.3. Агааржуулалтын шороо тоосыг байнга цэвэрлэн, шүүлтүүрийг солино.
- 9.4. Гар угаах угаалтуур, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байна. Угаалтуур нь хадгалах шүүгээнээс 1 метрийн зайтай байна.
- 9.5. Ариутгасан материалыг тавиур, шүүгээнд байрлуулахдаа хамгийн сүүлд гарсан ариутгасан материалыг тавиурын цаад талын хэсэгт байрлуулж, хуучныг тавиурын урд хэсэгт тавьж эхэлж хэрэглэнэ.

9.6. Ариутгалын тасаг, тусламж, үйлчилгээний нэгжүүдэд ариун материал хадгалах шүүгээтэй байна.

9.7. Ариутгагдсан багаж, хэрэгслийг зориулалтын бикс, тэргэнцрээр зөөнө. Тэргэнцэр нь ариутгасан зүйлийг бүрэн бүтэн аюулгүй тээвэрлэхэд тохиромжтой байх бөгөөд тэргэнцрийг хэрэглэхээс өмнө цэвэрлэнэ.

9.8. Тээвэрлэх явцад ариун байдлыг хамгаалах, цохих, бутлах, тахийлгаж мурийлгах, унагаах гэмтэл гаргахаас сэргийлнэ.

9.9. Ариутгагдсан зүйл шалан дээр унахад ямар нэгэн гэмтэлгүй байсан ч бохирлогдсон гэж үзнэ.

9.10. Тасаг, нэгжүүдэд ариутгасан материал түгээсэн тэмдэглэлийг “Маягт -3” – ын дагуу хөтөлнө.

9.11. Зориулалтын савалгаа, боолттой, бүрэн бүтэн байдал алдагдаагүй, гадна тал бохирдоогүй, ариун материал хадгалах зориулалтын шүүгээнд хадгалсан бол ариутгасан багаж, хэрэгслийг 6 сар хүртэл хадгалж болно.

9.12. Зориулалтын бус даавуун боолттой бол ариун материал хадгалах шүүгээнд 7 хоног хадгална.

### **Арав. Ариутгалд тавих хяналт**

10.1 Ариутгалын процесс бүрэн гүйцэд явагдаж байгаа эсэхийг техникийн буюу физик, хими, биологийн аргаар хянана.

10.2 Физикийн арга – Бүрэн автомат автоклавын дэлгэцийн мэдээллээр, хэм, даралт, хугацааг хянана. Мөн автоклавын жийргэвч, хавхлагын бүрэн бүтэн байдал, манометр, таг дарагч, боолт нь бүрэн ажиллагаатай эсэхийг өдөр бүр хянана.

10.3 Химийн хяналт - Химийн хяналтын арга нь халуун уурын нөлөөгөөр өнгөний өөрчлөлт өгдөг хяналтын индикаторуудыг ашиглаж хянана. Химийн хяналтын индикатор нь дотор ба гадна хэрэглэх 2 янз байдаг. Гадна болон дотор индикаторыг автоклавд хийх боолт, савалгаа бүрт хийнэ.

10.3.1. Дотор индикатор:

10.3.1.1 Дотор индикаторыг багаж, материалын савалгааны дотор талд байрлуулна.

10.3.1.2 Нэг ба олон параметртэй байж болно. Нэг параметрт индикатор нь ариутгалын нэг үзүүлэлтийг хянадаг (зөвхөн хэм) бол олон параметрт индикатор нь хоёр ба түүнээс дээш үзүүлэлт (хугацаа, хэм, уур гэх мэт)-ийг хянана.

10.3.1.3 Дотуур индикатор нь савалгаа бүрийн дотор ариутгалын процесс нэвтэрч багаж хэрэгсэлд хүрч байгаа эсэхийг үнэлнэ.

10.3.1.4 Олон улсын ангиллаар 3-6 дугаар ангилалд хамаарах индикаторыг боолт, савалгаа дотор ашиглана.

10.3.2. Гадна индикатор:

10.3.2.1. Савалгааны гадна талд нааж хэрэглэнэ. Хэм тодорхой хэмжээнд хүрсэн тохиолдолд индикаторын өнгө өөрчлөгддөг.

10.3.2.2. Ариутгалын мөчлөг бүрэн явагдсаныг батлахгүй.

10.4. Биологийн индикатор - Халуунд тэсвэртэй *geobacillus stearothermophilus*, *bacillus atrophaeus* амьд спор агуулсан индикатор юм.

- 10.4.1. Ариутгалын явц бүрэн явагдсан эсэхийг биологийн индикатораар хянадаг.
- 10.4.2. Ариутгагч бүрд биологийн индикаторын хяналтыг сард 1-ээс доошгүй удаа хянана.
- 10.4.3. Биологийн индикаторыг автоклавт байрлуулахдаа камерын хамгийн цаад (гүн) хэсэгт болон хаалганы ойролцоо байрлуулна.
- 10.4.4. Биологийн индикаторын үр дүнг үнэлэхдээ ажлын индикатор болон хяналтын индикатор хоёрыг хооронд нь харьцуулж үнэлнэ. Ажлын индикаторыг автоклаваас гаргасны дараа хяналтын индикатортой хамт дулаан тогтоогуурт байлгахад ажлын индикаторын өнгө өөрчлөгдөхгүй, харин хяналтын индикаторын өнгө нь өөрчлөгдөнө.
- 10.4.5. Ажлын индикаторын өнгө хувирвал ариутгал бүрэн гүйцэд хийгдээгүй байна гэж дүгнэнэ. Хяналтын индикатор өнгөний өөрчлөлт өгөхгүй бол индикатор чанарын шаардлага хангахгүй байгааг илтгэнэ.

10.5. Уурын нэвчилтийн тест (Bowie Dick test) - Ариутгах төхөөрөмжийн уур багаж, хэрэгсэлд нэвтэрч байгаа эсэхийг хянадаг тест юм.

- 10.5.1. Уурын нэвчилтийн тестээр сард 1-ээс доошгүй удаа хяналт хийнэ.
- 10.5.2. Багаж материалыг буруу савласнаас дутуу ариутгагдсаныг илрүүлэх, ариутгагч төхөөрөмжийн үйл ажиллагааны алдааг хянах зорилгоор ашигладаг.
- 10.5.3. Уурын нэвчилтийн тест нь вакуум ариутгагчид хангалттай вакуум орчин үүсээгүйг илрүүлдэг. Бүрэн вакуумжилт үүсэхгүй байх нь ариутгалын чанарыг хангалтгүй болгох эрсдэлтэй.
- 10.5.4. Тестийг байрлуулахдаа төхөөрөмжийг ажиллаж эхлэхээс өмнө ариутгагчийн хаалган талын хэсэгт тавиур дээр, хэрэв нэгээс олон камертай автоклав байвал камер бүрт байрлуулж хэрэглэнэ.
- 10.5.5. Ариутгал эхлэхээс өмнө автоклавыг хоосон ажиллуулж, Bowie Dick тестээр уур жигд тархаж байгаа эсэхийг шалгана.

10.6. Ариутгагдсан багаж, материалын ариун чанар шалгах зорилгоор лабораторийн шинжилгээ хийж болно.



**Арав. Багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт,  
ариутгалын үйл ажиллагааг үнэлэх дотоод хяналтын загвар хуудас**

	Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар
1	Багажийн цэвэрлэгээг ариутгалын тасагт хийдэг			
2	Нэг удаагийн зориулалтаар ашиглах хэрэгслийг давтан хэрэглэдэггүй байх			
3	Цэвэрлэгээг бохирын хэсэгт хийдэг байх			
4	Фермент агуулсан зориулалтын цэвэрлэх бодис ашигладаг			
5	Бохирын хэсэгт ажилладаг ажилтан ХХХ-ээр (нүдний шил, амны хаалт, халад, ханцуйвч, ус нэвтэрдэггүй хэрэгсэл) бүрэн хангагдсан			
6	Цэвэрлэгээний зориулалтын хэрэгслээр хангагдсан байх (сойз, зориулалтын тосгуур гэх мэт)			
7	Халдваргүйжүүлэх бодисыг зааврын дагуу хэрэглэдэг байх			
8	Халдваргүйжүүлэх бодисын найруулсан хугацааг тэмдэглэсэн эсэх			
9	Өндөр түвшинд халдваргүйжүүлсэн ариутгалд орохгүй багаж материалыг ариун багажийн нэгэн адил савладаг эсэх			
10	Зөөлрүүлсэн, шүүсэн усаар зайлалт хийдэг			
11	Багаж материалыг ариутгах тоног төхөөрөмжөөр хангагдсан байх			
12	Ариутгах төхөөрөмж эвдрэл гэмтэлгүй хэвийн ажиллаж байх			
13	Автоклавын физик үзүүлэлтийг өдөр бүр хянадаг байх			
14	Уурын нэвчилтийн тестээр 7 хоног тутам хяналт хийдэг байх			
15	Гадна хяналтын тест ашигладаг			
16	Дотуур хяналтын тестийг савалгаа бүрт хийдэг			
17	Биологийн хяналтын тестээр сар бүр хянадаг			
18	Ариутгалын ажилтны мэргэжил олгох сургалтад хамрагдсан ажилтан ажилладаг байх			
19	Шинэ тоног төхөөрөмж суурилуулах бүрт сургалт хийдэг байх			
20	Багаж зөөх сав нь тагтай, бариултай байх			
21	Багаж зөөх савыг цэвэрлэж, халдваргүйжүүлдэг байх			
22	Халдваргүйжүүлэх бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байх			
23	Хэмжих хэрэгсэлтэй байх			
24	Цэвэрлэгээний дараа цус, уургийн үлдэгдлийг шалгадаг байх			
25	Анхан шатны маягтуудыг бүрэн хөтөлдөг байх			

**ТӨВЛӨРСӨН АРИУТГАЛЫН ТАСАГ /НЭГЖ/-Т БАГАЖ, МАТЕРИАЛЫГ  
ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

Эмнэлэг, Тасгийн нэр: \_\_\_\_\_

20...оны.....сарын.....өдөр.....цаг.....минут

№	Багаж материалын нэр/	Тоо ширхэг	Хүлээлгэж өгсөн хүний нэр	Хүлээж авсан хүний нэр

**АРИУТГАЛЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ЗАГВАР МАЯГТ**

Ариутгалын төрөл: Уурын, хуурай халууны, бага хэмийн, химийн /зур/

20.....оны .....сарын.....өдөр

Аппаратын нэр, марк : \_\_\_\_\_

№	Ариутгасан зүйлийн нэр	Тоо хэмжээ	Ариутгасан хугацаа			Хяналт		
			Эхэлсэн цаг	Дууссан цаг	Ариутгалын аппаратаас гаргасан цаг	Химийн	Биологийн	Техникийн үзүүлэлт

Ариутгалын ажилтан: ...../ /  
/гарын үсэг /

/ /  
/нэр/



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 4/537 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫГ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗААВАР**

### **Нэг: Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү зааврыг эрүүл мэндийн байгууллагын ажилтан, түүнд дадлага хийж, суралцаж байгаа оюутан, суралцагч, дадлагажигч нар дагаж мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, суралцагч, дадлагажигч (цаашид ажилтан гэх) нь ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан ажлын байрандаа халдварт өртөж улмаар бусдад халдвар тараах эрсдэлтэй байдаг.
- 1.3. Эрүүл мэндийн ажилтан ажлын байрандаа зүүнд хатгуулах, хурц үзүүртэй, иртэй багажинд зүсэгдэх, хатгагдах, халдварлагдсан биологийн шингэн ам, хамар, нүдний салстад үсрэх, гэмтэлтэй арьс цус, биологийн шингэнээр бохирдох зэрэгт цусаар дамжих халдварт өртөх эрсдэл хамгийн их байдаг.
- 1.4. Өртөлтийн дараах сэргийлэлт (ӨДС) гэж өртөлтийн дараа халдвар авах эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг хэлнэ.
- 1.5. Эрүүл мэндийн байгууллага нь дараах чиглэлээр ажилтныг халдвараас сэргийлэх арга хэмжээг авна.
  - 1.9.1. Халдварт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх
  - 1.9.2. Өртсөний дараа халдвар авахаас сэргийлэх арга хэмжээ авах, хянах

### **Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг**

- 2.1. Эрүүл мэндийн ажилтныг үзлэг, шинжилгээнд хамруулах журам, заавар, хуваарьтай, ажиллагсдад танилцуулсан байна.
- 2.2. Хүний эрхийг дээдлэн ажилтны эрүүл мэндийн байдлын талаар хувь хүний нууцыг чандлан хадгална.
- 2.3. Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийг томилон ажиллуулна.
- 2.4. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх дараах 5 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.
  - 2.4.1. Эрүүл мэндийн байдалд үзлэг, шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх;
  - 2.4.2. Аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, дадлыг олгох;
  - 2.4.3. Ажлын байрыг халдварын тархалт хамгийн бага хэмжээнд байлгах аюулгүй ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх;
  - 2.4.4. Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөхөөс сэргийлж дархлаажуулах, хувийн хамгаалах хувцас хэрэгслээр хангах;

2.4.5. Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд халдвараас сэргийлэх арга хэмжээ авдаг, бүртгэж, тайлагнадаг байх.

2.5. Ажилтны аюулгүй байдал, ажлын байран дахь эрсдэлд өртөлт, өртөлтийн дараах арга хэмжээний талаар жил бүр сургалт зохион байгуулна.

2.6. Хурц үзүүр иртэй багаж хэрэгслийг зөв цуглуулах, аюулгүй хайрцаг шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

2.7. Шинэ ажилтанд баримжаа олгох сургалтаар өртөхөөс сэргийлэх, өртөлтийн дараа халдвараас сэргийлэх мэдлэгийг олгосон байна.

### **Гурав. Эрүүл мэндийн ажилтны үүрэг**

3.1. Халдвараас сэргийлэх журам, зааврыг мөрдөж ажиллана.

3.2. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хуваарийн дагуу орж, хориглох заалтгүй бол эрүүл мэндийн ажилтны хамрагдах шаардлагатай дархлаажуулалтад хамрагдана.

3.3. Халдварт өртөхөөс сэргийлэх мэдлэг олгох сургалтад хамрагдана.

3.4. Үйлчлүүлэгч болон бусдад халдвар тараах эрсдэл үүссэн үед халдварын сэргийлэлт, хяналтын алба, баг, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийн асуудал хариуцсан эмчид мэдэгдэнэ.

### **Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны үзлэг, шинжилгээ, дархлаажуулалт**

4.1. Эрүүл мэндийн байгууллагад шинэ ажилтан авахдаа дараах үзлэг шинжилгээнд хамруулж, дархлаажуулалтын мэдээллийг авна.

4.1.1. Сүрьеэ илрүүлэх – Цээж гэрэлд харах.

4.1.2. Гепатитын В, С вирус илрүүлэх,

В гепатитын вакцинд хамрагдсан бол дархлал тогтоцын шинжилгээний дүнг, дархлаажуулалтад хамрагдсан ч дархлал тогтоцын шинжилгээ хийлгээгүй бол шинжилгээнд хамруулж дүнг хувийн хэрэгт хавсаргана.

4.1.3. ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.

4.1.4. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын дархлаажуулалтад хамрагдсан эсэх хамрагдсан бол хэдэн онд гэдгийг асуумжаар тодруулах, эсрэг бие тодорхойлох шинжилгээнд хамруулна.

4.1.5. Улаанбурхан, салхинцэцэгийн халдвараар өвдсөн эсэхийг асуумжаар тодруулж үзлэгийн хуудаст тэмдэглэнэ.

4.1.6. Метициллин тэсвэртэй стафилококк ауриус илрүүлэх шинжилгээнд хамруулна.

4.2. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан нь гепатитын В вирус, улаанбурхан, улаанууд, гахай хавдар, сахуу, хөхүүл ханиад, татран, томуу зэрэг өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байна.

4.2.1. Эрүүл мэндийн ажилтанг гепатитын В вирусийн вакцинд хамруулахдаа В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg) илрүүлэх шинжилгээнд хамруулна.

Гадаргуугийн эсрэгтөрөгч сөрөг үед анти-НВs, анти-НВс маркерийг тодорхойлох шинжилгээнд хамруулж шинжилгээний дүн сөрөг бол гепатитын В вирусийн эсрэг вакцинаар 3 тунгаар дархлаажуулна. Эхний тунгаас 2 дахь тун 1 сарын зайтай, 3 дахь тунг 2 дахь тунгаас 5 сарын зайтай хийнэ.

4.2.2. Жил бүр томуугийн дархлаажуулалтад хамрагдана. Томуугийн вакцины зааврыг баримтлан хийнэ.

4.2.3. Улаанбурхан, гахайхавдар, улаануудын вакциныг тухайн халдвараар өвдөөгүй, дархлаагүй ажилтанг 2 тунгаар дархлаажуулна. Эхний тунгаас 1 сарын зайтай 2 дахь тунг хийнэ.

4.2.4. Сахуу, татран, хөхүүл ханиадын халдварын эрсдэлд үнэлгээ хийж эмнэлгийн ажилтанг дархлаажуулна.

4.3. Дархлаажуулалтад хамрагдсан бол эсрэг бие тогтсон эсэхийг баталгаажуулж, эрүүл мэндийн хуудсанд тэмдэглэн, хувийн хэрэгт хавсаргана.

4.3.1. В гепатитын эсрэг вакцины дархлаа тогтоцыг сүүлийн тунгаас 1 сараас хойш хугацаанд тодорхойлно. Anti HBs маркер 10mIU/ml –ээс их бол дархлал тогтсон гэж үзнэ.

4.3.2. Anti HBs маркер 10mIU/ml –ээс бага бол В гепатитын эсрэг вакцинаар дахин 3 тунгаар, Anti HBs маркер 100mIU/ml –ээс бага тогтсон бол дахин 1 тунгаар дархлаажуулна.

4.3.3. Anti HBs маркер 100mIU/ml –ээс их дархлаа тогтсон бол 5 жилийн дараа дархлаа тогтоцын шинжилгээг давтан тодорхойлуулна. 5 жил дотор дахин дархлал тогтоц үзэх шаардлагагүй.

4.3.4. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын өвөрмөц IgG үзэж дархлаатай эсэхийг баталгаажуулна.

4.4. Гэдэсний балнад, тарваган тахал, сүрьеэгийн эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар болон сайн дурын хэлбэрээр дархлаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

4.5. Эрүүл мэндийн ажилтныг жил бүр дараах үзлэг, шинжилгээнд хамруулна.

4.5.1. Сүрьеэ илрүүлэх;

4.5.2. Гепатитын С вирус илрүүлэх;

4.5.3. ХДХВ илрүүлэх;

4.5.4. Гепатитын В вирусийн дархлаажуулалтад хамрагдаагүй ажилтанг В вирус илрүүлэх шинжилгээнд хамруулах,

4.5.5. Гепатитын В вирусийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтанг 5 жил тутамд 1 удаа дархлал тогтоцын шинжилгээнд хамруулах;

4.5.6. Гепатитын В вирусийн архаг халдвартай бол D вирус илрүүлэх;

4.5.7. Гепатитын В, С вирусийн архаг халдвартай, эмчилгээнд хамрагдаагүй бол вирусийн идэвхижил тодорхойлох;

4.5.8. Метициллин тэсвэртэй стафилококк ауриус илрүүлэх шинжилгээнд хамруулна.

4.6. Эрүүл мэндийн байгууллага нь нийт ажилтны эрүүл мэнд, дархлаажуулалтын мэдээллийн нэгдсэн сантай байна.

4.7. Эрүүл мэндийн ажилтны жил бүрийн үзлэг шинжилгээ, дархлаажуулалтын зардлыг эрүүл мэндийн байгууллага, шинэ ажилтны үзлэг шинжилгээтэй холбоотой зардлыг иргэн өөрөө хариуцна.

### **Тав. Эрүүл мэндийн ажилтанг халдвар авах эрсдэлд өртөхөөс сэргийлэх**

5.1. Бүх тасаг, нэгж ажлын байрны өртөлтийн эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлт хүчин зүйлийг тогтоосон байна.

5.2. Эрүүл мэндийн ажилтанд жил бүр сургалт хийж, зааварчилгаа өгнө.

5.3. Зүү, тариур, хурц үзүүр иртэй багаж хэрэгслийг зөв ангилан цуглуулна. Чанарын шаардлага хангасан хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэл, шингэн нэвтэрдэггүй аюулгүй хайрцаг ашиглана.

5.4. Зүү буцааж таглах буруу дадал байгаа эсэхэд халдварын сэргийлэлт хяналтын алба, баг, тасгийн халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан тогтмол хяналт хийнэ. Буруу дадалтай ажилтанг илрүүлж зөвлөгөө, заавар өгч ажиллана.

5.5. Эрүүл мэндийн байгууллага нь цусаар дамжих халдварт өртөх эрсдэлийг бууруулах зорилгоор өөрөө эвдэрдэг, зүү нь буцаж татагддаг гэх мэт аюулгүй зүү, тариурыг хэрэглээнд нэвтрүүлнэ.

5.6. Цус биологийн шингэнд өртөх эрсдэлтэй ажилбарын үед хувийн хамгаалах, хувцас хэрэгслийг хэрэглэнэ. Хангамж, нөөцийг бүрдүүлж ажиллана.

5.7. Тасаг, нэгжүүдийг өртөлтийн дараах сэргийлэлтийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай цомгоор хангасан байна.

5.8. Өртөлтийн дараах сэргийлэлтийн цомогт спирт, шархны наалт, боолт, самбай, цус тогтоох цацлага, гепатитын В, С вирус, ХДХВ илрүүлэх түргэвчилсэн тест, шинжилгээ авах хэрэгсэл байна.

5.9. Түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх аргад эмч, мэргэжилтнийг сургасан байна.

5.10. Нүд рүү цус үсрэх эрсдэлтэй мэс засал, яаралтай тусламж, хүлээн авах тасагт нүд угаах хэрэгсэлтэй байна.

5.11. ХДХВ-ийн халдвар авах эрсдэлд өртсөн үед хэрэглэх ретровирусийн эсрэг эмийн цомог эмнэлгийн хэмжээнд 1-ээс багагүй байна.

### **Зургаа. Өртөлтийн дараах сэргийлэлт**

6.1. Ажилтан нь цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн үед дараах өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.2. Эрсдэлд өртсөн ажилтны үүрэг, яаралтай авах арга хэмжээ.

6.2.1. Зүүнд хатгуулсан, зүсэгдсэн бол айж, сандрахгүй, зүссэн, хатгасан шархтай хэсгийг савантай усаар угаана.

6.2.2. Шархыг антисептик уусмалаар цэвэрлэж цус тогтоох цацлага, наалт хэрэглэнэ.



6.2.3. Нүд рүү биологийн шингэн үсэрсэн тохиолдолд цэвэр ус эсвэл физиологийн уусмал, зориулалтын нүд угаагчаар угаана. Саван, халдваргүйжүүлэх бодис хэрэглэж болохгүй.

6.2.4. Эрүүл мэндийн ажилтан эрсдэлд өртсөн тохиолдлыг даруй халдварын сэргийлэлт, хяналтын алба, баг, тархвар судлаач, эсвэл эмнэлгийн ажилтны эмчид мэдэгдэнэ.

6.3. Эрсдэлт өртсөн ажилтныг үзлэг, шинжилгээнд хамруулах, халдвараас сэргийлэх арга хэмжээний асуудлыг тархвар судлаач, эмнэлгийн ажилтны эрүүл мэнд хариуцсан эмч холбогдох мэргэжлийн эмч нартай зөвшилцөж шийдвэрлэнэ. Үүнд:

6.3.1. Эрсдэлд өртсөн тохиолдлыг “Маягт-2”-ын дагуу бүртгэнэ. Халдварын эрсдэлийн үнэлгээг хамтран хийнэ.

6.3.2. Эрсдэлд өртсөн ажилтны эрүүл мэнд, гэмтлийн байдал, халдварын эрсдэлийг үнэлэн, өртөлтийн дараах халдвараас сэргийлэх эмчилгээ, шинжилгээнд хамруулах эсэх, хамрагдсан бол явцын хяналт тавина.

6.4. Халдварын эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн өртөлтийн дараа халдвараас сэргийлэх эмчилгээ, шинжилгээг хийнэ. Үүнд:

6.4.1. Үйлчлүүлэгч ХДХВ-ийн халдвартай, шинжилгээ өгөхөөс татгалзсан, өвчлөлийн байдал тодорхойгүй эсвэл эх уурхай тодорхойгүй бол ретровирусийн эсрэг эмийг эрсдэлд өртснөөс хойш аль болох богино хугацаанд 1-2 цагт, 72 цагаас хэтрүүлэлгүй ууна. Эмчилгээний үргэлжлэх хугацаа, тун хэмжээг мэргэжлийн эмчийн зөвлөгөөний дагуу шийдвэрлэнэ.

6.4.2. Ажилтан В вируст гепатитын эсрэг дархлаагүй (дархлаажуулалтад хамрагдсан ч дархлал тогтоогүй, 3 тун бүрэн хийлгээгүй), үйлчлүүлэгч гепатитын В вирусийн халдвартай тохиолдолд эрсдэлд өртсөний дараа 48 цагийн дотор В вируст гепатитын эсрэг вакцины эхний тунгаар дархлаажуулж, В вирусийн эсрэг өвөрмөц иммуноглобулиныг (0,06мл/кг эсвэл 500 ОУН) булчинд тарина.

6.4.3. Ажилтан В вируст гепатитын эсрэг дархлаатай (3 тун вакцинд хамрагдсан, дархлал тогтоцын шинжилгээнд Anti-HBs 100mIU/ml –ээс их), үйлчлүүлэгч гепатитын В вирусийн халдвартай бол дархлаажуулалт болон эмчилгээ шаардлагагүй.

6.4.4. Ажилтан В вируст гепатитын эсрэг дархлаагүй, үйлчлүүлэгч халдваргүй тохиолдолд эрсдэлд өртсөн ажилтанд HBIG иммуноглобулин тарьж, гепатитын В вирусийн эсрэг вакцинаар 3 тунгаар дархлаажуулна.

6.4.5. Ажилтан В вируст гепатитын эсрэг дархлаагүй, үйлчлүүлэгч HBsAg, HBeAg эерэг, гепатитын В вирусийн ДНХ –ийн түвшин өндөр бол эрсдэлд өртсөн ажилтанд HBIG иммуноглобулиныг 1 сарын зайтай 2 удаа тарьж, гепатитын В вирусийн эсрэг вакцинаар 3 тунгаар дархлаажуулна.

6.4.6. Үйлчлүүлэгч гепатитын С вирусийн халдвартай тохиолдолд эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтанд anti-HCV илрүүлэх шинжилгээг

6 сарын дараа, HCV-RNA –н ачаалал тодорхойлох шинжилгээ 4 долоо хоногийн дараа хийнэ. Уг шинжилгээг 6 сарын дараа давтан хийнэ.

6.5. Дархлаажуулалтын нэгжгүй эрүүл мэндийн байгууллага гепатитын В вирусийн халдвар авах эрсдэлд өртсөн ажилтанг 48 цаг дотор вакцин хийлгэх асуудлыг шийдвэрлэсэн байна.

6.6. Эрүүл мэндийн ажилтан өртсний дараа халдвараас сэргийлэх арга хэмжээ аваагүй бол HBsAg, анти-HBc маркерын давтан шинжилгээг 6 сарын дараа хийж, халдвар авсан эсэхийг тогтооно.

6.7. Эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан сэргийлэлтийн арга хэмжээ авч байх хугацаанд цус болон бусад эрхтний донор болохыг хориглоно.

6.8. Хэрэв тухайн ажилтан халдвар авсан нь тогтоогдсон бол холбогдох зааврын дагуу оношилж, вирусийн эсрэг эмчилгээнд хамруулна.

6.9. Эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлд өртсөн тохиолдолд ӨДС-ийн арга хэмжээний зардлыг тухайн байгууллага хариуцана.

### **Долоо. Цусаар дамжих халдвартай эмнэлгийн ажилтанд тавих хяналт**

7.1. Гепатитын архаг халдвартай эрүүл мэндийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхжилийг жилд 1 удаа шинжилнэ.

7.2. Эрүүл мэндийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхижил  $\geq 10^4$  GE/ml тохиолдолд хэвлий, цээжний хөндий, зүрх, үе мөч, гэмтэл, мэдрэлийн мэс засал, төрөх, эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбарт оролцуулахыг хязгаарлах арга хэмжээ авна.

7.3. Эрүүл мэндийн ажилтанд ХДХВ-ийн халдвар илэрсэн тохиолдолд мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбар, шүд, эх барих, чих хамар хоолой гэх мэт ажилбар бүхий эмнэлгийн тусламж, үйлчилгээг хийлгэхгүй.

7.4. Цусаар дамжих халдвартай болох нь тогтоогдсон эрүүл мэндийн ажилтантай байгуулах гэрээнд дараах асуудлыг тусгасан байна.

7.4.1. Ажилтны эрүүл мэндийг хариуцсан эмчийн хяналтад байж жил бүр вирусийн идэвхжилийг шинжилгээгээр хянах, өвчний явц, эмчилгээний талаар зөвлөгөө авах;

7.4.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх асуудлаар сургалтад хамрагдах, халдвараас сэргийлэх заавар журмыг чанд мөрдөж ажиллах;

7.4.3. Ажлын байр өөрчлөгдөх, вирус идэвхжсэн, өөр төрлийн өвчин эмгэг илрэх зэрэг үйлчлүүлэгчид халдвар дамжуулах эрсдэлтэй тохиолдолд ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчид мэдэгдэх;

7.4.4. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад алдаа гарч үйлчлүүлэгч халдварт өртөх эрсдэл үүссэн тохиолдлыг нэн даруй эмнэлгийн ажилтны эмч, тархвар судлаачид мэдэгдэх.

**Найм. Ажлын байрны зохицуулалт, хязгаарлалт хийх шаардлагатай зарим халдварууд**

<b>№</b>	<b>Халдварын нэр</b>	<b>Хязгаарлалт</b>
1	Нүдний салстын үрэвсэл	Үрэвсэл намдтал үйлчлүүлэгчтэй харьцахыг хязгаарлана.
2	Суулгалт халдвар	Шинж тэмдэг арилах хүртэл үйлчлүүлэгчийн орчин, хоол ундтай харьцахыг хязгаарлана. Өндөр эрсдэлтэй өвчтөнд тусламж үзүүлэхийг хязгаарлана. Норовирус бол шинж тэмдэг эхэлснээс хойш ажиллах хугацааг 48-72 цаг хязгаарлана.
3	Гепатитын цочмог болон архаг халдвартай HBeAg илэрсэн ажилтан	Гепатит Be антиген (HBeAg) сөрөг болтол арьс салст гэмтээсэн ажилбар хийлгэхийг хязгаарлана.
4	Хүний дархлал хомсдлын вирус	Инвазив ажилбар хийхийг хориглоно.
5	Улаанбурхан	Тууралт эхэлснээс хойш 7 хоног хүртэл ажлаас чөлөөлнө. Дархлаагүй ажилтан халдвар авах эрсдэлд өртсөн бол өртөлтөөс хойш 21 дэх өдөр хүртэл тусгаарлана.
6	Менингококкт халдвар	Антибиотик эмчилгээ эхэлснээс хойш 24 цаг хүртэл ажлаас чөлөөлнө.
7	Идэвхтэй сүрьеэ Туберкулин сорил эерэг	Халдваргүй болох нь батлагдах хүртэл ажлаас чөлөөлөх
8	Салхин цэцэг	Бүх шарх хатах болон тав үүсэх хүртэл ажлаас чөлөөлнө.
9	Амьсгалын замын вирусийн халдвар, цочмог халууралт	Цочмог шинж тэмдэг арилах хүртэл ажлаас чөлөөлөх, ТТӨ эрсдэл өндөртэй хэсэгт ажиллуулахгүй.
10	Арьсанд тууралт гарсан, халдварлагдсан шархтай,	Нярай, мэс засал, дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгчтэй ажиллах тасаг нэгжид ажиллахыг шинж тэмдэг арилах хүртэл хязгаарлана.
11	Гарын арьс гэмтэлтэй, бүрэн байдал алдагдсан	Биологийн шингэнд хүрэлцэх эрсдэлтэй ажилбар хийхийг хязгаарлана.

**Ажилтны эрүүл мэндийн хуудасны загвар**

1. Овог \_\_\_\_\_ 2. Нэр \_\_\_\_\_  
 4. Нас \_\_\_\_ 4. Хүйс:  Эр  Эм  
 5. Албан тушаал: \_\_\_\_\_

**А.Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ (Жил бүр ЭМА үзлэг, шинэ ажилтанд)**

Шинжилгээний төрөл	Үр дүн	Он сар өдөр	Эмнэлэг, лабораторийн нэр	Эмчийн гарын үсэг
Цээж гэрэлд харах				
ХДХВ				
HBsAg				
Anti HBs				
Anti HCV				
MRSA				

**Б.Дархлаажуулалт (Шинэ ажилтанд)**

Баталгаажуулах	Дархлаажуулалтад хамрагдсан хугацаа он, тун	Эсрэг бие тодорхойлуулсан эсэх
		Тийм/Үгүй
Гепатит В: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		
Сахуу, хөхүүл ханиад, татран: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		
Улаанбурхан, гахай хавдар, улаанууд: <input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй <input type="radio"/> Мэдэхгүй		

**В. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн дүгнэлт:**

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

----- Гарын үсэг

-----он ----- сар ----- өдөр

**Эрүүл мэндийн ажилтны халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдлыг бүртгэх хуудас**

**1. Халдвар авах эрсдэлд өртсөн эмнэлгийн ажилтны мэдээлэл**

Нэр .....	Овог .....	Нас .....	Хүйс: Эр <input type="checkbox"/> Эм <input type="checkbox"/>
Эмнэлгийн ажилтны харъяалагдах тасаг, нэгж ..... Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан уу? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй Хэрэв <b>Тийм</b> бол; Эхний тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № ..... 2 дахь тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № ..... 3 дахь тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № .....  Гепатитын В вирусийн дархлал тогтоцын шинжилгээнд хамрагдсан эсэх.  Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм бол шинжилгээний хариу .....  Гепатитын архаг халдвартай эсэх    Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> <input type="checkbox"/>  Тийм бол ямар халдвартайг бичих .....  ХДХВ-ийн халдвартай эсэх    Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> <input type="checkbox"/>			

**2. Эрсдэлийн талаарх мэдээлэл**

Эрсдэлд өртсөн огноо : .....он ..... сар .....өдөр .....цаг .....мин  
**Хийж байсан ажилбар болон өртөлтийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл.**  
 .....  
 .....  
**Зүү:** Хэрэглэсэн  Хэрэглээгүй   
 Тариурын зүү     уламжлалт эмчилгээний зүү     бусад.....  
**Хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл:** Хэрэглэсэн  Хэрэглээгүй   
 Мэс заслын хутга ,  Оёдол тавих хэрэгсэл,  Төмөр утас,  мпул,  
 хуруу шил,  бусад .....

**Цус болон биологийн шингэнд өртсөн:**  
 цус     шээс     шархны шүүдэс     бусад.....

Өртөлтийн хэлбэр  
 Нүдний салстад үсэрсэн     Хамар, амны салстад үсэрсэн   
 Арьсанд хүрсэн     Ил шарх, шалбархайтай хэсэгт хүрсэн

Хувийн хамгаалах хувцас өмссөн эсэх  
 Халад     бээлий     нүдний шил     амны хаалт     нүүрний хамгаалалт  
 бусад .....

Өртсөн болон гэмтсэн биеийн хэсэг .....

<u>Шархны байдал</u> <input type="checkbox"/> гүн <input type="checkbox"/> дунд зэрэг <input type="checkbox"/> өнгөц Гэмтсэн талбайн хэмжээ    Том <input type="checkbox"/> Жижиг <input type="checkbox"/>		
<b>3. Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл</b>		
Үйлчлүүлэгчийн түүхийн дугаар №:.....	Үйлчлүүлэгчийн овог ..... нэр .....	
<u>Үйлчлүүлэгч ямар нэгэн цусаар дамжих халдвартай эсэх?</u> <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй		
<u>Хэрэв тийм бол</u> <input type="checkbox"/> ГВВ <input type="checkbox"/> ГСВ <input type="checkbox"/> бусад ..... <input type="checkbox"/> ХДХВ <input type="checkbox"/> тодорхойгүй		
<b>4. Халдвараас сэргийлэх арга хэмжээ</b>		
<u>А. Ажилтан өөрөө авсан арга хэмжээний талаар тэмдэглэнэ үү ?</u>		
.....		
.....		
<u>Б.Өртөлтийн дараа ХСХ багийн авсан арга хэмжээ</u>		
Үйлчлүүлэгчийг шинжилгээнд хамруулсан эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй Хэрэв тийм бол хамрагдсан шинжилгээ, дүн <input type="checkbox"/> HIV <input type="checkbox"/> HCV <input type="checkbox"/> HBsAg <input type="checkbox"/> HBeAg <input type="checkbox"/> HBV-DNA .....		
Эмнэлгийн ажилтанг шинжилгээнд хамруулсан эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй Хэрэв тийм бол хамрагдсан шинжилгээ <input type="checkbox"/> HIV <input type="checkbox"/> HCV <input type="checkbox"/> HCV-RNA <input type="checkbox"/> HBsAg <input type="checkbox"/> HBeAg <input type="checkbox"/> HBV-DNA <input type="checkbox"/> Anti HBs .....		
<u>Гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулагдсан эсэх</u>		
Эхний тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № .....		
2 дахь тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № .....		
3 дахь тун хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр, серийн № .....		
<u>Иммуноглобулин хийсэн эсэх</u> <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <u>Хэрэв тийм бол,</u> Иммуноглобулин хийгдсэн ..... он ..... сар ..... өдөр,    серийн № .....		
<u>РВЭЭ хийсэн эсэх</u> <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <u>Хэрэв тийм бол,</u> РВЭЭ хийж эхэлсэн өдөр ..... он ..... сар ..... өдөр    Хугацаа ..... хоног		
<b>5. Баталгаажуулалт</b>		
Өртсөн ажилтан: Нэр:.....	Эмнэлгийн ажилтны эмч Нэр:.....	Тархвар судлаач Нэр:.....
Гарын үсэг: .....	Гарын үсэг: .....	Гарын үсэг: .....

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн А/537 дугаар тушаалын  
дөрөвдүгээр хавсралт

## **ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ДУРАН, ТҮҮНИЙ ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙГ УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, АРИУТГАХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврыг оношилгоо, эмчилгээнд хэрэглэдэг бүх төрлийн хатуу болон уян дуран, түүний дагалдах хэрэгсэл, туслах багажийг угаах, өндөр түвшний халдваргүйжүүлэлт, ариутгал хийх үйл ажиллагаанд мөрдөнө. Дуран тус бүрийг үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмжийг харгалзан угааж, халдваргүйжүүлж, ариутгана.

1.2. Нэг удаагаар хэрэглэх туслах багаж, хэрэгслийг давтан хэрэглэхийг хориглоно. Давтан хэрэглэж болох багаж, хэрэгслийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу өндөр даралттай уур, бага хэмийн хийн ариутгалаар ариутгаж битүүмжлэн, шошго, огноог тэмдэглэсэн байна.

1.3. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах, ариутгал шаардагдах бүх дуранг төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэгт ариутгана.

1.4. Халдварын дунд зэргийн эрсдэлтэй бүлэгт хамаарагдах, өндөр зэргийн халдваргүйжүүлэлт хийгдэх бүх дуранг ажилбарын өрөөнөөс тусдаа, цэвэр, бохир хэсгээр тусгаарлагдсан өрөөнд угааж, халдваргүйжүүлнэ. Угааж, халдваргүйжүүлэх өрөөнд сорох хэсэг нь хүний өндрийн түвшингээс доош байрлуулагдсан зориулалтын агааржуулалтын төхөөрөмжтэй байна.

1.5. Дуранг зориулалтын зөөлөвчтэй тосгуурт урсгал усаар угаах ба угаалганд хэрэглэгдэх сувгийн сойз нь тусгай зориулалтын байна. Сойзны бүрэн бүтэн байдал алдагдах бүрт шинээр сольж хэрэглэнэ. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах дурангийн угаалгын сойзыг нэг удаагаар хэрэглэнэ.

1.6. Дурангийн халдваргүйжүүлэлт, ариутгал хийх ажилтан нь ариутгалын ажилтны мэргэжил олгох сургалтад хамрагдсан, дурангын багаж хэрэгслийг угааж, халдваргүйжүүлэх чиглэлээр ажлын байрны сургалтад хамрагдсан мэргэшсэн байна.

1.7. Ажилтан зориулалтын хамгаалалтын хувцас хэрэгслээр (малгай, халат, нүдний шил, амны хаалт, чихэвч, бээлий) хангагдсан байна.

1.8. Дурангийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэгдэх бодис нь дуранг гэмтээхгүйгээр тохирсон байх ба олон улсын худалдаанд зөвшөөрөгдсөн, Монгол улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

1.9. Дуран түүний дагалдах хэрэгсэлтэй ажиллахдаа үйлдвэрлэгчээс гаргасан хэрэглэх арга, аюулгүй ажиллагааг баримтлана. Үйлдвэрээс тогтоосон техникийн ажлын хугацаанд ханган нийлүүлэгч байгууллага болон инженер техникийн алба үнэлгээг хийж, гэмтэл гарсан тохиолдолд хэрэглээнээс хасах буюу засварлах арга хэмжээг авч ажиллана.

## **Хоёр. Дурангийн ангилал, халдваргүйжүүлэлт, ариутгал хийх нөхцөлийн ялгаа**

2.1. Оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх дуранг хүний биеийн арьс, хөндийт эрхтний салст бүрхэвчинд гэмтэл учруулах, шууд хүрэлцэх гэмтлийн зэргээс хамааруулан 2 ангилна.

2.1.1. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах ариутгал шаардагдах дурангууд;

2.1.2. Халдварын дунд зэргийн эрсдэлтэй бүлэгт хамаарагдах өндөр зэргийн халдваргүйжүүлэлт хийгдэх дурангууд гэж ангилна.

2.2. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах, ариутгал шаардагдах дурангуудад үений, хэвлийн, бөөрний, давсагны, цээжний хөндийн, эмэгтэйчүүдийн, умайн, нуруу нугасны, тархины, чих хамар дайврын зэрэг мэс заслын бүх хатуу, уян дурангууд орно.

2.3. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах дурангуудыг энэ хавсралтын хүснэгт 1-д заасан зааврын дагуу химийн аргаар ариутгах эсвэл уурын болон бага хэмийн (газ плазма) аргаар ариутгана.

2.4. Халдварын дунд зэргийн эрсдэлтэй бүлэгт хамаарагдах, өндөр зэргийн халдваргүйжүүлэлт хийгдэх дурангуудад хоол боловсруулах дээд ба доод замын, уушгины, давсагны, чих хамар залгиур төвөнхийн зэрэг оношлогоо, ажилбар хийгдэх бүх уян, хатуу дурангууд орно.

2.5. Халдварын дунд зэргийн эрсдэлтэй бүлэгт хамаарагдах дурангуудыг өндөр түвшний халдваргүйжүүлэх уусмал болох глутаральдегид, устөрөгчийн хэт исэл, шоргоолжны хүчил, ортофталальдегид (OPA) агуулсан бодисоор хүснэгт 1-д заасан зааврын дагуу өндөр түвшний халдваргүйжүүлэлт хийнэ.

## **Гурав. Халдварын өндөр эрсдэлтэй аюултай түвшний бүлэгт хамаарагдах дуран түүний дагалдах хэрэгслийг угаах, ариутгах**

3.1. Мэс заслын дуран түүний дагалдах хэрэгслийн угаалга, ариутгалыг төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэгт хийнэ.

3.2. Мэс заслын дурангийн анхны цэвэрлэгээ, угаалга, хатаалт, ариутгалд дараах зааврыг чанд баримтална.

Анхны цэвэрлэгээ, угаалга	Их хэмжээгээр бохирлогдсон дуранг цус, уураг болон бусад биологийн бохирдол хатахаас өмнө 30 минутаас багагүй хугацаанд хүйтэн урсгал усаар угаана, бохирдолын зэрэг бага бол хаталтаас сэргийлэх зориулалтын детергент* эсвэл энзим* агуулсан бодис шүршиж ариутгалын тасаг, хэсэгт хүргэнэ.
Шалгах	Угаахын өмнө мэс заслын дуран уян бол битүүмжлэлийг шалгах, зориулалтын автомат эсвэл гар даралт хэмжигчийг ашиглах ба хэмжигч байхгүй үед урсгал усны тосгуурт дуранг далд ортол ус хийж хийн бөмбөлөг тасралтгүй гарч байгаа эсэхийг шалгаж үзнэ. Хэрэв битүүмжлэл алдагдсан бол дуранг цэвэрлэж, халдваргүйжүүлэлт хийлгүй засварын хэсэгт илгээнэ.



Дурангийн гадна угаалга	Хагалгааны дуран уян бол орооцолдуулахгүйгээр байрлуулахад хангалттай хэмжээний том, зориулалтын зөөлөвчин ханатай тосгуурт детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч уусмал ашиглаж шүүлтүүрээр шүүгдсэн бүлээн урсгал усаар дурангийн цорго, суваг, холбоос болон бүх салах дагалдах хэрэгслүүдийг салгаж зөөлөн хөөсрүүлэгч материал, алчуураар дурангийн гадна талыг хөөсрүүлэн угаана. Дурангийн оптикийн хэсгийг 70%-ийн этилийн спирт ашиглан цэвэрлэх бөгөөд бохирдол нь сайтар цэвэрлэгдсэн эсэхийг томруулдаг шилээр шалгаж нягтална. Дурангийн үзүүрт тогтсон хатсан зүйлийг хатуу биетээр хусахгүй.
Дурангийн дагалдах хэсгийн угаалга	Хатуу, уян дурангийн бүх салдаг дагалдах хэсгүүдийг салгаж зориулалтын зөөлөн сойз ашиглаж, детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч уусмалаар олон дахин (3-аас доошгүй) сойздож урсгал усанд угаана. Дуран, дагалдах хэрэгслийг (хайчны ир, нугас гэх мэт) шалган зориулалтын тосоор тослох үйлчилгээг хийнэ. Моторын системд зориулалтын шүршигч тосыг хэрэглэнэ. Цахилгаан багажийн тусгаарлалтыг сайтар шалгана. Хатуу болон уян дуран, гэрэл үүсгэгч кабель, тоноглол, призм, резинэн эдлэл, соронзон хавтан, зөөлөн пластик, олон удаагийн гуурс зэргийг хэт авиан ваннд цэвэрлэхгүй. Задаргаа хийдэггүй бүх төрлийн хайч, коагуляцийн багаж, бичил багажийг хэт авиан ваннд цэвэрлэж болно. Хөндийтэй багажийг хэт авиан ваннд налуу байдлаар хөндийд хэт авианы долгион хүрэхээр байрлуулна.
Дурангийн соруулах болон ажлын сувгийг сойздож угаах	Хатуу уян дурангийн ажлын суваг, ус, агаар оруулах, соруулах сувгийг онгорхой байлгаж детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч уусмалаар олон дахин (3-аас доошгүй) зориулалтын зөөлөн сойзоор сойздож, урсгал усанд угаана. Хэт жижиг сувгийг тариур ашиглаж угаана.
Автомат угаалга	Зориулалтын машинаар угааж, цэвэрлэхдээ удаан байлгах нь багаж, хэрэгсэл зэврэх эрсдэлтэй тул бүх эд ангийг тохирсон ховилд тааруулан угсарч тусгай контейнерт хэт их овоололгүй байрлуулан цагийн тохиргоог тааруулан угааж дуусмагц шууд гаргаж авна. Дуранг тусгай контейнергүй угаагч машинд угаахгүй.
Нэгдүгээр зайлалт	Гадна дотор угаалга хийсний дараа дурангийн гадна болон дотор талыг шүүсэн, цэвэр усаар детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч бодисыг арилтал сайтар зайлна.
Хатаах	Дурангийн багаж, хэрэгслийн гадаргуугаас химийн бодисын үлдэгдлийг арилтал сайтар зайлж, хийн буугаар хатаасны дараа үйлдвэрлэгчийн зааврын дагуу ариутгахад бэлтгэн уутлаж (пакетлан) савлана. Хийн буу байхгүй бол 70%-ийн этилийн спиртээр хатаана.
Савлах	Дээрх үйлдлүүдийн дараа дуран болон дагалдах хэрэгслийн цэвэрлэгээг нүдээр харж ариутгалд орж болох эсэхийг шалгана. Шаардлагатай тохиолдолд томруулдаг шил, зориулалтын микроскоп ашиглана. Бэлэн болсон багажийг сав, контейнорт байрлуулахдаа жижиг хэсгийг бүгдийг салгаж хүндээс хөнгөн жинтэйгээр нь хэт их овоолохгүйгээр байрлуулж ариутгалын бодис

	хий, газ чөлөөтэй орохоор байлгана.
Ариутгах	Дуран тус бүрийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тохирсон аргаар ариутгана. Хий газ плазма зэрэг ямарч аргаар ариутгасан ариутгагч аппаратанд савлагдсан дуран түүний дагалдах хэрэгслийг бүхий л талаас нь ариутгалын бодис орохоор байрлуулна.
Хадгалах	Ариутгалын дараа битүүмжилж хагалгааны цэвэр хэсэгт хадгална. Тусгай зориулалтын контейнорт савлагдаж ариутгагдсан бол 1 сар байна.

\*детергент- Угаагч бодис

\*энзим- цус, уураг, өөх тос, нүүрс ус зэрэг биологийн үлдэгдэл задлах бодис

### **Дөрөв. Халдварын дунд зэргийн эрсдэлтэй бүлэгт хамаарагдах дуран түүний дагалдах хэрэгслийг угаах, өндөр түвшингийн халдваргүйжүүлэлт**

4.1 Дуранг угаах, халдваргүйжүүлэх, зайлах, хатаах үйл явц дурангийн бүх ажлын сувагт хийгдэнэ.

4.2. Дуран түүний дагалдах хэрэгслийг угааж, халдваргүйжүүлэх, хадгалахдаа дараах зааврыг баримтална.

Анхны цэвэрлэгээ, угаалга	<ol style="list-style-type: none"> <li>1. Дуранг үйлчлүүлэгчээс сугалж авсан даруйд гэрэл үүсгэгч болон процессороос салгалгүйгээр шууд гадна талыг детергент* эсвэл энзим* шингээсэн нойтон алчуураар удирдлагын хэсгээс төгсгөл хэсэг рүү шувтарч арчин дуранд наалдсан салст цусыг арилгана.</li> <li>2. Агаар, усны сувгийг детергент* эсвэл энзим* агуулсан 200 мл уусмалаар соруулж угаана.</li> <li>3. Сувгийн тохируулагчтай (адаптор*) тохиолдолд тохируулагчийг таглана. Тохируулагчгүй тохиолдолд агаар, усны товчийг зөөлөн болон хүчтэй дарж үлээлгэнэ.</li> <li>4. Дурангийн гэрэл болон агаарын шахуургыг унтрааж гэрэл үүсгүүр болон процессороос салгана.</li> <li>5. Уснаас хамгаалах тагийг углана.</li> <li>6. Зориулалтын тэргэнцрээр ариутгалын тасаг, хэсэгт зөөвөрлөнө.</li> </ol>
Шалгах	Угаахын өмнө дурангийн битүүмжлэлийг шалгах, зориулалтын автомат эсвэл гар даралт хэмжигчийг ашиглах ба хэмжигч байхгүй үед урсгал усны тосгуурт дуранг далд ортол ус хийж хийн бөмбөлөг тасралтгүй гарч байгаа эсэхийг шалгаж үзнэ. Хэрэв битүүмжлэл алдагдсан бол дуранг цэвэрлэж, халдваргүйжүүлэлт хийлгүй засварын хэсэгт илгээнэ.
Дурангийн гадна угаалга	Дуранг орооцолдуудахгүйгээр байрлуулахад хангалттай хэмжээний том, зориулалтын зөөлөвчин ханатай тосгуурт детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч уусмал, шүүлтүүрээр шүүгдсэн бүлээн урсгал ус зэргийг ашиглан дурангийн цорго, суваг, холбоос болон бүх салах дагалдах хэрэгслүүдийг салгаж, зөөлөн хөөсрүүлэгч материал, алчуураар дурангийн гадна талыг хөөсрүүлэн угаана. Дуоденоскопийн дуранг угаахдаа толгой хэсгийн резинэн таг нь салдаг бол салгаж, сойздож угаана.

Дурангийн дагалдах хэсгийн угаалга	Зориулалтын сойз ашиглаж, дурангийн бүх салдаг дагалдах хэсгүүд болох ажлын сувгийн таг, ус, агаар дамжуулах, соруулах сувгийн товч зэргийг детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч уусмалаар олон дахин (3-аас доошгүй) сойздож, урсгал усанд угаана.
Дурангийн соруулах болон ажлын сувгийг сойздож угаах	Детергент* энзим* агуулсан цэвэрлэгч уусмалаар зориулалтын сойз ашиглан ажлын суваг, ус агаар дамжуулах суваг, соруулах сувгийг нэг чиглэлд олон дахин (3-аас доошгүй) сойздож урсгал усаар угаана
Нэгдүгээр зайлалт	Гадна дотор угаалга хийсний дараа дурангийн гадна болон дотор талыг шүүсэн, цэвэр усаар детергент* эсвэл энзим* агуулсан цэвэрлэгч бодисыг арилтал сайтар зайлна.
Өндөр түвшингийн халдваргүйжүүлэлтийг гар аргаар хийх	Дуран халдваргүйжүүлэх бодисыг CDC*, FDA*-ын зөвлөмжийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн бодисоос сонгож, бодисын өтгөрүүлэг, үйлчлэх хугацааг баримтална. Халдваргүйжүүлэх бодисонд дуранг бүрэн далд орсон байхаар хийж тагийг сайтар таглана. Гэхдээ дотор, гадна ажлын сувгуудад бүрэн хүрсэн байх ёстой. Халдваргүйжүүлэх уусмалыг хэрэглэх бүрт шинээр найруулна. Олон удаа хэрэглэж болох бодисын өтгөрүүлэг, үйлчлэх хугацааг индикатороор хянана. Халдваргүйжүүлэлтийн үйл явцыг энэ зааврын 7.1-д заасан хяналтын хуудас хөтөлж баталгаажуулна. Халдваргүйжүүлсэн дуранд цэвэр бээлийтэй харьцана.
Хоёрдугаар зайлалт	Энэ нь халдваргүйжүүлэх бодисын үлдэгдлийг арилгахаас гадна зайлалтын явцад дахин бохирдохоос сэргийлдэг тул шүүсэн буюу ариутгасан ус хэрэглэнэ. Халдваргүйжүүлэх бодисын үлдэгдэл үлдэхээс сэргийлж зайлсан усыг хэрэглэсний дараа шууд асгана.
Хатаах	Хийг дурангийн ажлын суваг дотуур оруулж илүүдэл шингэнийг зайлуулдаг боловч энэ нь сувгийг бүрэн хатаадаггүй тул хадгалахаас өмнө хийгээр үлээлгэн хатаах болон 70% -ийн спиртээр сувгийг зайлж хатаана.
Зориулалтын автомат машинаар халдваргүйжүүлэх	Зориулалтын дуран халдваргүйжүүлэх автомат машин нь халдваргүйтгэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зохих хэмд халааж, халдваргүйжүүлэх хугацааг тохируулдаг байх, дуран халдваргүйжүүлэх бодист бүхлээрээ дүрэгдэх боломжтой байх, халдваргүйжүүлсэн дуранг бүртгэх автомат хяналтын системтэй байх нөхцлийг хангана. Дуран болон салдаг хэсгүүд, дагалдах хэрэгслүүдийг хамтад нь халдваргүйжүүлэх бөгөөд аюулгүй ажиллагааны зааврыг баримтална. Машинд доголдол гарвал дуранг дахин халдваргүйжүүлнэ. <b>Хатаах:</b> Зориулалтын хийн буугаар үлээлгэж хатаана. Хэрэв зориулалтын хийн буу байхгүй бол 70%-н спиртийн 10мл уусмалыг сувгууд руу хийж хатаана.
Хадгалах	Зориулалтын шүүгээнд дурангийн төрлөөс хамаарч босоо байдлаар унжуулж үзүүр хэсгийг газар хүрэхээргүй өлгөөд бүх товч, тагийг салгаж, 7 хоног хүртэл хугацаанд хадгалж болно.

\*адаптор-сувгийн тохируулагч,

\*CDC – Centers for Disease Control, USA

\*FDA – Food and Drug Administration, USA

4.3. Усны шахуургын савыг өдөр бүр хэрэглэсний дараа угааж цэвэрлэн халдваргүйжүүлж, хуурайгаар хадгална.

### **Тав. Дурангийн оношилгоо эмчилгээнд хэрэглэгдэх туслах багажийн хэрэглээ ба ариутгал**

5.1. Дурангийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх туслах багаж нь шууд салст бүрхэвчийг гэмтээдэг халдварын өндөр эрсдэл бүхий аюултай түвшинд хамаарах учир багажийг нэг удаагаар хэрэглэнэ.

5.2. Нэг удаагийн багажийг хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн ариутгалын хүчинтэй хугацаа, битүүмжлэл шошгыг заавал шалгана.

5.3. Олон удаагаар хэрэглэж болох багаж, хэрэгслийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу өндөр даралтын уураар ариутгаж ариутгасан огноо, ариутгалын ажилтны нэр, хугацаа бүхий шошгыг наана.

5.4. Дахин хэрэглэж болох халуунд тэсвэргүй, чийг болон халуунд мэдрэг туслах багаж хэрэгслийг хүснэгт 1-д заасан зааврын дагуу химийн аргаар эсвэл хийн аргаар ариутгана.

5.5. Багажийг олон удаагаар ариутгахдаа бүтээгдэхүүний шинж чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүй байна.

5.6. Зориулалтын битүүмжлэлтэй савлагаатай, өндөр даралтын уур, хийгээр ариутгасан бол 6 сар хүртэл хадгална.

### **Зургаа. Дурангийн ариутгалын чанарыг үнэлэх**

6.1. Дурангийн багажны ариутгалын чанарыг бичил амь судлалын аргаар улирал тутам хянаж, бүртгэл хөтөлнө.

6.2. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үе шат бүрт тохирсон хяналтын хуудсаар хяналт хийнэ.

6.3. Дурангийн суваг дотор 20-30 мл ариун физиологийн уусмал хийж зайлж түүнээс арчдас авч, тэжээлт орчинд шууд тарина.

### **Долоо. Дурангийн багажны ариутгалын үе шатуудад хийгдэх хяналтын хуудас**

7.1. Халдварын өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарагдах, ариутгал шаардагдах дуран, дагалдах хэрэгслийн ариутгалын явцад дараах хяналтын хуудсыг ашиглан хяналтыг тогтмол хийнэ.

<b>Ариутгалын хэлбэр</b>		
<b>Шалгуур</b>	<b>тэмдэглэгээ</b>	<b>тайлбар</b>
Хатаах шүүгээнд хатаахдаа цагийг тэмдэглэх		
Угаалгын чанарыг ямар аргаар үнэлсэн		

Ариутгах аргын нөхцөлийг тэмдэглэх (Даралт, хэм, хийн төрөл)		
Ариутгалд хийсэн хугацаа (эхэлсэн ба дууссан цагийг тэмдэглэх)		
Багажийг тосолсон эсэх (ариутгал хийгдсэн хатуу дуранд хэрэглэх)		
Индикаторийн цаас наасан байх		
Индикаторийн цаас урвал өгсөн эсэхийг шалгах		
Ариутгасан багажны бүрэн бүтэн байдлыг шалгах		
Ариутгагдсан багажны хадгалах хугацаа зөв эсэх		
Багаж хүлээлцэх		

7.2. Халдварын дунд эрсдэлтэй бүлэгт хамаарагдах дуран түүний дагалдах хэрэгслийн өндөр түвшингийн халдваргүйжүүлэлтийг гар аргаар хийх явцад дараах хяналтын хуудсыг ашиглан хяналтыг тогтмол хийнэ.

<b>Өндөр түвшингийн халдваргүйжүүлэх уусмалын нэр</b>		
<b>Шалгуур</b>	<b>тэмдэглэгээ</b>	<b>тайлбар</b>
Дурангийн битүүмжлэлийг шалгасан эсэх		
Дурангийн дотор сувгийг хэдэн удаа сойздож угаасан		
Дуран түүний дагалдах хэрэгсэл уусмалд бүрэн далд орсон байх		
Уусмалд хийсэн хугацааг тэмдэглэх /эхэлсэн ба дууссан цагийг тэмдэглэх/		
Уусмалд дуран түүний дагалдах хэрэгслийг давхарлаж хийхгүй байх		
Уусмалын өтгөрүүлгийг шалгах		
Багажийг тосолсон эсэх (хатуу дуранд хэрэглэх)		
Багажийн бүрэн бүтэн байдлыг шалгах		
Халдваргүйжүүлсэн багажийн хадгалах хугацаа зөв эсэх		
Багаж хүлээлцдэг эсэх		

**Найм. Дуран, дагалдах хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үе шатанд ашиглах хяналтын хуудас**

8.1. Дуран, дагалдах хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үе шатанд хяналтын хуудас ашиглан улирал тутам хяналт хийнэ.

<b>Асуулт</b>	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	<b>Тайлбар</b>
<b>Цэвэрлэгээний өмнөх шат</b>			
1. Өвчтөнөөс дуранг сугалж авах явцад сувагт цэвэрлэгээний шингэн соруулж гадна талыг чийгтэй алчуураар арчдаг уу?			

<b>Гар аргаар цэвэрлэх</b>			
2. Цэвэрлэхээс өмнө бүх хавхлагыг салгаж авсан хэсгийг цэвэрлэдэг үү?			
3. Гараар цэвэрлэгээг хийхдээ зориулалтын угаалтуурт хийдэг үү?			
4. Гараар цэвэрлэгээ хийхээс өмнө битүүмжлэл алдагдсан эсэхийг шалгаж байна уу?			
5. Хэрэв битүүмжлэл алдагдсан бол ямар арга хэмжээ авахаа мэддэг үү?			
6. Цэвэрлэгээний зориулалтын уусмалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөв бэлтгэсэн үү?			
7. Цэвэрлэх явцад бүх сувгуудыг зориулалтын сойзоор угаадаг уу?			
8. Бүх ажлын сувгуудад цэвэрлэгээний уусмал соруулж, гадаргууг нь цэвэрлэгээний уусмал бүхий алчуураар арчиж байна уу?			
9. Бүх ажлын сувгийн дотор, гаднах гадаргууг усаар зайлдаг уу?			
10. Гар аргаар цэвэрлэгээ хийсний дараа дурангийн цэвэр байдлыг нотолсон хяналтын тогтолцоо байдаг уу?			
<b>Халдваргүйжүүлэлт</b>			
11. Хэрэв халдваргүйжүүлэх бодисыг дахин ашиглах боломжтой бол хамгийн бага үр дүнтэй өтгөрүүлэгт байгааг шалгаж, бүртгэсэн үү?			
12. Хэрэв халдваргүйжүүлэх бодисыг нэг удаагаар хэрэглэх бол түүнийг сайтар бэлтгэж, хэрэглэсний дараа асгах уу?			
13. Бүх ажлын суваг болон гаднах гадаргууд үйлчлэх халдваргүйжүүлэх бодисыг зөв сонгодог уу?			
<b>Зайлах</b>			
14. Дурангийн бүх ажлын суваг, гаднах гадаргууг шаардлага хангасан усаар зайлсан уу?			
<b>Автомат машины цэвэрлэгээ</b>			
15. Хэрэв автомат угаалгын машин ашиглаж байгаа бол бүх ажлын сувагт шингэн хангалттай дүрэгдсэн эсэхийг шалгадаг уу?			
16. Усны шинжилгээг хийж, зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг хянадаг уу?			
<b>Хадгалах</b>			
17. Дуранг бохирдол, эвдрэхээс хамгаалж хадгалдаг уу?			
<b>Хөдөлмөр аюулгүй ажиллагаа</b>			
18. Халдваргүйжүүлэх, цэвэрлэх үйл явцын туршид хувийн хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэж байгаа юу?			
19. Халдваргүйжүүлэх бодисын үнэрийг ажлын орчинд гаргах эрсдэлийг бууруулж хадгалдаг уу?			

**Өндөр түвшний халдваргүйжүүлэх бодисын химийн шинж чанар, түүний хэрэглэх заавар (CDC\*, FDA\*-ын зөвлөмж, 2017 оны 2-р сар)**

<b>Химийн шинж чанар</b>	Hydrogen Peroxide (7.5%)	Peracetic Acid (0.2%)	Glutaraldehyde (≥2.0%)	OPA* (0.55%)	Hydrogen Peroxide/ Peracetic acid (7.35%/0.23%)
Өндөр түвшинд халдваргүйжүүлэх шаардлага Хэм, хугацаа	20°C-д 30 минут	Хангахгүй	20 <sup>0</sup> -25 <sup>0</sup> C 20-90 минут	25 <sup>0</sup> C-д 5 минут /АУМ*/, 20 <sup>0</sup> C-д 12 минут	20 <sup>0</sup> C-д 15 минут
Химийн ариутгалын шаардлага Хэм, хугацаа	20 <sup>0</sup> C 6 цаг	50 <sup>0</sup> -56 <sup>0</sup> C 12 минут	20 <sup>0</sup> -25 <sup>0</sup> C 10 цаг	Ашиглахгүй	20 <sup>0</sup> C 3 цаг
Идэвхижүүлэлт	(-)	(-)	Алкалайн глутаральдегидтай хавсрана.	(-)	(-)
Давтан хэрэглэж болох хугацаа (сав баглаа задарснаас хойш)	21 хоног	1 удаа хэрэглэнэ	14-30 хоног	14 хоног	14 хоног
Бодисын тогтвортой байх хугацаа (сав баглаа боодол алдагдаагүй үед хадгалах)	2 жил	6 сар	2 жил	2 жил	2 жил
Материалын тогтвортой байдал	Сайн	Сайн	Маш сайн	Маш сайн	тодорхойгүй
Уусмалын хамгийн доод концентрацийг хянах шаардлагатай түвшин	Тийм (6%)	Үгүй	Тийм (1,5 эсвэл илүү%)	Тийм (0.3% OPA*)	Үгүй
Аюулгүй байдал	Хүчтэй нүд гэмтээгч (аюулгүй шил)	Хүчтэй нүд болон арьс гэмтээгч	Амьсгалын эрхтэн гэмтээгч	Нүд гэмтээгч, арьсан дээр толбо үүсгэнэ.	Нүд гэмтээгч
Халдваргүйжүүлэх арга	Механик болон автомат	Автомат	Механик болон автомат	Механик болон автомат	Механик
Органик материалын эсэргүүцэлт	Тийм	тийм	тийм	тийм	тийм
Зөвшөөрөгдөх өртөлтийн хязгаар (бодистой харьцаж буй ажилтанд)	1ppm	(-)	(-)	(-)	1ppm

\*АУМ – автомат угаалгын машин,

\*OPA – ortho-phthalaldehyde,

\*CDC – Centers for Disease Control, USA,

\*FDA – Food and Drug Administration, USA



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 41537 дугаар тушаалын  
тавдугаар хавсралт

## НҮҮР АМНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврыг эрүүл мэндийн ажиллагсад болон үйлчлүүлэгчийг халдвараас сэргийлэх зорилгоор нүүр амны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бүх эмнэлгүүд, нүүр амны тусламж, үйлчилгээ эрхэлдэг нүүр амны эмч нар, лабораторийн техникч, дадлагажигч, оюутан, гэрээт ажилтнууд дагаж мөрдөнө. Түүнчлэн захиргааны, бичиг хэргийн, үйлчлэгч, засвар үйлчилгээ, сантехникийн ажилтнууд тушаалтай танилцсан байна.

1.2. Нүүр амны тусламж, үйлчилгээг (цаашид НАТҮ гэх) нийгмийн бүх гишүүдэд ялгаварлан гадуурхахгүйгээр үзүүлэх бөгөөд "Халдвартай" гэх үндэслэлээр үйлчлүүлэгчийг эмчлэхээс татгалзах ёсгүй.

1.3. НАТҮ үзүүлдэг мэргэжилтнүүд нь халдварт өвчний үед амны хөндийд илэрдэг шинж тэмдэг, амны хөндийд эмийн бодисын үзүүлэх үр нөлөө, эмийн харилцан үйлчлэл, эмчилгээний үр дүнгийн талаар мэддэг байх ёстой.

1.4. Зарим халдварт өвчний улмаас элэгний болон бөөрний хүнд хэлбэрийн эмгэг, цус бүлэгнэлийн эмгэг, амьсгалын дутал, сэтгэцийн байдал өөрчлөгдсөн болон нүүр амны тусламж, үйлчилгээнд нөлөөлж болзошгүй олон эм ууж байгаа тохиолдолд эмчилгээг түр хугацаагаар хойшлуулж болно.

1.5. НАТҮ үзүүлэх эмнэлгийн байр нь эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй байдлыг хангасан, халуун, хүйтэн усанд холбогдсон, хана, тааз нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой, гадаргуу нь гөлгөр, шал нь хулдаасан, гэрэлтүүлэг, агааржуулалт нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

1.6. Хүүхдийн үзлэг болон эмчилгээний өрөө нь насанд хүрэгсдийнхээс тусдаа байна.

1.7. Үзлэгийн ор хоорондын зай 2 метрээс доошгүй байна.

1.8. НАТҮ-нд халдвараас сэргийлэх, хянах зорилгоор зөвхөн нүүр амны эмчилгээнд ашиглагдах зориулалтын бүтээгдэхүүнийг ашиглана.

1.9. Нэг эмч, 1-2 сувилагч эсвэл нүүр амны туслахтай ажиллана.

1.10. Мөнгөн усны хольцтой /амальгам/ пломбо хэрэглэхийг хориглоно.

1.11. Үзлэгийн өрөөнд багаж, эм, материал болон бусад хэрэгслийг ил задгай хадгалах, байршуулах, амьд болон хиймэл цэцэг, чимэглэл, хивс, дрож гэх мэт тоос, шороо цуглуулах зүйл тавихгүй.

1.12. Үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэхийн тулд халдварын сэргийлэлт, хяналтын байнгын сэргийлэлтийн зарчмыг баримтлан ажиллана.

## **Хоёр: Нүүр амны тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн ажилтны эрүүл мэнд**

2.1. НАТҮ үзүүлэгч байгууллага нь дээд шатны байгууллагаас гаргасан бодлогын баримт бичигтэй нийцсэн, өөрийн эмнэлгийн онцлогт тохирсон халдвараас урьдчилан сэргийлэх, хянах заавартай байх бөгөөд тухайн байгууллагын бүх ажилчдад танилцуулан гарын үсэг зурсан байна.

2.2. НАТҮ үзүүлэгч эмч, бусад ажилтныг жилд 2-оос доошгүй удаа халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр мэдлэг олгох онол, дадлага хосолсон сургалтанд хамруулах бөгөөд энэ чиглэлээр дадлага шалгалт авч мэдлэгийг тогтмол үнэлэн баримтжуулна.

2.3. Ажил олгогч нь дархлаажуулалтын талаар ажилчдад мэдээлэх, дархлаажуулах зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах, шинээр ажилд орж буй ажилтныг дархлаажуулалтад заавал хамруулан баримтыг хувийн хэрэгт хавсаргана.

2.4. Тусламж, үйлчилгээний явцад хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлд хатгагдахаас сэргийлж дараах арга хэмжээг баримтлан ажиллана. Үүнд:

- 2.4.1. Эм, тарилгын шингэн, тариур зэрэгт хүрэхээс өмнө гарын ариун цэврийг сахиж, цэвэр гадаргуу дээр, цэвэр орчинд бэлтгэнэ.
- 2.4.2. Дөрвөн гараар нүүр амны тусламж үзүүлж байх явцад хурц үзүүртэй багаж хэрэгслийг тусгай саванд хийж тусламж, үйлчилгээний цэгт байрлуулан дамжуулна.
- 2.4.3. Тариурын зүүг хэрэглэсний дараа шууд аюулгүй хайрцагт хийх, зайлшгүй тохиолдолд зүүний хошууг буцаан таглах бол “Нэг гарын дүрэм” баримтлана.
- 2.4.4. Хэрэглэсэн зүүг нугалах, хугалахыг хориглоно.
- 2.4.5. Нэг зүүг нэг үйлчлүүлэгчид олон удаа хэрэглэх тохиолдолд хэрэглээ бүрийн хооронд зүүг заавал таглана.
- 2.4.6. Нэг тарилгад нэг зүүг хэрэглэнэ. Өөр хүнд дамжуулж хэрэглэхийг хориглоно.
- 2.4.7. Нэг тарилгын шингэнээс (шүдний мэдээ алдуулалтын тариа) олон үйлчлүүлэгчид хэрэглэхгүй, туншилд үлдсэн тарилгын уусмалыг нийлүүлж хэрэглэхийг хориглоно.
- 2.4.8. Зүү, тариурыг тарилгын уусмал хадгалах зорилгоор ашиглахгүй.
- 2.4.9. Нэг тунт тарилгыг хэрэглэсний дараа шууд хаяна.

2.5. Халдварт өртсөн тохиолдолд холбогдох заавар, журмын дагуу арга хэмжээг авч ажиллана.

2.6. Шүдний эмч, мэргэжилтэнүүд сүрьеэгийн халдварыг илрүүлэх, оношилгоо, эмчилгээний чиглэлээр сургалтанд хамрагдсан байна.

### **Гурав. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл**

3.1. НАТУ-ний явцад цацагдсан шүлс, цус, усны дуслаас халдварт өртөх эрсдлээс сэргийлж нүдний салст бүрхэвч, амьсгалын замын салст бүрхэвчийг хамгаалах зорилгоор хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэнэ.

3.2. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг эмчилгээний бүсийн гадна байрлуулах бөгөөд дахин ашиглах зориулалттай хамгаалалтын нүдний шил, нүүрний хаалтыг үйлчлүүлэгч бүрийн дараа үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэнэ.

3.3. НАТУ-нд нэг удаагийн хэрэглээнд зориулсан бээлий хэрэглэнэ. Бээлий хэрэглэхээс өмнө, бээлий тайлсны дараа, хэрэглэж байх явцад урагдах, цоорсон тохиолдолд, дараагийн үйлчлүүлэгчид үзлэг хийх хооронд гарын ариун цэврийг заавал сахина.

3.4. Удаан үргэлжлэх ажилбарын үед бээлийг 90 минутаас дээш хугацаагаар өмсөхгүй бөгөөд өмсөх шаардлагатай бол гарын ариун цэврийг сахисны дараа шинэ бээлий хэрэглэнэ.

3.5. Эмчилгээний үед цус, шүлс цацагдахаас сэргийлж хамар, ам, эрүүг бүрэн халхалсан амны хаалтыг хэрэглэх бөгөөд үйлчлүүлэгчийг үзэх бүрт сольж хэрэглэнэ.

3.6. Сүрьеэгийн микобактер зэрэг агаараар дамжих халдварын үед урьдчилан сэргийлэхийн тулд N95, N99 эсвэл N100 шүүлтүүртэй амны хаалт өмсөнө.

3.7. Нүүр амны эмчилгээний явцад шүдний хагархай, эмтэрхий, чулуу үсрэх зэргээс үйлчлүүлэгчийг хамгаалж нүдний шил болон нүүрний хэсгийг хамгаалах даавуу хэрэглэнэ.

3.8. Амны хөндийн тусламж, үйлчилгээний үед гар болон биеийн бусад хэсэг бохирдохоос сэргийлж урт ханцуй бүхий нэг удаагийн халадыг өмсөнө.

3.9. Нэг удаагийн халад, малгайг тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө өмсөж, үйлчилгээ дууссаны дараа, харагдахуйц бохирдсон тохиолдолд аль болох хурдан солино.

3.10. Нэг удаагийн халадыг эмнэлзүйн бүсээс гадна хэрэглэхгүй, дүрэмт хувцсыг эмнэлгээс гадуур өмсөхийг хориглоно.

3.11. Эмнэлгийн гутал нь урдуураа битүү байх бөгөөд эмнэлгээс гадуур өмсөхийг хориглоно.

3.12. Лазер болон электрон мэс заслын багаж ашиглаж нүүр амны тусламж үзүүлэх эмчилгээний өрөө нь утаа шүүх сорох системтэй байх бөгөөд ажилтан нь шүүлтүүртэй амны хаалт, нүүрний хаалт хэрэглэнэ.

3.13. Рентген зураг авах, бохирлогдсон PSP-ийн хальс барих үедээ бээлий болон бусад хамгаалах хэрэгслийг өмсөнө.

3.14. Эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан тусламж, үйлчилгээний явцад ээмэг, бөгж, бугуйвч, энгэрийн зүүлт зэрэг гоёл, чимэглэл зүүхийг хориглоно.

### **Дөрөв. Амьсгалын замын эрүүл ахуй, үйлчлүүлэгчийн эрүүл мэнд**

4.1. Томуу, томуу төст өвчин болон амьсгалын замын халдварын дэгдэлтийн үед үйлчлүүлэгч болон асран хамгаалагчийг амьсгалын замын халдвараас сэргийлэх

арга хэмжээ, ач холбогдлыг ойлгуулах, ханиалгах, найтаах үедээ ам, хамраа цаасан салфеткаар таглах эсвэл тохойгоо нугалж таглах, хэрэглэсэн, бохирдсон салфеткыг хогийн саванд хаях, гарын ариун цэврийг сахих, бусад үйлчлүүлэгчдээс дор хаяж нэг метрийн зайд суухыг зөвлөнө.

4.2. Гарын ариун цэвэр сахих нөхцлийг бүрдүүлсэн байна. Гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодисыг хүлээн авах, хүлээлгийн хэсэгт байрлуулна.

4.3. НАТУ авах үйлчлүүлэгч ханиалгаж буй үед амны хаалтаар хангана.

4.4. НАТУ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгч бүрийн амны хөндийг спирт агуулаагүй, бичил биетний эсрэг үйлчилгээтэй ам зайлах уусмалаар зайлуулна.

4.5. НАТУ үзүүлэгч эмч, мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгчдээс сүрьеэгийн халдвараар өмнө нь өвчилж байсан эсэх, одоо илэрч байгаа шинж тэмдэг зэргийг асуумжаар авч урьд нь өвдөж байсан эсвэл илэрхий шинж тэмдэг бүхий оношлогдоогүй идэвхитэй сүрьеэгийн халдвартай үйлчлүүлэгчийг агаарын сөрөг даралттай, HEPA шүүлтүүртэй өрөөнд тусгаарлан N95 амны хаалт зүүж тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.6. Сүрьеэгийн халдвартай үйлчлүүлэгч эмчилгээнд хамрагдан халдваргүй болох эсвэл сүрьеэгийн эсрэг эмчилгээг 48 цагаас дээш хугацаанд хийлгэх хүртэл шүдний эмчилгээг хойшлуулна.

#### **Тав. Орчны халдварын сэргийлэлт, хяналт, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт**

5.1. НАТУ үзүүлж байгаа үзлэгийн өрөөг дараах байдлаар ангилан, халдвараас сэргийлэх зааврыг баримтлан ажиллана.

<b>Бүс</b>	<b>Тоног төхөөрөмж, багаж, хэрэгслүүд</b>	<b>Ажиллах эмнэлгийн мэргэжилтэн</b>	<b>Баримтлах дэглэм</b>
Эмчилгээний бүс	Нүүр амны тусламж, үйлчилгээний тоноглол бүхий үзлэгийн ор, орны дагалдах хэрэгсэл, тавцан, өрөмний суурь, рентген зураг харах дэлгэц, соруулгын хошууны суурь болон хоолойнууд, шүлсний сав,	Эмч дангаараа буюу сувилагч НА-ны туслахын хамт	<p>✓ Үзлэг бүрийг эхлэхийн өмнө тухайн эмчилгээнд хэрэглэгдэх багаж, хэрэгслийг тавиур дээр байршуулна. Мөн рентген зураг, нэг удаагийн бохирын сав, энгэрэвч зэргийг үзлэгийн тавцанд тавьж бэлдэнэ.</p> <p>✓ Үзлэг бүрийн өмнө үйлчлүүлэгчид нэг удаагийн хэрэгсэл болон ариун багажийн бүрэн бүтэн байдал, хүчинтэй хугацааг танилцуулна.</p> <p>✓ Тоног төхөөрөмжийн солих боломжгүй хүрэлцэх гадаргуу, ус, агаар, соруулагчийн бариул, пломбо, шарах гэрлийн аппаратны хошуунд нэг удаагийн</p>

	<p>тосгуурын цорго, сандлын товчлуур, эмч сувилагчийн үзлэгийн сандал</p>		<p>хамгаалалтын наалт наана.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Үзлэг бүрийн дараа хамгаалалтын наалт, ороогч цаасыг гадаргууг бохирдуулахгүйгээр авна.</li> <li>✓ Үзлэг, эмчилгээний явцад бохирлогдсон хөвөн, марль, хазалтын цаас, сувгийн цаас, илүүдэл материал зэргийг хог хаягдлын бохирын сав руу шууд хаяна.</li> <li>✓ Сувгийн эмчилгээний үед бохирдсон суваг өргөсгөгчийг <i>ариутгасан материалаар</i> цэвэрлэнэ. Ариутгасан материалыг үжлийн эсрэг уусмалаар норгож чийглэнэ.</li> <li>✓ Үзлэг, эмчилгээ дуусмагц хэрэглэгдсэн нэг удаагийн багаж хэрэгслийг устгалд оруулна.</li> <li>✓ Давтан хэрэглэгдэх бохир багаж, хэрэгслийг хэрэглэсэн даруйд ариутгалын тасаг, хэсэг рүү шууд зөөвөрлөнө.</li> <li>✓ Үзлэгийн ор бүрийн хажууд аюулгүй хайрцгийг байрлуулна.</li> <li>✓ Өрөө бүрт гарын угаалтуур, шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгч, гишгүүр бүхий эмнэлгийн хог хаягдлын сав байна.</li> <li>✓ Бага бохирдолттой хэсгийн гадаргуугаас эхлэн бохирдол ихтэй хэсгийн гадаргуу руу нэг чиглэлээр арчиж халдваргүйжүүлнэ.</li> <li>✓ Өрөм болон хий, усны, чулуу авагчийн хошууны суурь, хоолойн гадаргууг маш их бохирдолтой гэж үзэн халдваргүйжүүлэх бодис шүршиж, арчих эсвэл халдваргүйжүүлэх бодистой нэг удаагийн материалаар арчина.</li> <li>✓ Үзлэгийн орны тавцанд</li> </ul>
--	---	--	--

			<p>багаж, материалыг байнга байршуулах, үлдээхийг хориглоно.</p> <p>✓ Тухайн өдрийн үзлэг дууссаны дараа үзлэгийн орны усны шугамын хоолойн халдваргүйжүүлэлтийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийнэ.</p> <p>✓ Усны хоолойн шүүлтүүрийг үзлэг дууссаны дараа халдваргүйжүүлэн цэвэрлэж хатаасан байна.</p>
Цэвэр бүс буюу дээрх бүсээс гадагш 1-1,5 м зайд хамаарах хэсэг	Ариутгасан багаж хэрэгсэлтэй сав, хөвөн, самбай, ариун бээлий, гэрлийн аппарат хэрэгсэл, эмчилгээний болон пломбоны материалууд ханын шүүгээ саванд далд байрлана.	Сувилагч эсвэл НА-ны туслах	<p>✓ Цэвэр бүсийн сувилагч 2-3 эмчийн дунд ажиллаж болно.</p> <p>✓ Ариутгасан багаж хэрэгслийг ханын битүү шүүгээ саванд цэвэр орчинд хадгална.</p> <p>✓ Ариутгасан багажны савалгаан дээр ариутгасан, хүчинтэй байх огноог тэмдэглэсэн байна.</p> <p>✓ Ариутгасан багажийг ариутгасан хугацаагаар нь эхэлж хэрэглэх байдлаар байршуулна.</p> <p>✓ Хэрэглэхийн өмнө уутны бүтэн байдал алдагдаж бохирдох, хадгалах хугацаа дууссан эсэхийг хянана.</p> <p>✓ Цэвэр бүсийн сувилагч нь гарын эрүүл ахуйн дэглэмийг баримтлан эмнэлзүйн бүсэд ажиллаж байгаа эмч, сувилагчид шаардлагатай ариун багаж, цэвэр материалыг зааврын дагуу нэмэлтээр бэлдэж, дамжуулж өгнө.</p> <p>✓ Гэрлээр хатуурагч хуванцар материалыг хэрэглэх тохиолдолд зориулалтын саванд таслан авч, дамжуулж өгнө.</p> <p>✓ Үзлэг эхлэхийн өмнө ба дараа гадаргуугийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.</p> <p>✓ Цэвэр бүсийн сувилагч эмчилгээний бүсэд давхар</p>

			<p>ажиллахгүй.</p> <p><u>Цэвэр бүсэд ажиллах сувилагч түр хугацаагаар байхгүй тохиолдолд:</u></p> <p>✓ Эмчилгээний бүсэд ажилласан бээлийтэй гараар цэвэр бүсэд нэвтрэх, ариун багаж, цэвэр материал, эд зүйлстэй харьцахыг хориглоно.</p> <p>✓ Цэвэр багаж, материалтай харьцах үед нэмэлтээр цэвэр хямсаа хэрэглэнэ.</p> <p>✓ Хямсаагаар авах боломжгүй нягт эргэдэг таглаатай, сав баглаа боодолтой зүйлтэй харьцах тохиолдолд бээлийг тайлж, гарыг угаасны дараа дахин бээлий өмсөж харьцана.</p>
Эрсдэлгүй бүс буюу цэвэр бүсээс гадагш хамаарах бүх хэсэг	Эмчийн тэмдэглэл хөтлөх ширээ, журнал, компьютер, үзэг, үзлэгийн карт	Эмч, сувилагч	<p>✓ Үзлэг эхлэхийн өмнө ба дараа гарын эрүүл ахуйг сахина.</p> <p>✓ Үйлчлүүлэгчид хэрэглэгдсэн ариун багажны хяналтын цаасан туузыг үйлчлүүлэгчийн карт буюу журналд наана.</p>

5.2. Дээрхи бүсүүдэд үзлэг бүрийн дараа эрсдэлгүй бүсээс эхлэн цэвэр бүс, эмчилгээний бүс гэсэн дарааллаар халдваргүйжүүлэлт хийнэ.

5.3. Орчны гадаргууг эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу, туслах ажлын гадаргуу гэж ангилан дараах байдлаар цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийнэ.



### Орчны гадаргуугийн ангилал, халдваргүйжүүлэлт цэвэрлэгээ

Гадаргуу	Хамаарагдах хэсэг, багаж тоног төхөөрөмж		Бохирлогдох байдал	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх
Эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу	Эмнэлгийн ажилтны гар шууд хүрэлцэх гадаргуу, үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээний хэсэг.	<ul style="list-style-type: none"> <li>• Гэрлийн гар</li> <li>• Унтраалга</li> <li>• Зураг авах багаж хэрэгсэл</li> <li>• Суудлын дэлгэц бүхий товчлууур, хяналтууд</li> <li>• Давтан хэрэглэх сав, шүдний материал</li> <li>• Сугардаг ширээний бариул</li> <li>• Усны хаалтны бариул</li> <li>• Хаалганы бариул</li> <li>• Компьютерийн гар</li> </ul>	Эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу нь цус, шүлс, биеийн шингэн эсвэл биеийн шингэний агууламжтай ус цацагдан бохирдсон гадаргуу эсвэл эмнэлгийн ажилтны бээлийтэй гараар хүрэлцсэн гадаргуу	Эмчилгээний үед хүрэлцсэн бүх гадаргууг тухайн өдрийн ажил дууссаны дараа болон үйлчлүүлэгч хооронд халдваргүйжүүлэн цэвэрлэнэ.
Туслах гадаргуу	Халдвар дамжих эрсдэлийн хувьд харьцангуй хязгаарлагдмал гадаргуу.	Шал, хана, цонх, хөшиг, цонхны хөшиг, угаалтуур, хаалга	Эмнэлгийн ажилтны гар хүрэлцэх, бохирлогдсон шингэн асгарах, цацагдах үед бохирлогдоно.	Хэрвээ гадаргуу цус, шүлс, биологийн шингэнээр бохирлогдвол халдваргүйжүүлэгч уусмал хэрэглэн цэвэрлэгээ хийнэ.

5.4. Эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу, тоног төхөөрөмж нь цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд төвөгтэй, тухайн гадаргуу химийн бодист мэдрэг бол бохирдлоос хамгаалахын тулд чийг нэвтрүүлдэггүй, тунгалаг пластик материал бүхий хамгаалалтын наалтыг хэрэглэнэ.

5.5. Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлж дууссаны дараа хамгаалалтын наалтыг бээлийтэй гараар цуглуулан авч хог хаягдлын саванд хаяна.

5.6. Хамгаалалтын наалтыг авсны дараа эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу санамсаргүй байдлаар бохирдсон эсэхийг сайтар шалгаж хэрвээ бохирдсон бол халдваргүйжүүлэн угааж цэвэрлэнэ.

5.7. Хамгаалалтын наалтыг авсны дараа бээлийг тайлж гарын ариун цэврийг сахиж, дараагийн үйлчлүүлэгчид үйлчлэхээс өмнө цэвэр наалтыг наана.

5.8. Эрүү нүүрний жижиг мэс ажилбар (шүд авахаас бусад), шүдний имплант хийх эмнэлэг нь мэс ажилбарын өрөөтэй байх ба өрөө нь мэс заслын өрөөнд тавигдах шаардлагыг хангасан байна. Мэс ажилбарын өрөө нь шүдний ор, мэс заслын ор, шүлс соруулагч зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж, эм, багаж, хэрэгслээр хангагдсан, тоног төхөөрөмжид хамгаалалтын наалтыг хэрэглэж халдвараас сэргийлэх зааврыг мөрдөнө.

5.9. Мэс ажилбарын өрөөнд ажиллах эмч, сувилагч ариун бээлий, халад, малгай өмсөж ариун багаж хэрэгслийг ашиглаж 6 гараар (1 эмч, 2 сувилагч) ажиллана. Мэс ажилбарын өрөөгүй, шаардлага хангаагүй эмнэлэгт эрүү нүүрний жижиг мэс ажилбар (шүд авахаас бусад), имплант хийхийг хориглоно.

5.10. Хамгаалалтын наалт наасан, наагаагүй байснаас үл хамааран үзлэг бүрийн дараа өдөр бүр ажлын эхэнд болон төгсгөлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.

5.11. Хамгаалалтын наалт, ороогч гялгар цаасыг нэг удаа хэрэглээд хаяна.

5.12. Цус, шүлс, биологийн шингэн асгарсан цацагдсан тохиолдолд холбогдох зааврын дагуу халдварын эрсдэлийг багасгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

5.13. НАТҮ-ний явцад ялгарч байгаа хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг холбогдох тушаал, журам, зааврын дагуу гүйцэтгэнэ.

### **Зургаа. Нүүр амны тусламж, үйлчилгээний үеийн усны систем**

6.1. Шүдний өрмийн төхөөрөмж, хэт авиан цэвэрлэгч, үйлчлүүлэгчийн нүүр амны эмчилгээ, ам зайлахад хэрэглэгдэх ус нь шүүсэн ус байна.

6.2. Ус халаагч, крантны усыг нүүр амны тусламж, үйлчилгээнд, шүдний тоног төхөөрөмжид хэрэглэхгүй.

6.3. Шүдний эмнэлгийн усны системн усыг жилд 1 удаа шинжилгээнд өгч нян судлал, химийн үзүүлэлтийг шинжлүүлэн баримтжуулна.

6.4. Ажил эхлэхийн өмнө 2 минутын турш шугам хоолойгоор ус, хийг гүйлгэж, үзлэг бүрийн дараа хэрэглэгдсэн хэт авианы чулуу авагч, хий, усны шүршүүр зэрэг хүний ам руу ордог ус, хийтэй холбоотой бусад төхөөрөмжийн ус ба хийг 20-30 секундын турш гүйлгэнэ.

6.5. Ус бүхий савыг солихдоо цэвэр бээлийтэй гараар, усны системийн гуурсанд хүрэхгүйгээр солих ба савыг суллан угааж, халдваргүйжүүлж, хатаана.

6.6. Мэс заслын үед хэрэглэгдэх ус нь ариун ус байна.

### **Долоо. Багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал**

7.1. НАТҮ-ний эмнэлэг нь дотроо ариутгалын тасаг болон хэсэгтэй, ариутгалын хэсэг нь 8м<sup>2</sup> аас доошгүй талбайтай байна.

7.2. Ариутгалын тасаг, хэсэг нь нэг чиглэл урсгалтай, багаж хүлээн авах, цэвэрлэн халдваргүйжүүлэх бохирын хэсэгтэй, бэлтгэн савлах, ариутгах, хадгалах цэврийн хэсэгтэй байх бөгөөд хэсгүүд нь хана эсвэл хаалтаар тусгаарлагдсан дундаа цонхтой байхаас гадна зориулалтын багаж, тоног төхөөрөмж, ажлын байр, мэргэшсэн ажилтантай байна.

7.3. Ариутгалын тасаг, хэсэг ажиллуулах боломжгүй тохиолдолд энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын шаардлага хангасан газарт гэрээгээр гүйцэтгүүлнэ.

7.4. Ариутгалын тасаг, хэсэг нь нүүр амны тусламж, үйлчилгээний төрөл, хэрэглэгдэж буй багаж материалын тоо, овор, хэмжээнээс хамааран дараах тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, анхан шатны бүртгэл маягтуудтай байна.

7.5. НАТҮ үзүүлэгч эмнэлгийн ариутгалын тасаг, хэсэг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон халдваргүйжүүлэлт, ариутгалын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл хяналттайгаар суурилуулан ажиллуулна.

7.6. НАТҮ-нд хэрэглэгдэх багаж хэрэгслийг бохирдлын түвшнээс нь шалтгаалж халдварлах эрсдлээр нь өндөр эрсдэлтэй, дунд эрсдэлтэй, бага эрсдэлтэй гэж ангилна.

Эрсдэл	Хэрэглэгдэх байдал	Хамаарах багаж, хэрэгслүүд	Ариутгах, халдваргүйжүүлэх аргууд
Өндөр эрсдэлтэй	Яс, зөөлөн эд, цусны урсгалд нэвтэрдэг багажууд	<ul style="list-style-type: none"> <li>Хэсгийн мэдээ алдуулалтын тариур (төмөр шприц)</li> <li>Сувгийн багажнууд (гар болон машины файл, ример)</li> <li>Мэс заслын самбай</li> <li>Шүдний имплантын багажнууд</li> <li>Төмөр матриц (хэрэглэхийн өмнө)</li> <li>Амны толь (эдийг зүсэж гэмтээсэн ажилбарын үед ашигласан)</li> <li>Гажиг заслын банд (хэрэглэхийн өмнө)</li> <li>Тулгуур эдийн багажнууд (ультрасоникийн хошуу)</li> <li>Нүүр амны эмчилгээнд</li> </ul>	Даралтат уураар болон хуурай халуунаар ариутгана.

		<ul style="list-style-type: none"> <li>хэрэглэгддэг багажнууд</li> <li>• Өрмийн толгой болон алмазан бор</li> <li>• Рабар дамны бөгжнүүд</li> <li>• Чулуу авагчууд</li> <li>• Зэвэрдэггүй ган бүрээсүүд (хэрэглэхийн өмнө)</li> <li>• Мэс заслын багажнууд</li> <li>• Мэс заслын шүлс сорогчын хошуу</li> </ul>	
Дунд эрсдэлтэй	Гэмтсэн арьс, салст бүрхэвчинд хүрэх	<ul style="list-style-type: none"> <li>• Хазалтын цаас баригч</li> <li>• Агаар хийн хошуу</li> <li>• Өрмийн бариул</li> <li>• Цөгц доргиогч</li> <li>• Рабар дамны хүрээ болон бахь</li> <li>• Хэвний халбага</li> <li>• Шүдний лабораторийн бор</li> <li>• Хамрын маск</li> <li>• Гажиг заслын бахь</li> <li>• Голлосон хоршихуй тодорхойлогч</li> <li>• Лабораторийн хутга, шпатель</li> </ul>	Хуурай халуунаар ариутгана. Халуунд мэдрэг багаж хэрэгслийн өндөр түвшний халдваргүйтгэл Нэг удаагаар хэрэглэнэ.
Бага эрсдэлтэй	Гэмтээгүй арьс, салстад хүрэх	<ul style="list-style-type: none"> <li>• Даралтны аппарат</li> <li>• Гэрлийн аппарат</li> <li>• Рентгены хормогч</li> <li>• Амны камер болон рентгены сенсор</li> <li>• Рабар дамны цоологч</li> <li>• Лабораторийн тусгай багажнууд</li> </ul>	Дунд түвшний халдваргүйтгэгч бодисоор халдваргүйжүүлнэ.

а. Багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг уг тушаалын 2 дугаар хавсралтын дагуу хийнэ.

б. Хэт авиан цэвэрлэгчийг ашиглаж байгаа тохиолдолд түүний хэвийн үйл ажиллагааг сард 1 удаа “Foil” сорил тавин шалгана.

i. “Foil test”-ийг хийхдээ хэт авиан цэвэрлэгчийн савны урт ба гүнтэй тэнцүү хөнгөн цагаан тугалган цаасыг авч хэт авиан цэвэрлэгчийн шингэн рүү босоо байрлалд 30 секундын турш дүрнэ. Тугалган цаас нь савны ёроолд хүрч болохгүй.

ii. Хэт авиан цэвэрлэгчийг дээд хэмжээгээр ажиллуулахад тугалган цаасан дээр 1-ээс 4 мм диаметр хэмжээ бүхий нүхнүүд үүсч цооролт бий болно. Энэ тохиолдолд хэт авиан цэвэрлэгчийг хэвийн ажиллаж байна гэж үзэн цаасан

дээр он сар өдөр, цаг минут, гарын үсгийг бичиж хадгална. Хэрэв тугалган цаасны туршилтыг ажлын эхэнд хийсэн бол хэт авиан цэвэрлэгч дэх уусмалыг тугалгаар бохирдсон гэж үзэн багаж хэрэгслийг цэвэрлэхээс өмнө шингэнийг асгаж шинээр уусмалыг хийнэ.

с. Нэг удаагаар хэрэглэх багаж, хэрэгсэлд доор дурдсан багаж хэрэгсэл багтах бөгөөд үзлэг, эмчилгээнд хэрэглэсний дараа аюулгүй хайрцаг, эмнэлгийн хог хаягдлын саванд шууд хаяна. Үүнд:

- Зүү, нэг удаагийн тариур, тариа
- Хутганы ир, оёдлын утас
- Багс
- Зөөлц авагч
- Сувгийн хар зүү
- Брекет
- Бөгж
- Нум
- Тюба
- Легатурын утас
- Резин (өнгийн, холбогч, татлагын, зай гаргагч)
- Урьдчилан сэргийлэх үзлэгт зориулагдсан үзлэгийн багц
- Цаасан энгэрэвч, гадаргуугийн наалт
- Бээлий
- Шүлс сорогчийн хуванцар нарийн хошуу
- Ус, агаар шүршигчийн хуванцар хошуу

### **Найм. Шүдний өрмийн бариул ба бусад туслах багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал**

8.1. НАТҮ-ний хурдан болон удаан эргэлтийн өрмийн бариул, мэс заслын өрмийн бариул, өнгөлгөөний резинэн бариул, шулуун өрмийн бариул, ультрасоник, чулуу авагчийн хошуу болон бариул, сувгийн өрмийн бариулууд, өнгөлгөөний багаж (агаараар үлээлгэгч), агаар, усны хошуу зэрэг багажнууд нь амны хөндийгөөс шүлс шингэнийг дотор хэсэгрүү сорсоноор бохирдуулдаг тул дээрх багаж хэрэгслийг хэрэглэсний дараа 20 секундын турш ус хийг зэрэг үлээлгэн ажиллуулж ус, хийн шугам хоолойд орсон шүлс, бохирлогдсон шингэнийг гадагшлуулсны дараа зориулалтын бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

8.2. НАТҮ-ний хурдан болон удаан эргэлтийн өрмийн бариул, мэс заслын өрмийн бариул, өнгөлгөөний резинэн бариул, шулуун өрмийн бариул, ультрасоник, чулуу авагчийн хошуу болон бариул, сувгийн өрмийн бариулыг зориулалтын автоклавт ариутгана.

8.3. Үзлэгийн орны ус, хийн шугамнаас салах боломжтой амны хөндийд нэвтэрч буй багажуудыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж, тослон, ариутгана.

8.4. Үзлэгийн оронд бэхлэгдсэн салгаж болохгүй багаж хэрэгслийн (моторын гар, ультрасоник багажны гар, шүлс сорогч, өндөр давтамжит соруул, ус хийн хошууны бариул) хэсгүүдийг хэрэглэхийн өмнө халдваргүйжүүлэх эсвэл хамгаалалтын наалт нааж хэрэглээ бүрийн дараа солино.

8.5. Шүлс сорогч ашиглаж байх явцад үйлчлүүлэгчийн амыг хаалгаж сорогч хошууны орчим сөрөг даралт үүсгэхийг хориглох бөгөөд үйлчлүүлэгч хооронд шүлс сорогчийн хошууг 20 секундын турш хүчтэй усаар соруулж цэвэрлэнэ.

8.6. Сорогчийн шугам хоолойг зориулалтын бодисоор өдөр бүр цэвэрлэнэ.

8.7. Үзлэгийн орны сорогчийн шүүлтүүрийг байнга шалгаж шаардлагатай үед солино.

8.8. Халуунд тэсвэртэй, амны хөндийд ордог рентгений хэрэгсэл болох хальс баригч, чиглүүлэгч зэргийг үйлчлүүлэгч хооронд бага эрсдэлтэйд тооцон химийн аргаар халдваргүйжүүлнэ.

8.9. Рентген туяа өгөгч толгой хэсэг, удирдлагын хэсэг зэрэг гар хүрэх хэсгүүд, бохирлогдсон PSP- гийн болон энгийн хальсыг үйлчлүүлэгч хооронд цэвэрлэж халдваргүйжүүлэх эсвэл хамгаалалтын наалт нааж солино.

8.10. Зураг авсны дараа бохирлогдсон PSP -г халдваргүйжүүлж, цэвэр гадаргуу дээр хальсыг тавина. Бусад гадаргууг бохирдуулалгүйгээр уутыг хаяна.

8.11. Бээлийгээ тайлж, хальсыг боловсруулалт хийнэ. Хальс боловсруулах төхөөрөмжийг бохирдуулахаас сэргийлж хамгаалалтын наалт наана. Бохирдсон гадаргууг цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

8.12. Дижитал рентгений PSP, сенсор болон бусад холбогдох тоног төхөөрөмжийг (амны камер, тулгуур эдийн электрон багаж, хоршилтын анализатор, лазер) хэрэглэхийн өмнө хамгаалалтын наалтаар бүрж, дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхээс өмнө үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлнэ.

8.13. Авагдсан шүдийг үйлчлүүлэгчид өгөх бол нүдэнд харагдахуйц цус бохирдлыг цэвэрлэж өгнө. Сургалтын зорилгоор ашиглах тохиолдолд цус бохирдлыг цэвэрлэсний дараа 10%-ийн формалины уусмалд 14 хоног байлгана.

8.14. Шүдний лабораторид шүдний өнгө, хэмжээг тохируулах зорилгоор илгээж байгаа тохиолдолд цэвэрлэж халдваргүйжүүлэн битүүмжлэлтэй саванд хийж тээвэрлэнэ.

8.15. Авагдсан шүд амальгаман пломбогүй бол эмнэлгийн гаралтай халдвартай хог хаягдалд, амальгам пломботой тохиолдолд холбогдох тушаал, зааврын дагуу устгана.

### **Ес. Шүдний лабораторийн халдварын сэргийлэлт, хяналт**

9.1. Шүдний лабораторийг материал хүлээн авах, халдваргүйжүүлэх хэсгээр тусад нь зохион байгуулна.

9.2. Шүдэлбэр, зэмсэг, хэв, урьдал хийц, шүдэлбэр, голлосон хоршихуй тодорхойлогч, хазалтын төлөв тодорхойлогч зэргийг эмнэлгийн доторх болон гаднах бусад лаборатори руу илгээхийн өмнө зайлж цэвэрлэн чийгтэй байгаа хэв, зэмсэгийг шингэн нэвчихгүй саванд хийж зөөвөрлөнө.

9.3. Тухайн материалыг халдваргүйжүүлэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтална.

9.4. Гэрээт лаборатори руу материалыг зөөвөрлөх тохиолдолд холбогдох журмыг баримтална.

9.5. Шүдний лабораторийн ажилтны харьцаж буй хэв, загвар, шүдэлбэр зэрэг материалд бохирдол илэрвэл цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

9.6. Лабораторид хэрэглэгддэг багаж хэрэгсэл бор, өнгөлгөөний хэрэгсэл, чулуун өнгөлгөө, лабораторийн хутга, үелүүр, зорогч, шүдэлбэрийн сав, усны танк, прессорыг үйлчлүүлэгч хооронд үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэн халдваргүйжүүлж ариутгана. Нэг удаагийн хэрэглээний багаж, хэрэгслийг дахин хэрэглэхгүй, иртэй багажийг (бор, ир, гажиг заслын утас) аюулгүйн хайрцагт хаяна.

9.7. Амны хөндийд ороогүй шинэ шүдэлбэрт хэрэглэх өнгөлгөөний бор хэрэгслийг 7 хоногт нэг удаа өнгөлгөөний суурийг суллаж угааж халдваргүйжүүлэн ариутгана. Чулуун өнгөлөгчийг долоо хоногт 1 удаа халдваргүйжүүлнэ.

9.8. Засвар шүдэлбэрийг засварлах тохиолдолд өнгөлөх хэсэгт орохоос өмнө халдваргүйжүүлэх бөгөөд өнгөлгөөний хэрэгслүүдийг хэрэглэсний дараа цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Чулуун өнгөлгөөг халдваргүйжүүлэгч ашиглан чийглэх бөгөөд хэрэглэсний дараа шууд хаяна. Мөн тавцанг угааж халдваргүйжүүлнэ.

9.9. Амны хөндийд хэрэглэгддэг халуунд тэсвэртэй багаж (металл хэвний халбага, голлосон хоршихуй тодорхойлох төхөөрөмж) хэрэгслийг дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхийн өмнө цэвэрлэн халдваргүйжүүлж ариутгана.

9.10. Шүдний лабораторийн ажилтан цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийх явцад хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

9.11. Орчны гадаргууд хамгаалалтын наалт наах эсвэл цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

9.12. Лабораторийн хог хаягдлыг холбогдох тушаал, зааврын дагуу устгана.

9.13. Биопсийн сорьцыг холбогдох тушаал, зааврын дагуу хадгалж, тээвэрлэнэ.

#### **Арав. Шүдний согог заслын тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналт**

10.1. Шүдний согог заслын өрөө нь хүлээн авах, хэвлэх, өнгөлгөөний хэсгээс бүрдэх бөгөөд HEPA шүүлтүүр бүхий агааржуулалтын системтэй байхаас гадна цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт нь дээрх зааврын дагуу хийгдэнэ.

10.2. Шүдэлбэрт хоолны үлдэгдэл наалдаж бохирдсон үед шүдэлбэрийг цэвэрлэгээний уусмалд хийж, хэт авиан цэвэрлэгчээр зааврын дагуу цэвэрлэн урсгал усанд зайлна.

10.3. Шүдний согог заслын эмч, мэргэжилтэнүүд нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад хамгаалах хувцас хэрэгслийг байнга өмсөнө.

10.4. Шүдний өнгөлгөөний хэсэг нь үйлчлүүлэгчийн амны хөндийд орсон засвар шүдэлбэрийг өнгөлөх хэсэг, шинэ шүдэлбэрийг өнгөлөх хэсгээс бүрдэнэ. Хэрэв 2 талт өнгөлгөөний машин хэрэглэдэг бол 2 талд нь тус бүр сорогч эсвэл вакуум хаалттай байна. Сорогч, вакуум үүсгэгч байхгүй бол тусдаа өнгөлгөөний хэсэгтэй байна.

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн А/537 дугаар тушаалын  
зургаадугаар хавсралт

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Эрүүл мэндийн байгууллагын орчны цэвэрлэгээг хийх зорилго нь эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн ар гэр, олон нийтэд цэвэр ая тухтай аюулгүй орчныг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Бохирдол гэдэг нь орчны эд юмс, тоног төхөөрөмж нь халдварлах аюултай органик (хүний цус, биологийн шингэн) эсвэл органик бус (тоос, шороо) зүйлсээр бохирдохыг хэлдэг.
- 1.3. Эрүүл мэндийн байгууллагын нийт талбайг гадаад болон дотоод орчин гэж ангилна.
- 1.4. Дотоод орчинд хамаарах талбайг тасаг, нэгжийн үйл ажиллагаа, халдварын эрсдлийн зэргээр А, В, С бүсэд хуваан, бүс тус бүрт тохирсон цэвэрлэгээг хийнэ. (Хүснэгт 1)
- 1.5. Бохирдох эрсдэл өндөр буюу хүрэлцэх давтамж их (хаалганы бариул, өвчтөний ор, ширээ, гэрлийн унтраалга) гадаргуу болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй хүрэлцэх давтамж бага гадаргууд өдөр тутмын цэвэрлэгээг тодорхой давтамжтай хийж гүйцэтгэнэ. (Хүснэгт 3)

### **Хоёр. Цэвэрлэгээний ерөнхий зарчим**

- 2.1. Эрүүл мэндийн байгууллага бүр байгууллагын онцлогт тохирсон цэвэрлэгээ хийх журам, цэвэрлэгээний хуваарийг халдварын сэргийлэлт, хяналтын алба, багаар хянаж, батлуулсан байна.
- 2.2. Халдварын сэргийлэлт, хяналтын баг нь эрүүл мэндийн ажиллагсдад цэвэрлэгээ хийх давтамж, цэвэрлэгээний материалыг цэвэрлэх, хадгалах, цэвэрлэгээ хийх уусмалыг бэлтгэх талаар сургалтыг зохион байгуулна.
- 2.3. Цэвэрлэгээ хийхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг угааж, халдваргүйжүүлэх, хадгалах нөхцөлөөр бүрэн хангасан байна.
- 2.4. Цэвэрлэгээ хийх үед ахуйн бээлий, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.



2.5. Цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалд тоос сорогч, хивс угаах машин, цэвэрлэгээний тэргэнцэр, хувин, шалны мод, даавуун алчуур, цонх, шил толь цэвэрлэгч, шүршигч сав, сойз, хөөсрүүлэгч материал, шүүр, хогийн хутгуур, хогийн уут хамаарна.

2.6. Цэвэрлэгээнд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, материал нь бохирлогдоогүй, цэвэр байх бөгөөд хэрэглэсний дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж, цэвэр усанд зайлж хатаасан байна.

2.7. Эрүүл мэндийн байгууллагын хана шал, бусад тавилга хэрэгсэл эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоног төхөөрөмж гадаргууг арчиж цэвэрлэхдээ тоос, бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ.

2.8. Хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлээс эхэлж дээрээс доош нь чиглэлтэй цэвэрлэгээг хийнэ.

2.9. Эмнэлгийн орчны гадаргуугийн халдваргүйжүүлэлтэд монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн тухайн гадаргууд зориулагдсан үр дүнтэй бодисыг сонгоно.

2.10. Гадаргуугийн халдваргүйжүүлэгч бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

2.11. Цэвэрлэгээний уусмалыг өдөр бүр, шаардлагатай үед бэлтгэх, цэвэрлэгээ хийх явцад цэвэрлэгээний ус бохирдох, бичил биетнийг орчинд тараах эрсдэлтэй тул бохирдсон уусмалыг тухай бүрд солино.

2.12. Өөр тасаг нэгжид цэвэрлэгээ хийх үед цэвэрлэгээний уусмалыг шинээр сольж, бэлтгэн хэрэглэнэ.

2.13. Тасаг нэгж бүр цэвэрлэгээний тэргэнцэртэй байх ба цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалыг өөр тасаг нэгжид ашиглах, хооронд нь сольж хэрэглэхийг хориглоно.

2.14. Цэвэрлэгээнд хэрэглэх материалыг өнгөөр ялгаж, хэрэглэнэ.

<b>Зориулалт</b>	<b>Материалын өнгө</b>
Ариун цэврийн өрөөний суултуур	Улаан өнгө
Ариун цэврийн өрөөний гар угаагуур болон бусад гадаргуу	Шар өнгө
Үйлчлүүлэгчийн палат, өрөөний тоног төхөөрөмж, хэрэгслүүд, хана, ор, цонх	Цэнхэр өнгө
Шал	Цагаан өнгө

- 2.15. Их цэвэрлэгээг 2 долоо хоногт 1 удаа, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.
- 2.16. Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайд сард 1 удаа их цэвэрлэгээг хийнэ.

Хүснэгт 1

Бүс	Тухайн бүсэд хамаарах тасаг нэгж	Цэвэрлэгээ хийх уусмал
А халдварын эрсдэл өндөр	Тусгаарлах, мэс засал болон түүнтэй адилтгах тасаг, хэсэг, төрөх, боолт, тарианы, ариутгал, цусны албаны бокс, лаборатори, сүрьеэ, халдварт, амбулаторийн ажилбарын, угаалгын бохирын хэсэг, сэхээн амьдруулах, эрчимт, төрсний болон мэс заслын дараах, нярай, хог хаягдлын цэг, ариун цэврийн өрөө гэх мэт	Халдваргүйжүүлэх уусмал, угаалгын нунтаг бүхий уусмал
В халдварын эрсдэл дунд	Гал тогоо, амбулаторийн ажилбарын бус өрөөнүүд, эмийн сан, эмчийн өрөө, физик эмчилгээ, сувилагчийн пост, рентген, хэт авиан оношилгоо, зүрхний бичлэг, угаалгын газрын хатаалга, индүүдлэг, хадгалах өрөө, төрөхийн болон мэс заслын өмнөх, цус цуглуулах өрөө гэх мэт	Халдваргүйжүүлэх уусмал, угаалгын нунтаг бүхий уусмал
С халдварын эрсдэл бага	Захиргаа, сургалтын өрөө, хонгил, эмнэлгийн гаднах талбай, инженерийн хэсэг, ариун бус зүйл хадгалах агуулах, архивын өрөө, хүлээлгийн өрөө, өлгүүр гэх мэт	Угаалгын нунтаг бүхий уусмал

### Гурав. Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх

3.1 Эрүүл мэндийн ажилтан асгарсан, цацагдсан цус, биологийн шингэн асгарсан тохиодолд ажилтан, үйлчлүүлэгчдийг халдвар, гэнэтийн ослоос сэргийлж цаг тухайд нь асгарсан шингэнийг цэвэрлэх иж бүрдэлийг ашиглан халдваргүйжүүлэн цэвэрлэнэ. (Хүснэгт 2)

3.2 Асгарсан шингэнийг цэвэрлэх иж бүрдэл нь тусламж, үйлчилгээ үзүүлж буй цэг бүрт байна.

3.3 Асгарсан цус, биологийн шингэн, бусад органик материалыг халдваргүйжүүлж цэвэрлэх иж бүрдэлд нэг удаагийн хэрэглээний бээлий, мэс заслын амны хаалт, хормогч, нүдний шил, нүүрний хамгаалалт, ус нэвтрэхгүй хог хаягдлын уут, шингээгч цаас, даавуу, угаалгын нунтаг, халдваргүйжүүлэх бодис, хогийн хутгуур, цэвэрлэгээний сав зэрэг байна.

Хэмжээ	Цэвэрлэгээ
Толбо цэвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Хувийн хамгаалах хэрэгслийг өмсөнө.</li> <li>• Нэг удаагийн шингээгч цаас, даавуугаар угаалгын нунтаг бүхий уусмал хэрэглэж арчиж , хатаана.</li> <li>• Бохирдсон материалыг хог хаягдлын саванд хийнэ.</li> <li>• Гарын эрүүл ахуйг сахина</li> </ul>
Жижиг асгаралт /диаметр 10см-ээс бага /	<ul style="list-style-type: none"> <li>• Хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.</li> <li>• Асгарсан шингэн дээр халдваргүйжүүлэх бодис шингээж тодорхой хугацааны дараа нэг удаагийн шингээгч цаас, даавуугаар цэвэрлэнэ.</li> <li>• Халдваргүйжүүлэгч бодистой угаалгын нунтаг бүхий уусмалаар гадаргууг арчиж хатаана.</li> <li>• Бохирлогдсон материалыг ус нэвтрэхгүй халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.</li> <li>• Гарын эрүүл ахуйг сахина.</li> </ul>
Их хэмжээний асгаралт /диаметр нь 10см-ээс их/	<ul style="list-style-type: none"> <li>• Хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.</li> <li>• Асгарсан цус биологийн шингэн цэвэрлэх нэг удаагийн шингээгч цаас , сав, хутгуур материалыг ашиглана.</li> <li>• Асгарсан шингэн дээр халдваргүйжүүлэх бодис шингээж тодорхой хугацааны дараа нэг удаагийн шингээгч цаас, даавуугаар цэвэрлэнэ.</li> <li>• Халдваргүйжүүлэх бодистой угаалгын нунтаг бүхий уусмалаар гадаргууг арчиж хатаана.</li> <li>• Бохирлогдсон материалыг ус нэвтрэхгүй халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.</li> <li>• Гарын эрүүл ахуйг сахина</li> </ul>

### **Дөрөв. Мэс засал түүнтэй адилтгах өрөөний цэвэрлэгээ**

4.1. Тухайн өдрийн мэс засал эхлэхийн өмнө тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбайг угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэх ба мэс засал эхлэхээс 1 цагийн өмнө дуусгасан байна.

4.2. Мэс ажилбар хооронд болон дараа тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, гэрэл ойлгогч, бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбайг халваргүйжүүлэх уусмалын үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлэн угааж цэвэрлэнэ.

4.3. Тухайн өдрийн сүүлийн мэс заслын дараа тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч, бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбай зэргийг халдваргүйжүүлэх, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэнэ.

4.4. Агаарын хэм тохируулагч, агаар сорох хэсгийг инженер техникийн ажилтан тогтмол шалган, долоо хоног тутам цэвэрлэж, засвар үйлчилгээ хийнэ.

### Тав. Түргэн тусламжийн машины цэвэрлэгээ

5.1. Бээлий, угаалгын нунтаг бүхий цэвэрлэгээний бодис хийх сав, халдваргүйжүүлэх уусмал хийх сав, цэвэрлэгээ хийх алчуур, хог хаягдлын сав, хогны уут, цэвэрлэгээний материал агуулах сагс зэргийг бэлтгэсэн байна.

5.2. Түргэн тусламжийн машиныг 14 хоногт машины дотор, гадна тал, шал, хана, ор, сандал, бусад гадаргууг маш сайн цэвэрлэн их цэвэрлэгээг жолооч хийнэ.

5.3. Дуудлага хооронд түргэн тусламжийн машины гадаргууг халдваргүйжүүлэн цэвэрлэх. Үүнд:

5.3.1. Түргэн тусламжийн машины цонх, хаалгыг онгойлон агаар сэлгэлт хийнэ.

5.3.2. Үйлчлүүлэгчийн хэсэгт хүрэлцэх гадаргууд халдваргүйжүүлэх уусмалаар гадаргууг арчих болон цацаж халдваргүйжүүлэлт хийнэ.

5.4. Цус, биологийн шингэнээр бохирлогдсон болон хавьтал, дуслын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчийг тэвэрлэсэн үед жолооч цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийнэ. Ариутгалын ажилтан, тархвар судлаачаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.

### Зургаа: Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх давтамж

6.1. Эрүүл мэндийн байгууллагын дотоод орчинд халдварын эрсдэлийн зэргээс хамааран хамгийн багадаа доорхи давтамжтай цэвэрлэгээг хийж гүйцэтгэнэ.

6.2. Халдварын эрсдэлийн зэргээр А, В, С бүсэд хуваан, бүс тус бүрт тохирсон цэвэрлэгээг бохирдсон тухай бүрт хийнэ. (Хүснэгт 3)

Эд хогшил	Цэвэрлэгээ хийх хамгийн бага давтамж		
	Өндөр эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Бага эрсдэлтэй
Гар халдваргүйжүүлэх уусмалын сав	Халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт	Халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт	Халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт
Гар угаах угаалтуур	Өдөрт 3 удаа	Өдөрт 2 удаа	Өдөр тутам
Цонхны гадна тал	Сард 2 удаа	Сард 1 удаа	Улиралд 1 удаа
Цонхны дотор тал	Өдөр тутам	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа
Дулаан халаагуур (радиатир)	Өдөр тутам	Долоо хоногт 1 удаа	Сард 1 удаа
Агааржуулалтын сараалж нүх	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	Сард 1 удаа
Өвчтөний өрөөний хаалга	Өдөрт 2 удаа	Өдөр тутам	
Тасаг нэгжид орох хаалга	Өдөр тутам	Өдөр тутам	Долоо хоногт 1 удаа

Шал	Өдөрт 3 удаа	Өдөр 2 удаа	Өдөр тутам
Хана	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа
Ор	Өвчтөн солигдох бүр	Өвчтөн солигдох бүр	
Тааз	Сард 1 удаа	Сард 1 удаа	Жилд 1 удаа
Хаалганы бариул	Өдөрт 2 удаа	Өдөр тутам	Өдөр тутам
Өвчтөний орны дэргэдэх ширээ	Өдөрт 2 удаа	Өдөр тутам	
Ариун цэврийн суултуур	Өдөрт 3 удаа	Өдөрт 2 удаа	Өдөр тутам
Хүчил төрөгчийн оксиметр	Хэрэглэхийн өмнө ба дараа	Хэрэглэхийн өмнө ба дараа	
Дуслын хөл	Хэрэглэхийн өмнө ба дараа	Хэрэглэхийн өмнө ба дараа	
Компьютер, түүний гар	Өдөрт 2 удаа	Өдөр тутам	Долоо хоногт 1 удаа
Хог хаягдал зөөвөрлөх тэргэнцэр	Хэрэглэсний дараа	Хэрэглэсний дараа	Хэрэглэсний дараа
Цэвэрлэгээний багаж, хэрэгсэл	Хэрэглэсний дараа	Хэрэглэсний дараа	Хэрэглэсний дараа
Цахилгаан шат	Өдөр тутам	Өдөр тутам	Өдөр тутам
Зурагт	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа
Үйлчлүүлэгчийн өрөөний зурагт	Үйлчлүүлэгч хооронд Өдөр тутам	Үйлчлүүлэгч хооронд Долоо хоногт 1 удаа	Сард 1 удаа
Суурин утас	Өдөрт 3 удаа	Өдөрт 2 удаа	Өдөр тутам
Гэрлийн унтраалга	Өдөр тутам	Өдөр тутам	Өдөр тутам
Орны дэргэдэх эмч дуудах товчлууур	Өдөрт 2 удаа	Өдөрт 1 удаа	
Матрас, гудас	Үйлчлүүлэгч хооронд Долоо хоногт 1 удаа	Үйлчлүүлэгч хооронд Сард 1 удаа	
Хөшиг	Орны хөшиг – Долоо хоногт 1 удаа Өвчтөн гарсны дараа	Сард 1 удаа	Улиралд 1 удаа
Зүрхний монитор	Хэрэглэсний дараа Өдөр тутам	Хэрэглэсний дараа Өдөр тутам	
Эмийн тэргэнцэр	Өдөрт 3 удаа	Өдөрт 2 удаа	
Цагаан хэрэглэл зөөвөрлөх тэргэнцэр	Хэрэглэсний дараа Өдөрт 3 удаа	Өдөрт 2 удаа	
Хогийн сав	Өдөр тутам	Өдөр тутам	Өдөр тутам
Нярайн инкубатор	Өдөр тутам Үйлчлүүлэгч хооронд 1 хүүхдэд хэрэглэж байвал 3 хоногт 1 удаа		
Толь	Өдөр тутам	Өдөр тутам	Долоо хоногт 1 удаа
Эмийн шүүгээ	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	

Өвчтөн зөөвөрлөх тэргэнцэр	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	
Эм биобэлдмэл хадгалах хөргүүр	Долоо хоногт 1 удаа	Долоо хоногт 1 удаа	
Даралтны аппарат	Хэрэглэсний дараа	Хэрэглэсний дараа	

### **Долоо. Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээний үр дүнг үнэлэх**

7.1. Өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг хүснэгт 1, ажилбарын өрөөнд хийгдэх цэвэрлэгээг хүснэгт 2-т заасан загвар хуудсаар үнэлнэ.

7.2. Халдварын сэргийлэлт, хяналтын алба, баг нь цэвэрлэгээний чанарт дотоодын хяналт хийнэ. Дотоод хяналтыг Хүснэгт 3-т заасан шалгуур хуудсаар үнэлж дүгнэнэ. Үнэлгээг тийм онооны нийлбэр дүнг, үнэлгээ хийгдсэн асуумжийн авбал зохих оноонд харьцуулж хувиар гаргана. (Хүснэгт 4)

7.3. Тухайн байгууллагын нийлбэр онооны хувь 60%-аас бага байвал хангалтгүй, 60-70% бол дундаас доогуур, 71-90% дундаж, 91-100% байвал хангалттай түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээ авч ажиллана.

**Өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх загвар хуудас**

Эмнэлгийн нэр: \_\_\_\_\_

Тасаг : \_\_\_\_\_

Дотоод хяналт хийсэн огноо: /...../...../...../

Өрөөний дугаар \_\_\_\_\_

**Хүснэгт 1**

Цэвэрлэгээ хийх талбай	Цэвэрлэгээ хийсэн эсэх		Тайлбар
	Тийм	Үгүй	
<b>Өдөр тутмын цэвэрлэгээнд шаардлагатай зүйлс</b>			
Бээлий			
Гадаргуу халдваргүйжүүлэх уусмал			
Угаалгын нунтаг			
Халтирахаас сэргийлсэн анхааруулга			
Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх			
<b>Бохирдох эрсдэл өндөр буюу хүрэлцэх давтамж их гадаргуу</b>			
Орны бариул			
Орны толгой хөл			
Орны дэргэдэх дуудах товч			
Хаалганы бариул			
Орны дэргэдэх ширээ, шүүгээ			
<b>Хүрэлцэх давтамж бага гадаргуу</b>			
Хаалга			
Цонхны тавцан			
Ханан дээрх толбыг халдваргүйжүүлэх уусмалаар арчсан эсэх			
Бусад тавилга, сандал			
Гэрлийн унтраалга			
Гар угаалтуур			
<b>Эмнэлгийн тоног төхөөрөмж</b>			
Монитор			
Өвчтөний хөтөвч бүхий сандал			
<b>Ариун цэврийн өрөө цэвэрлэж эхлэхийн өмнө гарын эрүүл ахуй сахиж цэвэрхэн бээлий өмсөж, цэвэр цэвэрлэгээний материал хэрэглэх</b>			
Толь			
Гэрлийн унтраалга			
Саван болон цаасан алчуурны сав			
Гарын угаалтуурын цорго			
Гарын угаалтуур			
Шүршүүр			
Хананд толботой бол цэвэрлэсэн эсэх			
Ариун цэврийн цаасны сав			
Суултуур			
Суултуур цэвэрлэгч			
Гарын эрүүл ахуй сахина.			
Дүн			

## Ажилбарын өрөөнд хийгдэх цэвэрлэгээг үнэлэх загвар хуудас

Тасаг : \_\_\_\_\_ Өрөөний дугаар \_\_\_\_\_ Хяналт хийсэн огноо: .....

### Хүснэгт 2

Цэвэрлэгээ хийх талбай	Цэвэрлэгээ хийсэн эсэх		Тайлбар
	Тийм	Үгүй	
<b>Өдрийн ажилбар эхлэхийн өмнөх цэвэрлэгээ (Ажилбарын үед хүрч болзошгүй гадаргуугийн тоосыг дээрээс доош чиглэлд арчина.)</b>			
Тавилга			
Эмнэлгийн тоног төхөөрөмж			
Ажлын ширээ			
<b>Үйлчлүүлэгч хооронд</b>			
Гарын эрүүл ахуй сахина			
Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх			
Үзлэг, ажилбарын үед гарсан хог хаягдлыг цуглуулан цэвэрлэнэ.			
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт :			
Унтуулгын хэрэгсэл (цүнх, тэргэнцэр)			
Автомат дуслын шахуурга			
Соруулгын аппарат			
Монитор			
Үзлэгийн ор			
Тэргэнцэр			
Бусад			
Хүрэлцэх давтамж их гадаргуу Хаалганы бариул гэх мэт			
Шал болон хана (хэрвээ цус биологийн шингэн цацарсан асарсан бол )			
Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл тайлна.			
Гарын эрүүл ахуй сахина			
<b>Өдрийн ажилбар дууссаны дараах эцсийн цэвэрлэгээ</b>			
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт :			
Унтуулгын хэрэгсэл (цүнх, тэргэнцэр )			
Автомат дуслын шахуурга			
Соруулгын аппарат			
Монитор			
Үзлэгийн ор			
Тэргэнцэр			
Бусад			
Компьютер / дэлгэц, гар, удирдлага /			
Бусад тавилга, сандал			
Гэрлийн унтраалга			
Гар угаалтуур			
Шал			
Хог хаягдал цуглуулах сав			
Дүн			



## Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийх загвар хуудас

Эмнэлгийн нэр: \_\_\_\_\_

Тасаг : \_\_\_\_\_

Дотоод хяналт хийсэн огноо: /...../ /...../ /...../

### Хүснэгт 3

Цэвэрлэгээний шалгуур:		Хариулт	Оноо
<b>Нэг. Барилга байгууламжийн хэсгийн цэвэрлэгээ</b>			
Хана, цонхны хүрээ, тааз	Хана, таазны дотор тал нь тоосгүй, толбогүй бохирдолгүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Хана, таазны бэхэлгээ, тоноглолууд (унтраалга, залгуур) тоос, бохирдолгүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Гэрлийн бүрхүүл нь тоосгүй, цэвэр байх.	Үгүй	0
		Тийм	1
Цонхны дотор тал	Шилний гадаргуу, хүрээ, тавцан нь хурууны мөр болон бусад бохир, халтар толбогүй цэвэрхэн байх.	Үгүй	0
		Тийм	1
Хаалга	Хаалганы дотор болон гадна тал, хаалганы хүрээ нь тоос шороогүй, бохирдолгүй цэвэрлэгдсэн байх.	Үгүй	0
		Тийм	1
Шал	Шал, шалны хүрээ, булан тохой нь тоос шороогүй, бохир толбогүй, цаас болон хог хаягдал хаяагүй, ус болон шингэн асгараагүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Цэвэрлэсэн нойтон шалан дээр явган хүн болгоомжтой явах талаар тэмдэглэгээ тавих.	Үгүй	0
		Тийм	1
Агааржуулах нүх	Агааржуулах нүх, агааржуулалтын хэсэг нь тоос шороогүй, ямар нэгэн өнгөр тогтоогүй байх.	Үгүй	0
		Тийм	1
<b>Хоёр. Тавилга, хэрэгслийн цэвэрлэгээ</b>			
Цахилгаан хэрэгсэл	Цахилгаан хэрэгсэл нь тоос шороогүй, ямар нэг толбо, өнгөргүй байх	Үгүй	0
		Тийм	1
	Агаар сэлгэх мотор нь тоос шороогүй, бохирдолгүй байх.	Үгүй	0
		Тийм	1
Тавилга	Тавилга, тавиур, ширээ, сандал, хувцасны шүүгээний гадаргуу нь толбо, өнгөргүй, тос, бусад зүйлсийг асгаагүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Тавилгын хөл, дугуйн хөлнүүд, тавилгын булан тохой, хүрээ, завсар нь бохир толбогүй, тоос шороогүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Ор хоорондын даавуун хөшиг толбо, өнгөргүй, тос, бусад зүйлсийг асгаагүй байх.	Үгүй	0
		Тийм	1

Ариун цэврийн хэрэгсэл	Шаазан болон хуванцар гадаргуутай суултуур бүрэн, гэмтэлгүй, зэв үүсээгүй, бохир ямар нэг толбогүй, өнгөргүй, өтгөнөөр бохирлогдоогүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Ариун цэврийн өрөөний ханан дахь тавцангууд нь мөөгөнцөртөөгүй, тоосгүй цэвэр байх.	Үгүй	0
		Тийм	1
	Ус дамжуулах хоолойнууд нь тоосгүй ямар нэг толбо үүсээгүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Ариун цэврийн өрөөний хог хаягдлын сав нь хөл ажиллагаатай, тагтай, гэмтэл, хагаралгүй, цэвэрлэгдсэн байх.	Үгүй	0
		Тийм	1
<b>Гурав. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ</b>			
Өвчтөнд хэрэглэх тоног төхөөрөмж	Өвчтөнд хэрэглэх тоног төхөөрөмж нь хүний цус болон бусад биологийн шингэнээр бохирлогдоогүй, ямар нэг бохир толбогүй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Тоног төхөөрөмжийн хөл болон дугуйн хөлнүүд нь тоос шороогүй, ямар нэгэн бохир толбогүй, цэвэрхэн байх.	Үгүй	0
		Тийм	1
Цэвэрлэгээний тоног төхөөрөмж	Цэвэрлэгээний материалыг өнгөөр ялгасан.	Үгүй	0
		Тийм	1
	Цэвэрлэгээний бодис, хэрэгсэл хангалттай байх. /угаалгын нунтаг, халдваргүйжүүлэх уусмал, ахуйн бээлий гэх мэт /	Үгүй	0
		Тийм	1
	Цэвэрлэгээний материал хадгалах өрөөтэй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Цэвэрлэгээний тэргэнцэртэй байх.	Үгүй	0
		Тийм	1
	Цэвэрлэгээний тэргэнцэр нь тоос шороогүй, асгарсан шингэнгүй байх.	Үгүй	0
		Тийм	1
<b>Нийлбэр оноо</b>			<b>.... /24</b>

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн А/537 дугаар тушаалын  
долоодугаар хавсралт

## **ХАМГААЛАХ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэлд нэг удаагийн малгай, халад, нүдний шил, нүүрний хамгаалалт, амны хаалт, шүүлтүүртэй амны хаалт, комбинзон, хормогч, бээлий, гутал, улавч зэрэг орно.

1.2. Хамгаалах хувцас хэрэгсэл нь эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийн халдварт өртөх эрсдэлийг бууруулна.

1.3. Халдварын эрсдэлийг үнэлж хамгаалах хувцас, хэрэгслийг сонгож хэрэглэнэ. Ханиах, найтаах болон цус, биологийн шингэн цацагдах, үсрэх үед шингэн нэвтрэхгүй байна.

1.4. Хамгаалах хувцас хэрэгсэл нь хэрэглэх байдлаасаа шалтгаалан олон төрөл байна.

1.5. Амны хаалтын төрөл, ялгаа:

1.5.1. Мэс заслын амны хаалт – Эрүүл мэндийн ажилтны ярих, ханиах, найтаах үед цацагдах бичил биетнээр үйлчлүүлэгч халдварлагдахаас сэргийлнэ. Амьсгалын замын халдвараас сэргийлэх хамгаалалт болохгүй.

1.5.2. Мэс заслын шүүлтүүртэй амны хаалт – Нүүрэнд битүүмж үүсгэн зай завсар гаргахгүй, зөв тохируулан зүүхэд тоосонцор болон бичил биетнийг шүүдэг. Эрүүл мэндийн ажилтанд амьсгалын замын халдвар дамжих эрсдэлийг бууруулна. Ажилбарын үед хэрэглэнэ.

1.5.3. Шүүлтүүртэй амны хаалт - Нүүрэнд битүүмж үүсгэн зай завсар гаргахгүй, зөв тохируулан зүүхэд тоосонцор болон бичил биетнийг шүүдэг. Эрүүл мэндийн ажилтанд амьсгалын замын халдвар дамжих эрсдэлийг бууруулна.

1.6. Бээлийний төрөл, ялгаа:

1.6.1. Ариун бээлий-Ариун ажилбарын үед хэрэглэнэ.

1.6.2. Үзлэгийн бээлий – Цус, биологийн шингэнээр гар бохирдох эрсдэлтэй үед хэрэглэнэ. Үзлэгийн бээлий нь материалаас шалтгаалан химийн бодисд тэсвэртэй нитрил бээлий, винил, латекс гэх мэт олон төрөл байна.

1.6.3. Ахуйн бээлий – Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үед ашиглана.

### **Хоёр. Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх хамгаалах хувцас хэрэгсэлд тавигдах шаардлага**

2.1. Шүүлтүүртэй амны хаалтад тавигдах шаардлага:

- 2.1.1. Эмнэлэг болон халдвартай орчинд хэрэглэх заавартай байх;
  - 2.1.2. Халдвартай агаарын дуслыг 95 буюу түүнээс дээш хувь шүүх үзүүлэлттэй байх. Тоосонцорыг 95 хувь шүүх үзүүлэлттэй амны хаалтыг эмнэлэгт болон халдвартай орчинд хэрэглэхгүй;
  - 2.1.3. Шингэн нэвчихгүй тэсвэртэй байх;
  - 2.1.4. Амны хаалт болон гадна савалгаан дахь шүүлтүүрийн тэмдэглэгээнд “N95” буюу 95 хувийн шүүлтүүртэй, Европ стандартын дагуу үйлдвэрлэсэн бол FFP2, FFP3 гэсэн тэмдэглэгээтэй байна.
  - 2.1.5. Загвар нь хувь хүний нүүрний онцлогт тохирсон, битүүмжлэл үүсгэх боломжтой, ярих, амьсгалах үед ам руу татагдаж хонхойдоггүй байна.
- 2.2. Нэг удаагийн халад, комбинзон, хормогчид тавигдах шаардлага:
- 2.2.1. Шингэн нэвчихгүй;
  - 2.2.2. Халад, комбинзон нь биеийн хэмжээнд тохирсон, ажиллах явцад хөдөлгөөнд саадгүй биед эвтэйхэн, бариу биш байна. Багадсан, бариу байх нь хөдлөх үед урагдах эрсдэлтэй.
  - 2.2.3. Халад урт ханцуйтай, задгай тал нь хойшоо харсан, урд тал битүү байна.
  - 2.2.4. Асептик орчин шаарддаг ажилбарын үед ариун халад өмсөнө.
  - 2.2.5. Хормогч нь полиэтилен эсвэл хулдаасан материалтай байна.
- 2.3. Бээлийнд тавигдах шаардлага:
- 2.3.1. Урагдаж, гэмтэж, цоороогүй байх;
  - 2.3.2. Аль болох талькгүй байх;
  - 2.3.3. Хэмжээний хувьд олон төрлийн сонголттой байна.
- 2.4. Нүдний шил болон нүүрний хамгаалалтад тавигдах шаардлага:
- 2.4.1. Цанталтаас сэргийлсэн;
  - 2.4.2. Зураас үүсдэггүй;
  - 2.4.3. Халдвартай орчинд хэрэглэх нүдний шил нь зүүхэд зай завсар гарахаас сэргийлсэн зөөлөвчтэй байх;
  - 2.4.4. Мэс засал, нүүр амны тусламж зэрэг ажилбарын үед хэрэглэх нүдний шил нь нэмэлтээр харах талбайг гэрэлтүүлэх гэрэлтэй байна.

### **Гурав. Хамгаалах хувцас хэрэгслийн хэрэглээ**

- 3.1. Комбинзон, халад, малгай, бээлий, амны хаалт, шүүлтүүртэй амны хаалт, гутлын гадуурх улавчийг нэг удаа хэрэглээд устгана. Нүдний шил, давтан хэрэглэдэг нүүрний хаалт, усны гутлыг халдваргүйжүүлсний дараа давтан хэрэглэнэ.

3.2. Агаар дуслын халдвар, аерозол үүсгэх ажилбарын үед шүүлтүүртэй амны хаалтыг хэрэглэнэ.

3.3. Эмнэлэг, халдвартай орчинд хэрэглэх шүүлтүүртэй амны хаалтыг дараах загваруудаас сонгож хэрэглэж болно. Үүнд:

3.3.1. N95 тэмдэглэгээтэй, 8511 загварын дугаартай аяган хэлбэрийн хавхлагатай шүүлтүүртэй амны хаалт;

3.3.2. N95 тэмдэглэгээтэй, 8210 загварын дугаартай аяган хэлбэрийн шүүлтүүртэй амны хаалт;

3.3.3. FFP2 тэмдэглэгээтэй, 9322+ загварын дугаартай гурван нуглаас бүхий, хавхлагатай шүүлтүүртэй амны хаалт;

3.3.4. FFP3 тэмдэглэгээтэй, 9332+ загварын дугаартай гурван нуглаас бүхий, хавхлагатай шүүлтүүртэй амны хаалт;

3.3.5. FFP2 тэмдэглэгээтэй, 8822 загварын дугаартай аяган хэлбэрийн хавхлагатай шүүлтүүртэй амны хаалт гэх мэт.

3.4. Халад, комбинзоныг эрүүл мэндийн ажилтны арьс, хувцас бохирдохоос сэргийлж хэрэглэнэ.

3.5. Хормогчийг шингэн нэвтрэх эрсдэл ихтэй үед хэрэглэнэ.

3.6. Нүдний салстад шингэн шүршигдэх, цацагдах эрсдэлтэй үед нүдний шил эсвэл нүүрний хамгаалалт хэрэглэнэ.

3.6.1. Нүдний шилийг цэвэрлэж халдваргүйжүүлсний дараа давтан ашиглаж болно.

3.6.2. Нүүрний хамгаалалт нь давтан ашиглах болон нэг удаагаар ашиглах 2 төрөл байдаг. Үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

3.7. Нэг удаагийн үзлэгийн бээлийг хэрэглэхийн өмнө цоорсон, урагдсан гэмтэл байгаа эсэхийг шалгаж өмсөнө.

3.8. Хог хаягдалтай харьцах үед зүү нэвтрэхээс сэргийлсэн хамгаалалттай бээлий хэрэглэнэ.

3.9. Эмнэлэгт битүү гутал хэрэглэнэ. Халдварт өвчний тусгаарлалтын үед гутлын гадуурх улавч өмсөнө. Шингэн нэвтэрч гутал бохирдох эрсдэлтэй үед усны гутал өмсөнө.

3.10. Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх хамгаалах, хувцас хэрэгслийн захиалга өгөх, нийлүүлэгчээс хүлээн авахад чанарын шаардлага хангаж буй эсэхэд эм зүйч, тархвар судлаач, эмч, сувилагч зэрэг төлөөллийг оролцуулан нягтлан шалгаж үнэлгээ хийж хүлээж авна.

3.11. Шаардлага хангахгүй тохиолдолд эрүүл мэндийн ажиллагсад хариуцсан тасаг нэгжид мэдээлж солиулах арга хэмжээ авна.

## **Дөрөв. Хориглох зүйл**

- 4.1. Халдварын эрсдэлтэй орчинд даавуун халад, хөвөн марлиар хийсэн амны хаалт, даавуун алчуур зэрэг уламжлалт хамгаалах хувцас хэрэглэхгүй.
- 4.2. Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийг давтан хэрэглэхгүй.
- 4.3. N95, FFP2, FFP3 зэрэг шүүлтүүрийн тэмдэглэгээтэй боловч тоосонцор шүүх зориулалт бүхий шүүлтүүртэй амны хаалтыг эмнэлэгт хэрэглэхгүй.
- 4.4. Олон нийтэд зориулсан 3M™ 8670F, 3M™ 8612F, Tm F550G, Tm A520G зэрэг тэмдэглэгээтэй, шүүлтүүртэй амны хаалтыг эмнэлэгт хэрэглэхгүй.
- 4.5. Халдвартай орчинд хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгслийг тайлахгүйгээр бусад эд зүйлд хүрэх, өрөө тасалгаагаар сэлгүүцэхийг хориглоно.
- 4.6. Бээлий нь химийн бодист тэсвэртэй биш бол бээлийтэй гарыг угааж, халдваргүйжүүлэхгүй.
- 4.7. Ариун болон үзлэгийн бээлийг давтан ашиглахгүй, үйлчлүүлэгч бүрт 1 бээлий хэрэглэнэ.
- 4.8. Эмнэлэгт хэрэглэсэн хувцсыг гэрт аваачиж угаах, өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

## **Тав. Хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх, тайлах**

- 5.1. Цэвэр, ариун ажилбар, биологийн шингэнээр бохирлогдох эрсдэлтэй тусламж, хавьтал, дуслын замаар дамжих зарим халдварын үед хэрэглэх хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх, тайлахад анхаарах зүйл.
  - 5.1.1. Халад, мэс заслын амны хаалт, үзлэгийн болон ариун бээлий, малгай, шингэн үсрэх эрсдэлтэй бол нүдний шил эсвэл нүүрний хаалт өмсөнө.
  - 5.1.2. Өмсөх дараалал: - Гарын эрүүл ахуйг сахиж халад, малгай, амны хаалт, дахин гар халдваргүйжүүлсний дараа бээлий өмсөнө.
  - 5.1.3. Тайлах дараалал: - Бохирдол ихтэй хэсгээс эхэлж тайлна.

Бээлий тайлна.

Гарын эрүүл ахуйг сахиж дараа нь халад, малгайг тайлна.

Хамгаалах хувцас тайлах явцад нүд, ам, хамрын салст бохирдохоос сэргийлж нүдний шил, амны хаалтыг хамгийн сүүлд тайлна.

Бүх хамгаалах хувцсыг тайлсны дараа гарын эрүүл ахуйг сахина.
- 5.2. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин, эбола, томуугийн шинэ вирусийн халдвар, тарваган тахлын уушгины хэлбэр зэрэг халдвар тархах эрсдэл өндөртэй халдварын тусгаарлалтын үед иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг өмсөнө.

5.3. Хамгаалах хувцас хэрэгслийг халдвартай материалтай харьцах, тусгаарлалтын үед үйлчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө халдваргүй бүсэд өмсөнө. Өрөө нь тольтой байна.

5.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхөд анхаарах зүйл:

5.4.1. Хамгаалах хувцас өмсөхийн өмнө гарын эрүүл ахуйг сахина.

5.4.2. Комбинзон эсвэл халад өмсөнө.

5.4.3. Усны гутал эсвэл гутлын гадуурх улавч өмсөнө. Шингэн нэвтрэх эрсдэлтэй үед усны гутал өмсөнө. Комбинзоны түрийг усны гутлын гадуур гаргаж өмсөнө.

5.4.4. Дотор бээлий өмсөнө. Үзлэгийн бээлийг өмсөхийн өмнө хий оруулж цоорхой байгаа эсэхийг шалгана. Бээлий нь комбинзон, халадны ханцуйны дотор талд байна.

5.4.5. Агаар дуслын халдварын үед болон аерозол үүсгэх ажилбар гүйцэтгэх үед шүүлтүүртэй амны хаалт өмсөнө. Хавьтал, дуслын замаар дамжих халдварын үед мэс заслын амны хаалт хэрэглэнэ. Шүүлтүүртэй амны хаалт өмсөж байгаа үед битүүмжлэлийг шалгана. Метал хэсгийг хамрын хэлбэрт тааруулна. Өмсөхдөө аяга хэсгийг алга дотроо, бүчийг гарт сул унжуулж байрлуулна. Ам, хамрын хэсэгт аваачин бүчийг нэг нэгээр нь толгойд углана.

5.4.6. Нүдний шилийг зүүхдээ шилний доод хэсэг амны хаалтны дээд ирмэгийг дарсан байна. Нүүрний хамгаалалт хэрэглэж байгаа үед мэс заслын амны хаалт зүүж болно. Комбинзоны малгайг өмсөж цахилгааныг гүйцээж татна.

5.4.7. Амны хаалт, нүдний шилний бүч комбинзоны малгайны дотор талд байна. Амны хаалт, нүдний шилний бүч үстэй орооцолдохоос сэргийлж комбинзоны малгайны дотор талд нэг удаагийн малгай өмсөж болно.

5.4.8. Гадна бээлий комбинзон эсвэл халадны ханцуйг даруулж өмсөнө. Гарын бугуй хэсэг ил гарахаас сэргийлж комбинзоны ханцуйг цоолж эрхий хуруунд углаж өмсөнө.

5.4.9. Шингэн нэвтрэх эрсдэл ихтэй үед нэмэлтээр хормогч, ханцуйвч өмсөж болно.

5.4.10. Харааны шил тогтмол хэрэглэдэг эрүүл мэндийн ажилтан нүүрний хамгаалалтыг, мэс заслын амны хаалтын хамт хэрэглэнэ.

5.4.11. Хамгаалах хувцас хэрэгслийг өмссөний дараа нүүр, биеийн хэсэг болон хувцас ил гарсан эсэхийг нягтлан шалгана.

5.5. Хамгаалах хувцас, хэрэгслийг тайлах дараалал, анхаарах зүйл:

5.5.1. Халдвартай бүсээс гараад халдварын эрсдэл дунд буюу завсрын бүсэд хамгаалах хувцас хэрэгслээ тайлна.

5.5.2. Хамгаалах хувцас хэрэгслийг тайлахдаа эмнэлгийн орчин болон өөрийн хувцас, арьс, салстыг бохирдуулахаас сэргийлж огцом ширүүн хөдөлгөөн хийхгүй.

5.5.3. Гаднах бээлийг бохирдол багатай бугуй хэсгээс барьж 1 гарын бээлийг тайлж нөгөө гарт атгана. Нөгөө гарын бээлийний дотор талаас гадагш эргүүлж тайлна.

5.5.4. Комбинзоны цахилгааныг доошлуулж малгай хэсгээс эхэлж тайлна. Гадна, урд хэсэг бохирдол ихтэй гэж үзэн аль болох хүрэхгүй. Комбинзоны гадна талд хүрэхгүйгээр дотор талаас гадагш эргүүлэх хөдөлгөөнөөр тайлна.

5.5.5. Гутлын гадуурх улавчийг комбинзонтой хамт тайлна. Усны гутал өмссөн бол халдваргүйжүүлэх уусмалд дүрж дээрээс доош эргэлдүүлэх хөдөлгөөнөөр губкээр угааж, халдваргүйжүүлээд тайлна.

5.5.6. Дотор бээлийг гадна бээлийний нэгэн адил тайлна. Дотор бээлийг тайлсны дараа гарын эрүүл ахуйг сахина.

5.5.7. Толгойг бөхийлгөн нүдний шилний бүч хэсгээс барьж дээш, урагш татах хөдөлгөөнөөр тайлна. Дахин гараа халдваргүйжүүлнэ.

5.5.8. Шүүлтүүртэй амны хаалтыг тайлна. Толгойг бөхийлгөн доош тонгойж 2 бүчийг нийлүүлж бариад дээш, урагш татах хөдөлгөөнөөр тайлна.

5.5.9. Гарын эрүүл ахуйг сахина.

5.6. Халдвар дамжих эрсдэл өндөртэй шинэ халдварын үед хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх тусгай журам, зааврыг мөрдөнө.

### **Зургаа. Шүүлтүүртэй амны хаалтын тохироо шалгах**

6.1. Гараараа амны хаалтны өмнө талаас барьж огцом амьсгаа гаргахад хамгаалалт дотор нэмэх даралт үүсч гадагш хий гарахгүй байна.

6.2. Гүнзгий амьсгаа авахад сөрөг даралт үүсч хамгаалалт таны нүүрэнд наалдана. Хэрвээ нүх гарсан, зөв байрлаагүй, эсвэл бүч сул бол дахин шалгана.

6.3. Шүүлтүүртэй амны хаалтны тохироо шалгах чанарын арга - Тохироо шалгах чанарын сорил нь үндсэн 2 үе шаттай. Эхлээд мэдрэг байдлын сорил явуулж, мэдрэг байдлын уусмалын амт, үнэрийг мэдэрсэн хүнд шүүлтүүртэй амны хаалт зүүлгэн, тохироог чанарын аргаар шалгана. (Сүрьеэгийн халдварын сэргийлэлт, хяналтын заавраас дэлгэрүүлж харах)

Хүснэгт 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх

Ажилбар	Гарын эрүүл ахуй	Үзлэгийн бээлий	Ариун бээлий	Мэс заслын амны хаалт	Нүдний шил/ нүүрний хамгаалалт	Халад
Тогтмол хяналт /АД хэмжих/	+	-	-	-	-	-
Эмчийн үзлэг	+	-	-	-	-	-
Гэмтсэн арьс, салстад хүрэлцэх бол	+	-	+	+	-	+
Булчин тариа хийх	+	-	-	-	-	-



Судсаар тариа хийх	+	+	-	-	-	-
Судасны цуснаас шинжилгээ авах	+	+	-	-	-	-
Шингэн цацагдах эрсдэлтэй бол	+	+	-	+	+	+
Шарх боох/шалгах	+	+	+ /шарханд хүрэх бол/	+	-	+ /их хэмжээний халдварлагдсан шарх/
Цусанд сахар, гемоглобин хянах	+	+	-	-	-	-
Үтрээний үзлэг	+	-	+	-	+	+
Судсанд гуурс тавих	+	+	-	-	+ /цацагдах эрсдэлтэй/	-
Судсанд суулгац тавих	+	-	+	+	+	
Судасны суулгацын арчилгаа	+	-	+	-	-	-
Мэс заслын асептик үйл ажиллагаа	+	-	+	+	+	+
Шээлгүүр тавих	+	-	+	+	+	+
Шээлгүүрийн арчилгаа	+	+	-	-	+ / өртөх эрсдэлтэй/	+ / өртөх эрсдэлтэй/
Соруулга хийх	+	-	+ /нээлттэй соруулга/	+	+	+ /өртөх эрсдэлтэй/
Шүдний мэс ажилбар	+	-	+	+	+	+
Шүдний ажилбар	+	+	-	+	+	+ /өртөх эрсдэлтэй/

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 4/537 дугаар тушаалын  
наймдугаар хавсралт

## **ЭМНЭЛГИЙН ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ЦАГААН ХЭРЭГЛЭЛ УГААХ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Эрүүл мэндийн байгууллага нь орны тоо, хүчин чадалдаа тохирсон зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, ЭМА-ны ажлын хувцас угаах угаалгын газартай байна.
- 1.2. Угаалгын газар бохир хэрэглэлийг ангилан ялгах, халдваргүйжүүлэх, угаах, индүүдэх, цэвэр хэрэглэлийг хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 1.3. Халдваргүйжүүлэлт, угаалга нь бичил биетний тоог бууруулдаг, халуун индүүгээр индүүдэх нь бичил биетнийг устгадаг тул индүүдэхдээ тасаг, нэгжид хийхгүй угаалгын газарт хийнэ.
- 1.4. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангах цэвэрхэн, өнгө үзэмжтэй цагаан хэрэглэлээр хангагдсан байна.
- 1.5. Мэс засал, төрөх, сэхээн амьдруулах, тусгаарлах, халдварт, сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгсдийг эмнэлгээс цагаан хэрэглэлээр хангана гэрээс авчруулж хэрэглэхгүй. Бусад тасагт үйлчлүүлэгч өөрөө хүсвэл цагаан хэрэглэлээ авчирч хэрэглэж болох ба эмнэлгээс гарахад нь угааж, халдваргүйжүүлэх зааврыг өгнө.
- 1.6. Үйлчлүүлэгчийн цагаан хэрэглэлийг бохирдсон тохиолдол бүрт солино.

### **Хоёр. Угаалгын газарт тавигдах шаардлага**

- 2.1. Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр хэсэгтэй байна. Бохир хэсэгт бохир хэрэглэлийг ангилан ялгах, угааж халдваргүйжүүлэх, цэвэр хэсэгт индүүдэх, хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 2.2. Угаалгын газрын өрөө тасалгаа нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр, бохир усны шугамд холбогдсон, зөөврийн усан хангамжтай үед угаалгын үйлчилгээнд хүрэлцэхүйц хэмжээний ус нөөцлөх савтай, ус зөөвөрлөх, халаах хэрэгслээр хангагдсан байна.
- 2.3. Угаалгын газрын өрөөний шал нь резинэн хулдаас, ус зайлуулах хоолойтой, хана нь шаазан хавтан, таазыг эмульсдсэн байна. Шал-хана, тааз-ханын хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

2.4. Угаалгын газаргүй эрүүл мэндийн байгууллагууд нь нярайн даавуу болон мэс ажилбар, төрөлтөд хэрэглэх даавуун хэрэглэлээс бусад зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, ажлын хувцсыг халдваргүйжүүлэх, угаах, индүүдэх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.5. Гэрээгээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд угаалгын газарт угаалгасан материалын бүртгэл хөтөлж гэрээт газраар баталгаажуулсан байна.

2.6. ЭМА-ны ажлын хувцас, нярай, мэс засал, төрөхийн цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг тус, тусад нь, бусад тасгийн цагаан хэрэгслийг халдварын эрсдэл өндөртэй (халдварт, сүрьеэгийн тасаг, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийн, цус, шээс, гэх мэт биологийн шингэнээр бохирлогдсон), халдварын эрсдэл багатай гэж ангилж угаах тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

### **Гурав. Ангилан ялгах, халдваргүйжүүлэх**

3.1. Ор хөнжлийн даавуу, дэрний уут, гудас, матрасны гаднах уутыг үйлчлүүлэгч эмнэлгээс гарах болон бохирдсон тохиолдол бүрт цэвэр хэрэгслээр солиж бохир хэрэгслийг угаалгад өгнө.

3.2. Үйлчлүүлэгчийн орноос бохир цагаан хэрэглэлийг авахдаа орчинд бохирдлыг тараахаас сэргийлж хуйлах, эвхэх байдлаар авна.

3.3. Гудас, матрас нь эмнэлгийн зориулалттай гаднах өнгө нь ус нэвтэрдэггүй бол тасагт нь халдваргүйжүүлж, угааж болно.

3.4. Хөнжил, бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг угаалгын газарт өгч халдваргүйжүүлж, угаалгана.

3.5. Хөвөнтэй, угаахад тохиромжгүй материалаар хийгдсэн хөнжил, гудас, матрас, дэрийг биологийн шингэнээр бохирлогдоогүй бол дезкамер болон озоноор халдваргүйжүүлэлт хийнэ.

3.6. Тасаг, нэгж бүр бохир хэрэгслийг зөөвөрлөх ус нэвтэрдэггүй зориулалтын уут, тэргэнцэртэй байна. Даавуун уут хэрэглэж байгаа тохиолдолд уут нь бариултай байх ба зөөвөрлөх ажилтан бээлий өмсөнө.

3.7. Бохир хэрэгслийг уутанд дүүргэж хийхгүй 5 хүртэл хэмжээгээр хийнэ. Бохир хэрэгслийг зөөвөрлөж байгаа уут нь цэвэр хэрэгслийн уутнаас өнгөөр ялгасан байна. Уутыг угааж, халдваргүйжүүлж, индүүднэ.

3.8. Бохир хэрэгслийг тасаг, нэгжээр нь бүртгэн хүлээн авч бохирдолтын байдлаар нь халдвартай үйлчлүүлэгчийн, биологийн шингэнээр бохирлогдсон, хир ихтэй гэх мэтээр ангилан угаалгад шилжүүлнэ.

3.9. Бохир хэрэгсэлтэй ажиллаж байгаа ажилтан нүдний салст хамгаалах нүдний шил, нүүрний хаалт, амны хаалт, усанд тэсвэртэй бээлий, халад, хулдаасан хормогч, ханцуйвчаар хангагдсан, хэрэглэж хэвшсэн байна.

### **Дөрөв. Угаах, хадгалах**

4.1. Угаалганд эмнэлгийн зориулалттай халдваргүйжүүлэх үйлчилгээтэй угаалгын бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэнэ.

4.2. Халдваргүйжүүлэх үйлчилгээгүй ахуйн зориулалтын угаалгын бодис хэрэглэж байгаа үед бохир хэрэгслийг эхэлж халдваргүйжүүлсний дараа угаана. Халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, хэрэглэнэ.

4.3. Хагас автомат угаалгын машин болон гараар угааж байгаа тохиолдолд мушгиж, сэгсэрсний дараа цэвэр усаар угаалгын бодисын үлдэгдлийг арилтал угаана.

4.4. Угаах хэрэгслийн халдварын эрсдлээс шалтгаалан эрсдэл багатайгээс эхэлж угаана. Угаалга хооронд машин, савны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж дараагийн хэрэгслийг угаана.

4.5. Угаалгаас гарсан хэрэгслийг халуун агаараар хатаах төхөөрөмжийг ашиглан хатаахаас гадна нарны гэрэлд хатааж болно.

4.6. Цэвэр хэрэгслийг шалнаас дээш 10-15 см өргөгдсөн, хангалттай хэмжээний тавиур бүхий шүүгээнд хадгална.

4.8. Цагаан хэрэгслийг зориулалтын уутанд багцалж савлана. Цэвэр хэрэгслийг тасаг нэгж рүү зөөвөрлөх уут тусдаа байна.

### **Тав. Угаалгын газрын үйл ажиллагаанд хяналт тавих загвар хуудас**

д/д	Үнэлгээний асуумж	Хариулт	Оноо
1	Угаалгын тасаг, нэгжийн урсгал зөв, эрүүл ахуйн шаардлагын дагуу зохион байгуулагдсан	Тийм	2
		Үгүй	0
2	Угаалгын тасаг нь цэвэр, бохир хэсгээр тусгаарлагдсан	Тийм	2
		Үгүй	0
3	Угаалгын тасаг халуун, хүйтэн усаар хангагдсан	Төвлөрсөн усан хангамжид холбогдсон халуун, хүйтэн устай	2
		Зөөврийн усан хангамжтай боловч ус халаах, нөөцлөх, бохир ус зайлуулах боломж бүрдүүлсэн	1
		Зөвхөн хүйтэн устай	0
4	Цагаан хэрэглэл зөөвөрлөх тэргэнцэртэй	Тийм	2
		Үгүй	0
5	Угаах төхөөрөмжөөр хангагдсан	Төрөлжүүлж угаах угаалгын машин хангалттай	2
		Угаалгын машин хүрэлцээгүйгээс нэг угаалгын машин ашиглаж ээлжилж	1

		угаадаг	
		Гараар угаадаг	0
6	Хатаах тоног, төхөөрөмжөөр хангагдсан	Хатаах машинтай	2
		Зориулалтын хатаах тавиуртай	1
		Хатаах хэрэгсэлгүйгээс сэгсрээд шууд индүүддэг эсвэл зориулалтын бус хатаагчтай	0
7	Индүүдэх тоног төхөөрөмжөөр хангагдсан	Зориулалтын бул индүүтэй	2
		Ахуйн зориулалтын индүүтэй	1
		Индүүддэггүй	0
8	Эмнэлгийн зориулалтын халдваргүйжүүлэх үйлчилгээтэй угаалгын бодис хэрэглэдэг	Тийм	2
		Үгүй	0
9	Угаалгын газрын ажилтан нь халдвараас сэргийлэх талаар сургалтад хамрагддаг	Жилд 1-ээс доошгүй удаа сургалтад хамруулдаг	2
		Хийдэггүй	0
10	Ажилтныг хамгаалах, хувцас хэрэгслээр бүрэн хангасан	Тийм	2
		Үгүй	0
11	Өртөлтийг бүртгэдэг, өртөлтөөс сэргийлэх иж бүрдэлтэй	Тийм	2
		Үгүй	0
12	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай	Тийм	2
		Үгүй	0
13	Цэвэр хэрэгслийг багцалж савладаг	Тийм	2
		Үгүй	0
14	Хадгалах шүүгээ нь тавиур хүрэлцээтэй, битүү	Хүрэлцээтэй, битүү	2
		Хүрэлцээтэй боловч задгай	1
		Хүрэлцээгүй	0
15	Бохир, цэвэр хэрэгслийг зөөвөрлөх уут тасаг бүрт тусдаа хангалттай хэмжээгээр байдаг	Эмнэлгийн хэмжээнд бүх тасгуудад хангалттай	2
		Зарим тасгуудад хангалтгүй	1
		Хангалтгүй	0
<b>Нийлбэр оноо</b>			<b>30</b>



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 11537 дугаар тушаалын  
есдүгээр хавсралт

## ТУСГААРЛАН СЭРГИЙЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. ЭТҮХХ, эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар, халдварт өвчин, халдварын дэгдэлтийн үед тусгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлж эрүүл мэндийн байгууллагын орчин, ажиллагсад, бусад үйлчлүүлэгчид халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээг зохицуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Тусгаарлалтын үед эрүүл мэндийн байгууллага нь стандарт сэргийлэлтийн арга хэмжээг баримтлахаас гадна нэмэлтээр халдварт дамжих замд суурилсан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

1.3. Стандарт (байнгын) сэргийлэлт: - Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүн бүрт хэрэгжүүлнэ. Халдвараас сэргийлэх зорилгоор тогтмол хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Стандарт сэргийлэлтэд:

1.3.1. Гарын эрүүл ахуй сахих,

1.3.2. Хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх,

1.3.3. Тарилгын аюулгүй байдал,

1.3.4. Орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, угаалгын үйлчилгээ

1.3.5. Багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал

1.3.6. Ханиах найтаах үед халдвар дамжихаас сэргийлэх

1.3.7. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх арга хэмжээг хамруулна.

1.4. Нэмэлт сэргийлэлт: - Дамжих замд суурилсан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэлнэ. Халдварт өвчин, ЭТҮХХ, эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар оношлогдсон тохиолдолд тухайн халдварын дамжих замд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээ нь:

1.4.1. Хавьтлын замаар дамжих халдварын үед хэрэгжүүлэх;

1.4.2. Дуслын замаар дамжих халдварын үед хэрэгжүүлэх;

1.4.3. Агаарын жижиг дуслар, хүнээс хүнд шууд амьсгалын замаар дамжих халдварын гэж ангилна.

1.5. Эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт сэргийлэлт арга хэмжээ шаардлагатай үйлчлүүлэгчийг тусгаарлах боломжтой байна.

1.6. Тусгаарлах өрөө нь ямар зорилгоор ашиглаж байгаагаас шалтгаалан ялгаатай.

1.6.1. Стандарт тусгаарлах өрөө (Class-S) – Хавьтал болон дуслын замаар дамждаг халдварын үед ашигладаг. Нэмэлт агааржуулалт шаардлагагүй.

1.6.2. Агаарын сөрөг даралттай тусгаарлах өрөө (Class-N) – Агаар дуслын замаар дамждаг сүрьеэ, улаанбурхан, салхинцэцэгийн халдварын үед ашиглана.

1.6.3. Агаарын эерэг даралттай тусгаарлах өрөө (Class-P) – Дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгчийг тусгаарлаж эмчлэхэд ашиглана.

1.6.4. Олон улсын хөл хориот өвчний үеийн тусгаарлалт (Class-Q) гэж ангилна.

1.7. Олон улсын хөл хориот өвчний үеийн тусгаарлалт (Class-Q) –ыг ОУЭМД-ээр зохицуулагддаг халдварт өвчин, халдварлах эрсдэл өндөртэй халдварууд, шинэ вирусийн халдварын үед (томуугийн шинэ вирусын халдвар, эбола гэх мэт) олон улсын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.

1.7.1. Тусламж, үйлчилгээний хэсгийг халдвартай бүс, халдварын эрсдэл дунд буюу завсрын бүс, халдваргүй бүс гэсэн 3 бүсээр хувааж тусгаарлалтыг зохион байгуулна.

1.7.2. Халдвартын эмнэлэг, тасагтай эрүүл мэндийн байгууллага олон улсын хөл хориот өвчний үед ашиглах тусгаарлах өрөөтэй байна.

1.7.3. Төрөлжсөн мэргэжлийн төв, тусгай, төв эмнэлэг, дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт Class-Q ангиллын 3 бүсээр тусгаарлах боломжтой өрөөтэй байна.

1.8. Халдварт, сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь агаарын сөрөг даралт бүхий тусгаарлах өрөөтэй (Class-N) байна.

1.9. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг бүх эрүүл мэндийн байгууллага, тасаг, нэгж бүрт стандарт тусгаарлах өрөөтэй байна. Тусгаарлалт хийгээгүй үед өрөөг өдөр тутмын тусламж, үйлчилгээнд ашиглана.

1.10. Дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгчид тусламж үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага агаарын эерэг даралттай тусгаарлах өрөөтэй байна.

1.11. Клиник, өрхийн эрүүл мэндийн төв, амбулаторийн тусламж үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгч илэрвэл түр тусгаарлах боломжийг бүрдүүлсэн байна.

### **Хоёр. Агаарын жижиг дуслуар, хүнээс хүнд амьсгалын замаар шууд дамжих халдварын үед хэрэгжүүлэх тусгаарлан сэргийлэлт**

2.1. Улаанбурхан, салхинцэцэг, томуугийн H7N9, H5N1 вирус, томуугийн шинэ вирусын халдвар, дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгч Varicella-zoster-н халдвартай, уушигны түрхэц эерэг сүрьеэ, MERS коронавирус зэрэг халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлана.

#### **2.2. Тусгаарлалт**

2.2.1. Үйлчлүүлэгчийг аль болох дотроо ариун цэврийн өрөөтэй агаарын сөрөг даралттай нэг хүний өрөөнд тусгаарлана.

2.2.2. Агаарын сөрөг даралттай өрөө байхгүй бол 1 хүний өрөөнд тусгаарлаж хаалгыг хаалттай байлгана. Амьсгалын замаар дамжих халдварын тусгаарлах өрөөний агаар эмнэлгийн бусад хэсэгт тархахааргүй зохион байгуулагдсан байна.

2.2.3. Өрөө хүрэлцээгүй бол ижил үүсгэгчээр үүсгэгдсэн, ижил халдвартай үйлчлүүлэгчдийг хамт тусгаарлаж болно.

2.2.4. Тусгаарлах өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ тавина.

2.2.5 Тусгаарлалтын үед өрөөнөөс гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай оношлогоо, эмчилгээ, яаралтай тусламж үзүүлэх зорилгоор өрөөнөөс гаргах бол нэг удаагийн амны хаалт зүүлгэнэ.

2.2.6 Тусгаарлалт хийх хугацаа нь тухайн өвчин тус бүрийн удирдамж, зааврын дагуу байна.

### 2.3. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх

2.3.1. Эрүүл мэндийн байгууллага нь тусгаарлах өрөөнд ажиллах эрүүл мэндийн ажилтанг сургаж, бэлтгэсэн байна. Ажилтан нь хамгаалах хувцас хэрэгслийг зөв хэрэглэж сурсан, тусгаарлах өрөөнд ажиллах талаар мэдлэгтэй, дадлага, туршлагатай байна.

2.3.2. Улаанбурхан, салхинцэцэгийн халдварын үед тухайн халдварын эсрэг дархлаатай эмч, сувилагч, үйлчилгээний ажилтанг ажиллуулна.

2.3.3. Улаанбурханы халдвартай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх эмнэлгийн ажилтан дархлаагүй бол шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ. Дархлаатай бол шүүлтүүртэй амны хаалт шаардлагагүй.

2.3.4. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх эрүүл мэндийн ажилтан шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ. Амны хаалтын тохироо шалгах сорилуудад хамрагдсан байна.

2.3.5. Амьсгалын замаар дамжих халдварын үед эрүүл мэндийн ажилтан шүүлтүүртэй амны хаалт, эсвэл мэс заслын амны хаалтыг, нүүрний хаалтын хамт хэрэглэнэ.

2.3.6. Аэрозол үүсгэх ажилбарын үед (bronхи дурандах, интубаци тавих, авах, соруулга хийх гэх мэт) шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ.

### 2.4. Тусгаарлалтын үед үйлчлүүлэгч, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага

2.4.1. Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

2.4.2. Тусгаарлалтын үед бусад өрөө тасалгаанд орох, эмнэлэг дотор сэлгүүцэхийг хориглоно.

2.4.3. Онцын шаардлагагүй бол ар гэр, эргэлтээр ирсэн хүмүүсийг тусгаарласан өрөөнд оруулахгүй.

2.4.4. Зайлшгүй шаардлагаар орох бол ЭМА-ы нэгэн адил хамгаалах хувцас хэрэгсэл өмсөнө.

### 2.5. Тусгаарлах өрөөний цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт

2.5.1. Үйлчлүүлэгчид хэрэглэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж аль болох тусдаа байх, багажийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг батлагдсан зааврын дагуу хийнэ.

2.5.2. Тусгаарлах өрөөний цэвэрлэгээг зааврын дагуу хийнэ. Нэмэлт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт шаардлагагүй.

2.5.3. Тусгаарлах өрөөний салхивчыг нээн гадна орчны агаартай агаар сэлгэлт хийнэ.



2.6. Шилжих хөдөлгөөнийг хязгаарлана. Зайлшгүй шилжүүлэх бол очих газарт урьдчилан мэдэгдэнэ. Үйлчлүүлэгчид мэс заслын амны хаалт, эмнэлгийн ажилтан шүүлтүүртэй амны хаалт зүүнэ.

2.7. Амбулатори, өрх, клиникийн эмнэлэгт тусгаарлан сэргийлэлтийг хэрэгжүүлэх

2.7.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй эрүүл мэндийн байгууллагад үзлэгийн үед амьсгалын замаар дамжих халдварын сэжигтэй үйлчлүүлэгч илэрвэл тухайн өрөөнд нь түр тусгаарлаад халдвартын эмнэлэг, тасагт шилжүүлнэ.

2.7.2. Үзлэг, оношлогооны өрөө бүрт эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчид хэрэглэх амны хаалт байна.

2.7.3. Түр тусгаарлах үед үйлчлүүлэгчид нэг удаагийн амны хаалт зүүлгэнэ.

### **Гурав. Дуслын замаар дамжих халдварын тусгаарлан сэргийлэлт**

3.1. Улирлын томуу, улаанууд, сахуу, хөхүүл ханиад, гахай хавдар, менингококкт халдвар, стрептококк групп А үүсгэгдсэн халдвар, эритема, тарваган тахлын уушигны хэлбэр, *Haemophilus influenzae type B*, аденовирүсээр үүсгэгдсэн уушигны хатгаа, риновирусын халдвар, метицилинд тэсвэртэй болон тэсвэргүй стафилококк ауреусаар үүсгэгдсэн уушигны хатгаа, Ласса, эбола, малбург, Крым-Конгын цусархаг халууралт зэрэг халдварын үед дуслын сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2. Тусгаарлалт

3.2.1. Дуслын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчийг дотроо ариун цэврийн өрөөтэй нэг хүний өрөөнд тусгаарлана.

3.2.2. Өрөө, тасалгаа хүрэлцэхгүй тохиолдолд ижил халдвартай хүмүүсийг нэг өрөөнд байрлуулж болно. Үйлчлүүлэгчийн ор хоорондын зай 2 метрээс багагүй байна. Толгой-хөл гэсэн зарчмаар зөрүүлж байрлуулна. 2 метрээс дотогш зайд бол ор хооронд хөшгөөр тусгаарлана.

3.2.3. Хаалга онгорхой байхад халдвар тархах эрсдэлгүй.

3.2.4. Тусгаарласан өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ хэрэглэнэ.

3.2.5. Тусгаарлалт хийсэн өрөөнд үйлчлүүлэгчийн түүх, цахим төхөөрөмжийг оруулахгүй.

3.2.6. Тусгаарлалтын үргэлжлэх хугацаа нь тухайн өвчний удирдамж, зааварт тусгагдсан халдваргүй болох хугацааг баримтлана.

3.3. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх

3.3.1. Тусгаарлах өрөөнд ажиллах эрүүл мэндийн ажилтан нь сургаж бэлтгэгдсэн байна. Хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх, халдвараас сэргийлэх мэдлэг, дадалтай байна.

3.3.2. Дуслын замаар дамжих халдварын үед нүд, ам, хамрын салстыг хамгаална.

3.3.3. Тусгаарлах өрөөнд орох, дуслын халдвартай үйлчлүүлэгчид 1 метрээс дотогш зайд тусламж үзүүлэх ажилтан нь мэс заслын амны хаалт хэрэглэнэ. Шүүлтүүртэй амны хаалт шаардлагагүй. Дусал үсрэх эрсдэлтэй бол нүдний шил зүүнэ.

3.3.4. Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээнд тохируулан хамгаалах хувцсыг сонгож хэрэглэнэ. Тухайлбал: Судасны гуурс тавих бол ариун бээлий, нэг удаагийн халад, амны хаалт, өрөөг цэвэрлэх бол халад, амны хаалт, ахуйн бээлий гэх мэт.

3.3.5. Гарын эрүүл ахуйг сахина.

3.3.6. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тохиолдолд тухайн өвчний эсрэг дархлаа тогтсон эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.3.7. Дархлаатай эмнэлгийн ажилтанд шингэн үсрэх эрсдэлгүй ажилбар гүйцэтгэх бол нүд, ам, хамрын салстыг хамгаалах хэрэгсэл шаардлагагүй.

3.4. Тусгаарлалтын үед үйлчлүүлэгч, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага.

3.4.1. Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3.4.2. Оношлогоо, эмчилгээ, яаралтай тусламж зэргээс бусад тохиолдолд өрөөнөөс гаргахгүй, бусад өрөө тасалгаанд орохыг хориглоно.

3.4.3. Тусгаарлагдан эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч оношлогоо, эмчилгээний зорилгоор өөр тасаг, кабинетаар үйлчлүүлэх бол амны хаалт зүүнэ.

3.4.4. Тусгаарлалтын үед бусад өрөө тасалгаанд орох, эмнэлэг дотор сэлгүүцэхийг хориглоно.

3.4.5. Ар гэр, эргэлтээр ирсэн хүмүүс тусгаарласан өрөөнд орох бол амны хаалт зүүлгэж гарын эрүүл ахуй сахина.

3.5. Үйлчлүүлэгчид хэрэглэсэн тоног төхөөрөмж, өрөөг цэвэрлэх

3.5.1. Үйлчлүүлэгчид хэрэглэх хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аль болох тусад нь хэрэглэнэ. Даралтны аппарат, чагнуур, халуун хэмжигч гэх мэт.

3.5.2. Багажийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг батлагдсан зааврын дагуу хийнэ.

3.5.3. Тусгаарласан өрөөнд хуурай цэвэрлэгээ хийхгүй, шүүр ашиглахгүй чийгтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ. Цэвэрлэгээ хийх нийтлэг зааврыг баримтлана.

3.6. Үйлчлүүлэгчийг өөр тасаг нэгж, эмнэлэг рүү шилжүүлэхэд амны хаалт зүүлгэнэ. Шилжих хөдөлгөөнийг аль болох хязгаарлана. Зайлшгүй шилжүүлэх бол очих газарт урьдчилан мэдэгдэнэ.

3.7. Гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа үед гэрт хийх цэвэрлэгээ, тусгаарлалт, халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар эмч зөвлөгөө өгнө.

## **Дөрөв. Амьсгал болон дуслуар дамжих халдварын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх арга хэмжээ**

4.1. Томуу, томуу төст өвчин, улаанбурхан зэрэг агаар дусал, дуслын замаар дамждаг халдварт өвчний дэгдэлтийн үед халдвартай болон халдварын сэжигтэй шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзлэгийн хэсгээс эхлэн тусгаарлах арга хэмжээг авна.

4.2. Клиник, амбулатори, үзлэгийн хэсэгт хэрэгжүүлэх халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.2.1. Дэгдэлтийн үед эмнэлгийн орох хэсгээс эхлэн халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг олон хүнтэй хавьтал болохоос сэргийлж тусгаарлах арга хэмжээ авна.

4.2.2. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохооргүй байрлалтай хэсэгт тухайн халдварт зориулсан үзлэгийн өрөөг тусад нь зохион байгуулна.

4.2.3. Эмнэлгийн орох хэсэгт хөтөч сувилагч ажиллуулна. Эсвэл угтах хэсэгт ажиллаж байгаа ажилтан халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөө рүү чиглүүлж, амны хаалт зүүлгэнэ.

4.2.4. Хөтөч, угтах үйлчилгээний ажилтан ажиллуулах боломжгүй бол “Дуугүй хөтөч” – ажиллуулж болно. “Дуугүй хөтөч”-ийг нүдэнд ил тод харагдахаар байрлуулж ойлгомжтой үг, дүрслэлээр илэрхийлсэн байна.

4.2.5. Эмнэлгийн орох хэсэгт үйлчлүүлэгчид зориулсан амны хаалт, гарын эрүүл ахуй сахих боломжийг бүрдүүлсэн байна.

4.2.6. Гаднаас орж ирж байгаа үйлчлүүлэгчид амны хаалт хэрэглэхийг анхааруулсан, санамжийг эмнэлгийн гадна болон дотор хэсэгт ил тод харагдахаар байрлуулна.

4.2.7. Урсдаг самбар, телевиз, зурагт хуудас зэрэг сурталчилгааны хэрэгслийг ашиглан тухайн халдвараас сэргийлэх талаар иргэдэд зориулсан анхааруулга санамжийг өгнө.

4.2.8. Амьсгал, дуслын замын халдвартай үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөөний үүдэнд олон хүний бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохицуулна. Үзлэгийн өрөө, эмчийн тоог нэмэгдүүлэх гэх мэт.

4.2.9. Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй хүнээс 3 алхам буюу 1 метрийн зай барих, амны хаалт зүүх, ханиах, найтаах үед сальфетка хэрэглэх, сальфетка байхгүй үед тохой руу найтаах санамжийг үйлчлүүлэгчид өгнө. Санамж, анхааруулгыг үзлэгийн өрөөний үүд хэсэгт байршуулна.

4.2.10. Дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад олон хүний бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

4.2.10.1. Өрх, сумын эрүүл мэндийн төв гэрийн эргэлт, гэрээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх;

4.2.10.2. Цагийн хуваарийн зохицуулалт хийх - Товлолт үзлэг, дархлаажуулалт, эм бичих зэрэг яаралтай биш тусламж, үйлчилгээг цагийн хуваариар зохицуулах;

4.2.10.3. Хүн амд чиглэсэн халдвараас сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн сайн дурын ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх гэх мэт.

4.3. Хэвтэн эмчлүүлэх эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.3.1. Дэгдэлтийн үед халдвартай үйлчлүүлэгчийг тусгаарлаж эмчлэх боломжийг бүрдүүлсэн байна.

4.3.2. Ижил халдвартай үйлчлүүлэгчдийг 1 өрөөнд олноор тусгаарлан эмчилж байгаа үед ор хоорондын зай 2 метрээс багагүй, хөл, толгойн зарчмыг баримтлана.

4.3.3. Үйлчлүүлэгч бүрт халдварын үүсгэгчийг илрүүлж тусгаарлаж чадахгүй үед эмнэлзүйн шинж тэмдэгт тулгуурлан ижил шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчдийг 1 өрөөнд хамтад нь тусгаарлана.

4.3.4. Эмчилгээ хийгээд тодорхой хугацаа өнгөрсөн, эмчилгээний үр дүнд эмнэл зүйн шинж тэмдэг арилж гарах гэж байгаа эмчлүүлэгчтэй өрөөнд гаднаас шинээр ирсэн өвчтөнг нэмж авахгүй.

4.3.5. Үзлэг, эмчилгээ, үйлчлүүлэгчийн өрөөнд гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.3.6. Хэвтэн эмчлүүлэх өрөө нь гадна орчны агаартай агаар сэлгэх боломжтой байна.

4.3.7. Томуу, томуу төст өвчин болон бусад халдварын дэгдэлтийн үед үйлчлүүлэгчийг өрөөнөөс гаргахгүй тариа хийх, утлага, шарлага гэх мэт эмчилгээг аль болох өрөөнд хийх боломжийг бүрдүүлнэ.

4.3.8. Зайлшгүй шаардлагаар өрөөнөөс гарч эмчилгээ, оношлогоо хийлгэх бол тухайн газарт мэдэгдэж олон хүнтэй хавьтал болохоос сэргийлнэ. Амны хаалт зүүлгэнэ.

4.3.9. Эрүүл мэндийн байгууллагад тухайн халдварын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч их байгаа бол физик эмчилгээ, шаардлагатай оношлогооны хэсгийг тусад нь зохион байгуулна.

4.3.10. Улаанбурханы халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн бусад тасаг нэгжид халдвартай болон халдвар авсан байж болзошгүй үйлчлүүлэгчийг оруулахаас сэргийлж хүлээн авахын эмч болон эмчлэгч эмч тархвар судлалын асуумж авна.

4.3.11. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд шинж тэмдэгийн тандалт хийж халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг эрт тусгаарлах арга хэмжээг авч ажиллана.

4.3.12. Эмнэлгийн ачаалал их байгаа, орны тоо хүрэлцэхгүй үед архаг өвчнийг эмчилдэг тасаг нэгжийн үйл ажиллагааг зогсоож тухайн халдварыг эмчлэх тасгийг нээж ажиллуулна. Эмнэлэг тус бүрийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

4.3.13. Улаанбурханы халдварын дэгдэлтийн үед дархлаатай (уг халдвараар өвдсөн эсвэл 2 тун вакцинд хамрагдсан) эрүүл мэндийн ажилтны судалгааг гаргасан байна.

4.3.14. Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэхэд биечлэн оролцдог эрүүл мэндийн ажилтныг жил бүр улирлын томуугийн дархлаажуулалтад хамруулна.

4.3.15. Эрүүл мэндийн ажилтны дунд тухайн халдвар илрүүлэх шинж тэмдэгийн тандалтыг тасаг, нэгжийн халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан, ахлах сувилагч хийнэ.

4.3.16. Эрүүл мэндийн ажилтанд халдварын шинж тэмдэг илэрвэл ажлаас түр чөлөөлнө.

### **Тав. Хавьтлын замаар дамжих халдварын тусгаарлан сэргийлэлт**

5.1. Олон эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай болон колонизаци, суулгалт халдварууд, гепатитын А, Е вирусын халдвар, шархны халдвар, халдварт саа, тарваган тахлын ходоод гэдэсний зам болон булчирхайн хэлбэр, боом, урвах тахал, гар хөл амны өвчин, А бүлгийн стрептококкоор үүсгэгдсэн инвазив халдвар, балнад, *Herpes Simplex* вирусээр үүсгэгдсэн арьсны халдвар, бүсэлхий яр, эбола вируст халдварын үед хавьтлын сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### 5.2. Тусгаарлалт

5.2.1. Хавьтлын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчийг дотроо ариун цэврийн өрөөтэй нэг хүний өрөөнд тусгаарлана. Ижил халдвартай үйлчлүүлэгчдийг хамт тусгаарлаж болно.

5.2.2. Хаалга онгорхой байхад халдвар тархах эрсдэлгүй.

5.2.3. Оношлогоо, эмчилгээ, яаралтай тусламж зэргээс бусад тохиолдолд өрөөнөөс гаргахгүй, бусад өрөө тасалгаанд орохыг хориглоно.

5.2.4. Тусгаарлалтын үед тусгаарласан өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ хэрэглэнэ.

#### 5.3. Эрүүл мэндийн ажилтанг халдвараас сэргийлэх

5.3.1. Эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээний бүх үед бээлий хэрэглэнэ.

5.3.2. Үйлчлүүлэгч, түүний орчинд хүрэлцэх үед нэг удаагийн халад өмсөнө.

5.3.3. Шингэн нэвчих эрсдэл ихтэй үед хормогч, ханцуйвч зэргийг нэмэлтээр өмсөнө.

5.4. Тусгаарлах өрөөний тоног төхөөрөмж, өрөөний цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт

5.4.1. Үйлчлүүлэгчид хэрэглэх хэрэгсэл, тоног төхөөрөмж тусдаа байх, бусад өрөө тасалгаанд дамжуулахгүй.

5.4.2. Багажийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг батлагдсан зааврын дагуу хийнэ.

5.4.3. Тусгаарласан өрөөг цэвэрлэгээ хийх зааврын дагуу цэвэрлэнэ. *C.difficile* болон эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай үйлчлүүлэгчийн өрөөнд нэмэлт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.

5.4.4. Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарсны дараа эмнэлгийн хөшиг болон даавуун хэрэгслийг угааж, халдваргүйжүүлнэ.

5.5. Үйлчлүүлэгчийг өөр тасаг нэгж, эмнэлэг рүү шилжүүлэхдээ эмнэлгийн ажилтан бээлий, халад өмсөнө. Очих газарт урьдчилан мэдэгдэнэ.

5.6. Шилжүүлсний дараа тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

5.7. Гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа үед гэрт хийх цэвэрлэгээ, тусгаарлалт, халдвараас сэргийлэх талаар зөвлөгөө өгнө.

## СЭРЭМЖЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, БИЧИЛ БИЕТНИЙ ЖАГСААЛТ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагад эмнэлзүйн шинжлэгдэхүүнээс (илрүүлэг шинжилгээг тооцохгүй) "Сэрэмжлүүлэх бичил биетэн"-ий жагсаалтад орсон бичил биетэн илэрсэн тохиолдолд мэдээлэл, дохиолол өгч халдвараас сэргийлэх, хяналтад авах арга хэмжээг эрчимжүүлнэ.

1.2. Эмнэлэгт сэрэмжлүүлэх бичил биетний халдварын 1 тохиолдол илэрвэл халдвар тус бүрийн холбогдох заавар, удирдамжийн дагуу, 2 ба түүнээс олон тохиолдол илэрвэл халдварын дэгдэлтийн үед ажиллах журмын дагуу арга хэмжээ авна.

1.3. Эмэнд тэсвэртэй бичил биетний онцгой фенотип илэрсэн тохиолдолд эмэнд тэсвэртэй бичил биетний халдвараас сэргийлэлт, хяналтын зааврын дагуу ажиллана.

### Хоёр. Сэрэмжлүүлэх бичил биетний жагсаалт

2.1. Халдвараас сэргийлэх арга хэмжээ шаардлагатай сэрэмжлүүлэх бактерийн жагсаалт.

2.1.1. Эмнэлгийн аль нэг тасаг, нэгжийн үйлчлүүлэгчээс дараах бактери өсгөвөрлөгдөх;

1. *Bacillus anthracis*
2. *Clostridium difficile*
3. *Bordetella pertussis*
4. *Corynebacterium diphtheria/ulcerans*
5. *Legionella spp*
6. *Mycobacterium tuberculosis complex*
7. *Neisseria meningitides*
8. *Staphylococcus aureus*
9. *Staphylococcus aureus – PVL*
10. *Streptococcus pyogenes*

2.1.2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтөрөгч бактери

1. *Campylobacter spp,*
2. *Escherichia coli* (хор ялгаруулагч омог)
3. *Salmonella spp*
4. *Shigella spp*

2.1.3. Эрчимт эмчилгээ, нярайн эрчимт эмчилгээ, хавдар, цусны эмгэг судлалын тасгийн үйлчлүүлэгчээс эмнэлгийн орчны дараах бактери өсгөвөрлөгдөх;

1. *Pseudomonas aeruginosa*,
2. *Acinetobacter spp*,
3. *Stenotrophomonas maltophilia*,
4. *Serratia marcescens*

2.1.4. Эмэнд тэсвэржсэн дараах бактери өсгөвөрлөгдөх;

1. Өргөтгөсөн үйлдэлтэй бетта лактамаза ялгаруулагч (ESBL)
2. Ванкомицинд тэсвэржсэн энтерококк (VRE)
3. Карбапенемд тэсвэржсэн энтеробактери (CRE)
4. Олон эмэнд тэсвэржсэн (MDR) болон маш олон эмэнд тэсвэржсэн (XDR) *M. tuberculosis* комплекс

2.1.5. Эмэнд тэсвэржсэн онцгой хэвшинж бүхий дараах бактери илрэх

Ид	Бичил биетний нэр	Эмийн тэсвэржилт
<b>1. Грам сөрөг бактерийн онцгой тэсвэртэй хэвшинж</b>		
1	<i>Enterobacteriaceae</i>	Колистинд тэсвэртэй ( <i>Proteae</i> ба <i>Serratia marcescens</i> -ээс бусад), Меропенем болон / эсвэл имипенемд тэсвэртэй ( <i>Proteae</i> – <i>Proteus spp</i> , <i>Providencia spp</i> ба <i>Morganella spp</i> -ээс бусад)
2	<i>Salmonella typhi</i>	Фторхинолин эсвэл карбапенемд тэсвэртэй
3	<i>Pseudomonas aeruginosa</i> , <i>acinebacter spp</i>	Колистинд тэсвэртэй
4	<i>Acinetobacter baumannii</i>	Карбапенемд тэсвэртэй
5	<i>Haemophilus influenzae</i>	Цефалоспорины гуравдугаар уламжлал, карбапенем, фторхинолинд тэсвэртэй
6	<i>Moraxella catarrhalis</i>	Цефалоспорины гуравдугаар уламжлал эсвэл фторхинолинд тэсвэртэй
7	<i>Neisseria meningitidis</i>	Цефалоспорины гуравдугаар уламжлал эсвэл фторхинолинд тэсвэртэй
8	<i>Neisseria gonorrhoeae</i>	Спектиномицин эсвэл азитромицин эсвэл цефалоспорины гуравдугаар уламжлалд тэсвэртэй.
<b>2. Грам эерэг бактерийн онцгой тэсвэртэй хэвшинж</b>		
1	<i>Staphylococcus aureus</i>	Ванкомицин, тейкопланин, телаванцин, далбаванцин, оритаванцин, даптомицин, линезолид, тедизолид, квинупристин-дальфопристин ба тигециклин, цефтаролин эсвэл цефтобифрол зэрэгт тэсвэртэй
2	Коагулаза сөрөг <i>Staphylococcus</i>	Ванкомицин, телаванцин, далбаванцин, оритаванцин, даптомицин, линезолид, тедизолид, квинупристин-дальфопристин эсвэл тигециклинд тэсвэртэй
3	<i>Corynebacterium spp</i>	Карбапенем, ванкомицин, теопланин, телаванцин, далбаванцин, оритаванцин, даптомицин, линезолид, тедизолид, квинупристин-дальфопристин, тигециклин ба рифампицинд тэсвэртэй. Пенициллинд өндөр түвшний тэсвэртэй
4	А, В, С болон G бүлгийн β-цус задлагч стрептококк	Пенициллин, цефалоспорин, ванкомицин, тейкопланин, телаванцин, далбаванцин, оритаванцин, даптомицин, линезолид, тедизолид, квинупристин-дальфопристин ба тигециклинд тэсвэртэй

5	<i>Enterococcus</i>	Даптомицин, линезолид, тедизолид болон тигециклинд тэсвэртэй
<b>3. Агааргүйтэн бактерийн онцгой тэсвэртэй хэвшинж</b>		
1	<i>Bacteroides spp</i>	Метронидазолд тэсвэртэй
2	<i>Clostridium difficile</i>	Метронидазол, ванкомицин, фидаксомицинд тэсвэртэй

Жич: Бичил амь судлалын өдөр тутмын шинжилгээнд дээрх үүсгэгчийн эмийн мэдрэг чанарыг дурдсан эм тус бүрээр шинжилдэггүй. Жагсаалт дахь эмэнд тэсвэржсэн онцгой хэвшинж бүхий илэрсэн бактери тохиолдолд шинжилгээний нарийвчлалыг дахин нягталж, баталгаажуулна.

2.2 Халдвараас сэргийлэх арга хэмжээ шаардлагатай сэрэмжлүүлэх вирусийн жагсаалт.

2.2.1. Эмнэлгийн аль нэг тасаг, нэгжийн үйлчлүүлэгчээс дараах эмгэгтөрөгч вирус илрэх

1. Гепатитын В, С вирус
2. ХДХВ
3. Шинэ коронавирус-(MERS/SARS)
4. Салхин цэцгийн (бүслүүр үлд) вирус-Varicella zoster virus (chickenpox)
5. Улаанбурхан
6. Гахай хавдар
7. Улаанууд
8. Гепатитын А вирус
9. Аденовирус
10. Норовирус
11. Ротавирус

2.2.2. Эрчимт эмчилгээний тасаг, цус, хавдар судлалын тасгийн эмчлүүлэгчээс амьсгалын замын халдвар үүсгэгч дараах вирус илрэх

1. Аденовирус –Adenovirus
2. Иж томуугийн вирус (Parainfluenza)
3. Амьсгалын замын синцитиал вирус (RSV)
4. Томуугийн вирус
5. Парвовирус

2.3. Эрчимт эмчилгээний тасаг, цус, хавдар судлал зэрэг эрсдэл өндөртэй тасгийн эмчлүүлэгчээс дараах мөөг илрэх

1. *Aspergillus spp.*
2. *Pneumocystic jirovecii*
3. *Candida auris*



## 2.4. Үйлчлүүлэгчийн хоол боловсруулах замаас шимэгч илрэх

1. *Cryptosporidium spp*

2. *Giardia lamblia*

### Гурав. Сэрэмжлүүлэх нөхцөл

3.1. Үйлчлүүлэгчид лабораторийн шинжилгээний дүгнэлт гарахаас өмнө дараах жагсаалтад заасан өвчний сэжиг бүхий эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг сэрэмжлүүлэх нөхцөл гэнэ.

3.2. Сэрэмжлүүлэх нөхцөл тодорхойлогдсон үед лабораторийн шинжилгээний дүнг хүлээхгүйгээр халдварын сэргийлэлт, хяналтын албанд даруй мэдээлж халдвараас сэргийлэх арга хэмжээг эрт авч хэрэгжүүлнэ.

Салхин цэцэг/бүсэлхий яр (Herpes zoster)

Сахуу

Хоолны хордлого

Томуу

Улаан бурхан

Менингит

Менингококкийн септицеми

Гахай хавдар

Улаанууд

Хамуу

Улаан эсэргэнэ

Зөөлөн эдийн халдвар ( хүнд зэргийн)

Халдварын сэжиг бүхий суулгалт/ бөөлжилт

Легионеллын халдвар

Сүрьеэ

Балнад/Иж балнад

Нярайн нүдний салстын үрэвсэл

Хүүхдийн экзантем

Тахал

Халдварт саа

Гадаад улсад зорчсон түүхтэй шалтгаан тодорхойгүй халууралт бүхий үйлчлүүлэгч

Вирусийн цусархаг халууралт

Вируст гепатит

Хөхүүл ханиад

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн А/537 дугаар тушаалын  
арваннэгдүгээр хавсралт

## **ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТАНД БИЧИЛ АМЬ СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Бичил амь судлалын лабораторийн үйлчилгээ нь эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх, тандах, бичил биетний эсрэг эмэнд тэсвэржилтийг хянах, халдварын дэгдэлтийг илрүүлэх, хянах үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

1.2. Тухайн эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэл, төрлөөс шалтгаалан бичил амь судлалын лабораторийн шатлал, шинжилгээний цар хүрээг тодорхойлно.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын бичил амь судлалын лаборатори нь халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг хангасан байна.

1.3.1. Лабораторийн магадлан итгэмжлэл ISO 15189 стандартын шаардлага хангасан байна.

1.3.2. Лабораторийн шатлал, биоаюулгүйн зэрэглэлд тохирсон, биоаюулгүйн шаардлага хангасан байна.

1.3.3. Эмнэлзүйн болон шаардлагатай тохиолдолд эрүүл зүйн бичил амь судлалын шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт арга аргачлалын дагуу хийх боломжийг бүрдүүлнэ.

1.4. Халдварын сэргийлэлт, хяналтын баг, бичил биетний эсрэг эмийн менежментийн баг, эм зүйн хороо, чанарын алба, эмнэл зүйч эмч нартай хамтран ажиллана.

### **Хоёр. Бичил амь судлалын лабораторийн үүрэг**

2.1. Тархвар зүйн ач холбогдолтой болон сэрэмжлүүлэх бичил биетэн (сэрэмжлүүлэх бичил биетнийг илрүүлэх хэсгээс харна уу) илэрсэн тохиолдолд халдварын сэргийлэлт, хяналтын баг, хариуцсан мэргэжилтэн, тасаг нэгжид шуурхай мэдээлэх тогтолцоо бүрдүүлсэн байна.

2.1.1. Тархвар зүйн ач холбогдолтой болон сэрэмжлүүлэх бичил биетэн илрэхэд “Дохиолол өгөх” тогтолцоотой байна.

2.1.2. Бичил амь судлалын лаборатори мэдээллийг шуурхай хүргэх нь эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, халдварын тохиолдлыг хянахад чухал үүрэгтэй.

2.2. Бичил амь судлалын шинжилгээний дүнг үндэслэн мэдээллийн сан бүрдүүлэн хадгална.

2.3. Бичил амь судлалын мэдээллийн сан нь ЭТҮХХ-ын тандалт болон бусад үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой байна.

2.4. Эмнэлзүйн бичил амь судлаач нь халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүн байна.

2.5. Эмнэлзүйн бичил амь судлалын лабораторийн мэргэжилтнүүд нь эмнэлзүйн тасгийн эмч, сувилагч нарт шинжлэгдэхүүн авах, хадгалах, тээвэрлэх, шинжилгээний дүнг үнэлэх чиглэлээр сургалт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.

2.6. Тухайн эрүүл мэндийн байгууллагад эмнэлзүйн бичил амь судлаач ажиллуулах боломжгүй тохиолдолд мэргэшсэн шинжээчээс зөвлөгөө авах тогтолцоо бүрдүүлсэн байна.

2.7. Бичил биетний (эмгэгтөрөгч-өвөрмөц) эсрэг эмэнд мэдрэг чанарын шинжилгээний дүнд тулгуурласан антибиограм боловсруулна. Үүнд:

2.7.1. Бичил биетний эсрэг эмийн мэдрэг чанарын шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар (ДЭМБ, CLSI, EUCAST) шинжлэх боломж бүрдүүлсэн байна.

2.7.2. Бичил биетний эсрэг эмэнд мэдрэг чанарын шинжилгээний дүнг WHONET програм хангамж ашиглан мэдээллийн сан үүсгэн хадгалж, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийнэ.

2.7.3. Бичил биетний эсрэг эмэнд мэдрэг чанарын шинжилгээний дүнг үндэслэн ХСХ-ын ач холбогдолтой дүгнэлт гарган тодорхой давтамжаар улирал бүр тасаг, нэгжид эргэн мэдээлнэ.

2.7.4. Эмнэлзүйн бичил амь судлалын лаборатори нь бичил биетний эсрэг эмэнд мэдрэг чанарын шинжилгээний дүнг нэгтгэн хуримтлагдсан антибиограмыг гаргаж эмнэлзүйч, шийдвэр гаргагч нарт жилд 1 удаа мэдээлдэг байна.

### **Гурав. Эрүүл зүйн урьдчилан сэргийлэх шинжилгээ**

3.1. Нийтлэг хэрэглэж байгаа ариутгал, халдваргүйжүүлэх бодисын идэвхи тодорхойлох, бодисын үр дүнг тогтоох шинжилгээг улсын хэмжээнд 2 жил тутамд чадавх бүхий судалгаа, шинжилгээний лабораторийг түшиглэн хийнэ.

3.2. Гемодиализын усанд эндотоксин, бактерийн тоо тодорхойлох шинжилгээг хамгийн багадаа сард нэг удаа хийнэ. Диализын усанд хор бодис (Endotoxin) 0,25 EU/ml –аас бага, нянгийн тоо 100 CFU/ml –ээс ихгүй байна.

3.3. Шүдний өрөмийн усанд бактерийн тоо тодорхойлох шинжилгээг хамгийн багадаа сард нэг удаа хийнэ.

3.4. Эрүүл мэндийн байгууллагад эрүүл зүйн бичил амь судлалын шинжилгээг (агаар, арчдас, ариун материалын шинжилгээ) бүх тасаг нэгжийг хамруулан хийхгүй. Дараах тохиолдолд хийж болно. Үүнд:

3.4.1. ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан үед эрсдэлийг тогтоох, халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээний үр дүнг үнэлэх, эрүүл зүйн шинжилгээгээр өсгөвөрлөсөн үүсгэгчийг, үйлчлүүлэгчээс өсгөвөрлөсөн дэгдэлтийн үүсгэгчтэй фенотип болон генотипийн түвшинд харьцуулан судалж дүгнэлт гаргах;

3.4.2. Цусны хавдартай, дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгчийг эмчилж буй тасаг нэгж, мэс заслын өрөө, дутуу нярай болон нярайн эрчимт

эмчилгээний өрөө зэрэг эрсдэлтэй тасаг нэгжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үр дүнг хянах зорилгоор хийж болно.

3.4.3. Өрөөний агаараас эрүүл зүйн шинжилгээнд агаарын сорьц цуглуулах зориулалтын багаж (air sampler) ашиглан сорьц цуглуулна. Агаарт мөөгний спор илрүүлэх шинжилгээ хийж буй тохиолдолд тунадасжуулах буюу идэвхигүй арга хэрэглэхгүй.

3.5. Агааржуулалтын системд засвар үйлчилгээ хийх, шүүлтүүр солиход агаар дахь бичил биетний бохирдлыг тодорхойлох шинжилгээ хийнэ. (фильтрийн бохирдлын шинжилгээ)

### **Дөрөв. Гемодиализийн шингэн болон усыг шинжлэх бичил амьсудлалын лабораторийн шинжилгээний аргачлал**

4.1. Сорьц цуглуулах:

- Ариун, таглаатай шилэн (эндотоксин үзэх тохиолдолд endotoxin-free эсвэл pyrogen-free тэмдэглэгээтэй) саванд 5-100 мл сорьцыг цуглуулна.
- Гемодиализийн шингэн бэлтгэхэд хэрэглэх усны сорьцыг
  - ус цэвэршүүлэх системээс гарч буй цэгээс
  - Ус нөөцлөх танктай бол түүнээс гарч буй цэгээс
  - Диализийн машинд ус орохын өмнөх цэгээс цуглуулах бөгөөд эхний 1000 мл усыг асгах буюу гоожуулсны дараа 100 мл сорьцыг цуглуулна.
- Гемодиализийн шингэн буюу диализатыг диализатораас гарч буй цэгээс нь буюу диализатораас гарч буй шугамыг салган эхний 100 мл –ийг асгасны дараа 50 мл сорьцыг авна. Эсвэл диализатын шугаман дээр тусгайлан гаргасан сорьц авах хэсгээс (sterile sampling port) авч болно.
- Бактерийн эндотоксин тодорхойлоход эхний 100 мл-ийг асгасны дараа 5 мл сорьц цуглуулна.
- Цуглуулсан сорьцыг тэр даруй лабораторид илгээнэ.

4.2. Шинжилгээ хийх - Сорьцыг боловсруулах, шинжлэхдээ халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан ажиллана.

4.3. Хэрэглэх тэжээлт орчин нь 90-100 мм диаметртэй петрийн аяганд бэлтгэсэн Tryptone glucose extract agar, Reasoners 2A, Trypcase soy agar, Standards methods agar/Plate count agar-ын аль нэгийг хэрэглэнэ.

4.4. Шинжлэх арга:

А. Мембран фильтрийн арга:

1. 50-100 мл хэмжээтэй сорьцыг сайтар хольсны дараа 0.22-0.45 мкм нүх бүхий мембран филтрээр шүүнэ.
2. Мембран филтрээ ариун хавчуураар авч тэжээлт орчны гадаргуу дээр ус шүүгдсэн дээд талаар нь тэжээлт орчны гадаргуу дээр наалдуулан тавина.
3. Tryptone glucose extract agar, Reasoners 2A агар хэрэглэж буй тохиолдолд 20-22°C-т 7 хоног, Trypcase soy agar, Standards methods agar хэрэглэж буй тохиолдолд 35°C-т 48 цаг аэроб нөхцөлд инкубацласны дараа ургасан

колонийн тоог тоолж 1 мл сорьцон дахь бичил биетний тоог колони үүсгэгч нэгжээр тооцон гаргана.

#### Б. Шууд тарих арга (pour-plate spreading technique)

1. 50-100 мл сорьцыг сайтар хольсны дараа 1 мл ба 100 мкл-ийг соруулан авч тэжээлт орчны төвд нь дусаана.
2. Ариун сорьц тараагчаар жигд тараана.
3. Tryptone glucose extract agar, Reasoners 2A агар хэрэглэж буй тохиолдолд 20-22°C-т 7 хоног, Tryptcase soy agar, Standards methods agar хэрэглэж буй тохиолдолд 35°C-т 48 цаг аэроб нөхцөлд инкубацласны дараа ургасан колонийн тоог тоолж 1 мл сорьцон дахь бичил биетний тоог колони үүсгэгч нэгжээр тооцон гаргана.

#### 4.5. Хэвийн хэмжээ нь:

- Бактери <100 КҮН/мл,
- Мөөг <10 КҮН/мл байна.
- Бактерийн эндотоксин <0.25 EU/мл байна.

*Тайлбар:* Tryptone glucose extract agar, Reasoners 2A агарын аль нэгийг хэрэглэж буй тохиолдолд бактери болон мөөгний тоог, Tryptcase soy agar, Standards methods agar-ийн аль нэгийг хэрэглэж буй тохиолдолд зөвхөн бактерийн тоог гаргана.

#### **Тав. Шүдний усыг шинжлэх микробиологийн шинжилгээний аргачлал**

5.1. Сорьц цуглуулах - Шүдний усыг 2 минутын турш өндөр хурдаар гоожуулсны дараа ариун, таглаатай шилэн саванд 100 мл сорьцыг цуглуулна. Сорьцыг тэр даруй лабораторид илгээнэ.

5.2. Хэрэглэх тэжээлт орчин - 90-100 мм диаметртэй петрийн аяганд бэлтгэсэн Tryptcase soy agar, Standards methods agar/Plate count agar-ын аль нэгийг хэрэглэнэ.

#### 5.3. Шинжилгээ хийх:

- Сорьцыг сайтар хольсны дараа 1 мл - ийг соруулан авч тэжээлт орчны төвд нь дусаана.
- Ариун сорьц тараагчаар жигд тараана.
- 25°C-т 48 цаг аэроб нөхцөлд инкубацласны дараа ургасан колонийн тоог тоолж 1 мл сорьцон дахь бичил биетний тоог колони үүсгэгч нэгжээр тооцон гаргана.

#### 5.4. Хэвийн хэмжээ: ≤500 КҮН/мл байна.

2.1.



**УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭ, СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗААВАР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврыг уламжлалт анагаах ухаан болон сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага мөрдөж ажиллана.

1.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага нь дээд шатны байгууллагаас гаргасан бодлогын баримт бичигт нийцүүлэн, өөрийн тусламж, үйлчилгээний онцлогт тохирсон халдвараас сэргийлэх, хянах заавартай байна.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйд тавигдах шаардлага, хангасан байртай байна.

1.4. Уламжлалт, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүд нь эрүүл мэндийн байгууллагад мөрдөх халдвараас сэргийлэх дүрэм, журам, нийтлэг заавруудыг дагаж мөрдөнө.

**Хоёр. Багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал**

2.1. Уламжлалт анагаах ухаан болон сэргээн засах тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь ариутгалын тасаг, хэсэгтэй, эсвэл гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.2. Багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үйл ажиллагааг энэхүү тушаалын 2- хавсралтад заасны дагуу гүйцэтгэнэ.

2.3. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх багаж, хэрэгслийг халдварлах эрсдлээр нь өндөр, дунд, бага эрсдэлтэй гэж 3 ангилна.

Эрсдэл	Хамаарах багаж, хэрэгслүүд	Халдваргүйжүүлэх, ариутгах, арга
Өндөр эрсдэлтэй	Түрэм заслын алт, мөнгөн зүү, шивүүр, самнуур	Цэвэрлэнэ, дунд түвшинд халдваргүйжүүлнэ, автоклаваар ариутгана.
Дунд эрсдэлтэй	Шивүүр, самнуур, хануур засалд хэрэглэдэг бумба	Цэвэрлэнэ, өндөр түвшинд халдваргүйжүүлнэ.
Бага эрсдэлтэй	Бумба	Цэвэрлэнэ, бага түвшинд халдваргүйжүүлнэ.

2.4. Шивүүр, самнуур засал эмчилгээнд зөвхөн шилэн бумба хэрэглэнэ. Заслын үед бумбанд цугласан цусыг шууд хүйтэн ус эсвэл цэвэрлэгээний бодистой уусмалаар цэвэрлээд тагтай саванд хийж ариутгалын тасаг, хэсэг рүү зөөвөрлөнө.

2.5. Түрэм засал эмчилгээнд хэрэглэсэн алт, мөнгөн зүүг хэрэглэсний дараа хүйтэн урсгал усаар угааж, тагтай саванд хийж ариутгалын тасаг, хэсэгт хүргэнэ.

2.6. Соруул засалд хэрэглэсэн шилэн бумбыг үйлчлүүлэгчид хэрэглэсний дараа зориулалтын цэвэрлэгээний бодис бүхий бага түвшний халдваргүйжүүлэх уусмалаар угааж, халдваргүйжүүлээд сайтар цэвэр усаар зайлаад хатааж хэрэглэнэ.

2.7. Нэг удаагаар хэрэглэх зориулалттай багаж, хэрэгслийг нэг удаагаар хэрэглэнэ. Давтан хэрэглэхгүй.

2.8. Уламжлалтын тусламж, үйлчилгээнд дараах багаж, хэрэгслийг 1 удаагаар хэрэглэнэ. Үүнд:

- Уламжлалт эмчилгээний зүү
- Чихний зүү
- Хутганы ир
- Ланцет

### **Гурав. Тусламж, үйлчилгээний үед халдвараас сэргийлэх**

3.1. Эмчилгээний зүү, шивүүр, сам соруул, хануур, түрэм засалд хэрэглэгдэх багажийг цэвэр орчинд, цэвэр гадаргуу дээр урьдчилан бэлтгэнэ.

3.2. Гарын эрүүл ахуйг сахиж, нэг удаагийн бээлий өмсөнө.

3.3. Хануурын хутга, зүүг давтан хэрэглэхгүй, хэрэглэсний дараа шууд аюулгүй хайрцагт хийнэ. Хэрэглэсэн зүүг нугалах, хугалахыг хориглоно.

3.4. Нэг хатгасан зүүг дахин хатгаж хэрэглэхгүй.

3.5. Хануур, шивүүр, зүү тавих арьсны талбайг хатгалт хийхээс өмнө 2 хувийн хлоргексидин, 70 хувийн спирт, эсвэл повидон иодын уусмалаар халдваргүйжүүлнэ.

3.6. Цус үсрэх эрсдэлтэй үед ажилбар хийж байгаа ажилтан нүд, ам, хамрын салстыг хамгаалж амны хаалт, нүдний шил эсвэл нүүрний хамгаалалт өмсөнө.

3.7. Биологийн шингэнд хүрэлцэх эрсдэлтэй бол нэг удаагийн үзлэгийн бээлий өмсөнө.

3.8. Бариа засал, шавар эмчилгээ, татлага зэрэг засал хийж байгаа үед үйлчлүүлэгч хооронд дэвсгэр даавууг солино. Орны гадаргууг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

2.1.



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 29 -ны  
өдрийн 9/537 дугаар тушаалын  
арвангуравдугаар хавсралт

## ТАРИЛГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврыг бүх төрлийн тарилга, зүү эмчилгээ, шивүүр зэрэг арьс салст цоолох ажилбарын үед дагаж мөрдөнө. Зааврын зорилго нь тарилга, арьс салст цоолох ажилбарын халдварын эрсдлээс сэргийлэхэд оршино.

1.2 Тарилгын аюулгүй байдалд ажилбар хийх орчин, ажилбарт хэрэглэх эмнэлгийн хэрэгслийн ариун байдал, тарилгын уусмалын аюулгүй байдал, арьсны талбайн халдваргүйжүүлэлт, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хамруулан ойлгоно.

1.3 Энэхүү зааварт хамаарах тусламж, үйлчилгээ авч байгаа үйлчүүлэгчид эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар илрүүлэх өдөр тутмын тандалтад хамруулах шаардлагагүй.

1.4 Хатгалт хийсэн газарт улайх, хавдах, буглаа үүсэх зэрэг хэсэг газрын үрэвсэл, болон бусад халдварын тохиолдол илэрвэл бүртгэнэ. Халдварын сэргийлэлт, хяналтын алба, баг, хариуцсан мэргэжилтэнд мэдээлж хариу арга хэмжээ авч ажиллана. Дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.5 Эрүүл мэндийн байгууллага нь тарилга, хатгалттай холбоотой гарч болох эрсдлээс сэргийлж шаардлагагүй ажилбар, хатгалтаас татгалзах бодлогыг баримтлан ажиллана. Эмчилгээг тарилга байдлаар хэрэглэхээс илүүтэйгээр уух, түрхэх зэрэг аюулгүй аргыг сонгож хэрэглэнэ.

1.6 Захын судсанд уян зүү тавих ажилбарыг хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг үнэлж эмчийн заалтаар, халдвараас сэргийлэх үйл ажиллагааг баримтлан гүйцэтгэнэ. Уян зүү тавих нь хатгалтын тоог бууруулах зохистой арга биш юм.

### Хоёр. Ажилбар гүйцэтгэх орчинд тавигдах шаардлага

2.1 Энэхүү зааварт хамаарах ажилбар гүйцэтгэх өрөө нь (тарианы өрөө, дархлаажуулалтын өрөө, ажилбарын өрөө гэх мэт) гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн, байгалийн агааржуулалт, гэрэлтүүлэгтэй, зохиомол гэрэлтүүлэг нь эрүүл мэндийн байгууллагад мөрдөх орчны стандартын шаардлагыг хангасан байна.

2.2 Ажилбарын өрөөнд амьд болон хиймэл цэцэг, хивс, дрож гэх мэт тоос, шороо цуглуулах зүйлс байрлуулахгүй.

2.3 Тарилгыг үйлчлүүлэгчийн өрөөнд хийх тохиолдолд гарын эрүүл ахуй сахиж, тарилгад шаардлагатай хэрэгсэл, хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах нөхцлийг бүрдүүлсэн байна.



2.4 Тарианы өрөө нь тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах шүүгээ, хөргөгч, сандал, ширээ, ор, дуслын өлгүүр зэргээр хангагдсан байна. Мөн тарилгатай холбоотой аливаа эрсдэл гарсан үед хэрэглэх яаралтай тусламжийн эм, хэрэгслээр хангагдсан байна.

### **Гурав. Ажилбарын үед халдвараас сэргийлэх үйл ажиллагаа**

3.1. Ажилбар гүйцэтгэх эмнэлгийн мэргэжилтэн гарын эрүүл ахуй сахиж, үжилгүйжүүлэх дэглэм, ажилбар гүйцэтгэх үйлдлийн стандартыг мөрдөж ажиллана.

3.2. Эмчийн бичсэн заалтыг мөрдөж ажиллана. Ажилбар гүйцэтгэхээс өмнө эмийн бодисын бохирдол, тунадас үүссэн эсэх, тариур болон зүүний уутны битүүмжлэл, хүчинтэй хугацааг шалгана.

3.3. Тарилга хийхдээ нэг хүнд, нэг тариур зүүг, нэг удаагаар ашиглана. Хэрэглэсэн зүү, тариурыг давтан хэрэглэх, тариа найруулахад ашиглахыг хориглоно.

3.4. Судас, дусал тариа хийх, судас хатгаж сорьц цуглуулах зэрэг цус биологийн шингэнээр эрүүл мэндийн ажилтны гар бохирдох эрсдэлтэй үед нэг удаагийн цэвэр бээлий өмсөнө. Үйлчлүүлэгч хооронд бээлийг солино.

3.5. Булчин, арьсан дор, арьсан дотор хийх тарилгын үед бээлий өмсөх шаардлагагүй, үйлчлүүлэгч хооронд гарын эрүүл ахуйг сахина.

3.6. Тарианы туншилыг нээхийн өмнө задлах хэсгийг, мөн тарилгын уусмалыг найруулж бэлтгэхдээ зүү хатгах хэсгийг халдваргүйжүүлнэ.

3.7. Тариаг аль болох бага савалгаатай буюу нэг хүнд, нэг удаа хэрэглэх байдлаар сонгож хэрэглэнэ. Олон туншилтэй тариаг задласны дараа хадгалж хэрэглэхгүй. Хөвөнгөөр таглах, пластраар наах зэрэг нь бохирдлоос сэргийлж аюулгүй байдлыг хангахгүй.

3.8. Олон тунтай тариа найруулах зорилгоор ашиглаж байгаа уусмалыг хэрэглэхдээ:

3.8.1. Зүүг хатгаж орхихгүй;

3.8.2. Соруулах бүрдээ хатгах талбайг халдваргүйжүүлнэ, шинэ зүү, тариур ашиглана;

3.8.3. Эмийн бодистой тариураар найруулах уусмалаас соруулахыг хориглоно;

3.8.4. Аль болох хамгийн бага савалгааг сонгож хэрэглэнэ;

3.8.5. Найруулах уусмалыг задалсан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэнэ.

3.8.6. Задалснаас хойш 24 цагаас хэтрүүлэхгүй хэрэглэнэ. Найруулах уусмалын задалсан хугацаа 24 цагаас хэтэрсэн бол шууд устгана.

3.9. Арьсны талбайн халдваргүйжүүлэлтэд аль болох нэг удаагийн савалгаатай антисептик уусмал бүхий ариун самбайг (alcohol pad) ашиглана. Эсвэл 2 хувийн хлоргексидин, 70 хувийн спирт, 2.5-7.5 хувийн повидон иодын уусмалыг ариун хөвөн, самбайд шингээж ашиглана.

3.10. Хатгалт хийх талбайд халдваргүйжүүлэлт хийснээс хойш 30 секунд орчмын дараа зүүг хатгана.

3.11. Халдваргүйжүүлэлтийн дараа хатгалт хийх талбайг бохирдуулахаас сэргийлж гараа хүргэхгүй байх, бохирдуулах эрсдэлтэй бусад зүйлийг хүргэж болохгүй.

3.12. Зүүг бохирдуулахаас сэргийлж хатгалт хийх хүртэл хамгаалалтын тагтай байлгана. Судсаар тариа хийхэд судас олохгүй олон удаа хатгахад зүүг бохирдуулахаас сэргийлнэ. Бохирдох эрсдэл үүссэн бол зүүг солино.

3.13. Тарилга хийсний дараа зүү хатгасан талбайг бохирдлоос сэргийлж ариун самбайгаар дарж наалтаар тогтооно. Талбайн халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн хөвөнг тарилгын дараа ашиглаж болохгүй, ариун хөвөн ашиглана.

3.14. Ажилбарын явцад цус, биологийн шингэн, тарилгын уусмалаар тарианы тэргэнцэр, тавиур, тарилга бэлтгэх орчин бохирдох эрсдэлтэй тул цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийнэ.